78

# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 02 өдөр Дугаар 187 Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гар угаах, халдваргүйжүүлэх заавар"-ыг нэгдүгээр, "Эрүүл мэндийн байгууллагад давтан хэрэглэгддэг эмнэлгийн багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах заавар"-ыг хоёрдугаар, "Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх заавар"-ыг гуравдугаар, "Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар"-ыг дөрөвдүгээр, "Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар"-ыг тавдугаар, "Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэг удаагийн зориулалтаар хэрэглэх багаж, материалын жагсаалт"-ыг зургаадугаар, "Тусгаарлан сэргийлэлтийн заавар"-ыг долоодугаар, "Шүдний эмнэлгийн тусламж, үйлчилгээнд баримтлах халдварын эсрэг дэглэм"-ийг наймдугаар, "Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах, хэрэглэх заавар"-ыг есдүгээр, "Оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх дуран түүний дагалдах хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах заавар"-ыг аравдугаар, "Халдварын эрсдэл өндөртэй тасаг, нэгжүүдийн халдвараас сэргийлэх заавар"-ийг арваннэгдүгээр, "Халдварын сэргийлэлт, хяналтад микробиологийн лабораторийн гүйцэтгэх үүрэг"-ийг арванхоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалаар батлагдсан зааврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, зааврын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д, эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулж, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

САЙД Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

081594

99

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02-өдрийн 187 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# ГАР УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ ЗААВАР

## Нэг. Эрүүл мэндийн байгууллага, эмч, ажилтны үүрэг

1.1. Гарын ариун цэврийн байдал нь халдвараас урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг тул энэхүү зааврыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын эрүүл мэндийн ажилтнууд, дадлагажигч эмч, оюутан, үйлчлүүлэгчийн асран хамгаалагч, сахиурууд дагаж мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, нянгийн эсрэг үйлчилгээтэй шингэн саван, гар арчих нэг удаагийн хэрэглээний алчуур, спиртийн агууламж 70-80 хувьтай гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

1.3. Гар угаах дараалал, санамж, анхааруулга бүхий зурагт хуудсыг гарын угаалтуур бүрийн дэргэд байрлуулсан байна.

1.4. Мэс засал, төрөх, нярай, тарианы зэрэг ажилбарын өрөөнд мэдрэгчтэй эсвэл, хөл, тохойг ашиглан нээж хаах ажиллагаатай гарын угаагууртай байна.

1.5. Төвлөрсөн усан хангамжгүй газарт гоожуурт угаагуурыг ашиглаж болно. Гоожуур болон ус нөөцлөх савыг өдөр бүр цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

1.6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагад олон хэрэглээтэй даавуун алчуур, гар хатаагч сэнсийг ашиглахгүй.

1.7. Эрүүл мэндийн ажилтан тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ хумс ургуулах, будах, хиймэл хумс, бөгж, бугуйвч, бугуйн цаг зэргийг зүүхийг хориглоно.

1.8. Тархвар судлаач, халдвар хяналтын ажилтан нь эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаанд ажиглалтын судалгаа, үнэлгээг тасаг нэгж бүр улиралд 1-ээс доошгүй удаа хийж, мэдлэг олгох сургалтыг тасралтгүй явуулна.

## Хоёр. Гар угаах, халдваргүйжүүлэх арга

2.1. Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэхдээ дараах 5 мөчид гарыг угааж эсвэл халдваргүйжүүлнэ.

2.1.1. Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө болон хүрсний дараа

2.1.2. Шүлс, цус, цэр, шээс зэрэг биологийн шингэнд хүрэлцсэний дараа,

2.1.3. Ажилбар хийхийн өмнө

2.1.4. Үйлчлүүлэгчийн орчны эд зүйлд хүрсний дараа

2.2. Гар угааж, халдваргүйжүүлсний дараа орчны гадаргуу, хийх ажилбараас бусад зүйлд хүрч гараа бохирдуулахаас сэргийлнэ.

2.3. Дараахь 2 аргаар гарын ариун цэврийг сахина.

Арга 1. Нүдэнд харагдахуйц хиртэй байх, биологийн шингэнээр гар бохирлогдсон, бээлийг өмсөхийн өмнө болон тайлсны дараа, хоол идэхийн өмнө, ариун цэврийн өрөөнд орсон тохиолдол бүрт "**саван, ус ашиглан гар угаах**".

**Саван, ус ашиглан гар угаах дараалал:**

1) Гараа норгосны дараа хангалттай хэмжээний саван авна.
2) Саванг хөөсөртөл алгаа хооронд нь сайн үрнэ. Нэг гарын алгаар нөгөө гарын алгаа, ар талыг, хурууг, 2 гарын хурууны завсарыг үрж угаана.
3) Хурууг үеэр нугалж алган дотроо хурууг сайн үрнэ. Хоёр гарын хурууны үзүүрийг угаана.
4) Эрхий хуруу, хуруунуудыг гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр сайн үрнэ.
5) Гарын шууг нөгөө гараараа тойруулан барьж мушгих маягаар угаана.
6) Гараа усаар зайлж, нэг удаагийн цаасан алчууураар арчина. Крантыг цаасан алчууураар жийрэглэж хаана.
7) Гар угаахад нянгийн эсрэг үйлчилгээтэй шингэн саван ашиглах ба шингэн саванг дуусаагүй байхад нь нэмж хийхийг хориглоно. Хоосон савыг дахин дүүргэхийн өмнө сайтар цэвэрлэж, хатаасны дараа шингэн саванг савлана.

Арга 2. Нүдэнд харагдахуйц хиргүй, биологийн шингэнээр бохирдоогүй үед "**спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодис ашиглан гар хурууг халдваргүйжүүлэх**".

**Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн ашиглан гар, хурууг халдваргүйжүүлэх дараалал:**

1) Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодисоос алганы хонхорыг дүүртэл авна.
2) Гар угаах дарааллын дагуу 20-30 секундийн турш үрж халдваргүйжүүлнэ.
3) Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодисыг үйлчлүүлэгчийн өрөөний үүд, орны дэргэд зэрэг үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтан хэрэглэхэд ойр байхаар байрлуулна.
4) Хэрэглээний явцад спиртын агууламжийг тодорхойлж, шаардлага хангаж буй эсэхэд эм зүйч, эм найруулагч дотоодын хяналт тавина.
5) Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэгч бодисыг дуусаагүй байхад дээрээс нь нэмж хийхийг хориглоно. Бохирдлоос сэргийлж савыг сайтар цэвэрлэсний дараа бодисыг хийнэ.

**Мэс ажилбарын үеийн гар угаах, халдваргүйжүүлэх дараалал:**

1) Гар угаах хөөсрүүлэгч материал, саван, ариун алчуур, халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.
2) Мэс засалч, туслах эмч, сувилагчийн гар шархгүй, хумсгүй, будаггүй байна.
3) Гар угаах усны хэм, урсгал тохируулан тохойноос урагш хэсгийг сайтар норгосны дараа нэг удаагийн хэрэглээний савантай материал эсвэл савандаж гарын алга, ар тал, хуруунуудын завсар, хумс, бугуйнаас тохой хүртэл сайтар үрж 5-с доошгүй минутын турш угаана.
4) Цэвэр усаар булхуулж саванг бүрэн гүйцэт арилгасны дараа ариун алчууpаар арчиж хатаана.
5) Халдваргүйжүүлэх уусмалаар гарын алга, ар тал, хуруунуудын завсар, хумс, бугуй хэсгийг дарааллын дагуу үрж халдваргүйжүүлнэ.

## Гурав. Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодисыг бэлтгэх заавар

3.1. Дараах зааврын дагуу шаардагдах материал, нөхцлөөр хангагдсан эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага нь спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодисыг найруулж хэрэглэж болно.

3.2. Шаардлагатай материал:

3.2.1. Найруулах хэмжээнээс шалтгаалан 10, 50, 100 литрийн багтаамжтай шингэний түвшинг заах хэмжээстэй хуванцар эсвэл шилэн, зэвэрдэггүй гангаар хийгдсэн таглаатай сав.

3.2.2. Хутгуур (мод эсвэл хуванцар, металлаар хийгдсэн байна).

3.2.3. Хэмжээс бүхий цилиндр хэлбэртэй хувин эсвэл юүлүүр.

3.2.4. Эрэгдэж бөглөгддөг сайн бөглөөтэй 100 мл, 500 мл-ийн хуванцар эсвэл шилэн сав тус бүр 1 ширхэг

3.2.5. Этанолын концентрацийг хэмжигч

3.3. Спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодисыг 2 янзаар найруулна. Арга тус бүр өөр өөр бодисыг, өөр хэмжээтэй хэрэглэнэ.

| Арга | 10 л уусмал бэлтгэхэд Шаардагдах бодисын хэмжээ | Уусмалын эцсийн бүтэц |
|---|---|---|
| Найрлага 1 | Этанол 96% - 8333 мл | этанол 80% |
| | Глицерол 98% - 145 мл | глицерол 1,45% |
| | Гидроген пероксид 3% 417 мл | гидроген пероксид 0,125%, |
| Найрлага 2 | Изопропилийн спирт 99,8% - 7515 мл | Изопронолийн спирт 75% |
| | Гидроген пероксид 3% - 417 мл | гидроген пероксид 0,125% |
| | Глицерол 98% - 145 мл | глицерол 1,45% |

3.4. Найруулах арга:

1) Найрлагад орох спиртийг том шил эсвэл хуванцар савны хэмжээс хүртэл хийнэ.
2) Гидроген пероксидыг хэмжигч цилиндрээр хэмжин авч нэмж өгнө.
3) Глицеролыг хэмжигч цилиндр ашиглан нэмнэ. Глицерол их наалдамхай учир хэмжигч цилиндрийн ханан дахь үлдэгдлийг буцалсан ус эсвэл нэрмэл усаар зайлж дараа нь савандаа юүлнэ.
4) 10 литрийн хэмжээтэй савандаа 10 литр хүртэл нэрмэл эсвэл буцалсан хүйтэн ус нэмнэ.
5) Уусмалаа бэлдмэгц саваа аль болох хурдан хугацаанд эргэдэг эсвэл шингэн гоожихооргүй бөглөөгөөр бөглөнө.
6) Уусмалыг бүрэн холилдтол зайлах эсвэл холигч машин ашиглан сэгсэрч бүрэн найруулна.
7) Бэлдсэн уусмалаа хольсны дараа 500, 100 мл-ийн хуванцар савнуудад хуваж хийнэ.
8) Савласан бодисыг 72 цаг тавьж тогтворжилтыг хангасны дараа хэрэглэж эхэлнэ. Энэ нь спирт шил саванд байсан эмгэг төрөгчийг устгах хангалттай хугацаа юм.

## Дөрөв. Гарын ариун цэврийн сахилтын байдалд дотоодын хяналт, үнэлгээ хийх шалгуур хуудас

4.1. Эрүүл мэндийн ажилтныг өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэх явцад нь хавсралт дахь хавсралт дахь "Гарын ариун цэврийн сахилтыг үнэлэх ажиглалтын маягт"-ын дагуу ажиглах байдлаар гарын ариун цэвэр сахих дадлыг тархвар судлаач, халдвар хяналтын ажилтан, тасгийн ахлах сувилагч судална.

# ГАРЫН АРИУН ЦЭВРИЙН САХИЛТЫГ ҮНЭЛЭХ АЖИГЛАГЧИЙН МАЯГТ

Эмнэлэг.....

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ажиглагч (эхний үсэг) | □□□ | | | | |
| Огноо (е,с,о) | □□ □□ □□ □□ | Ye шат № | □□□ | Тасаг/хэлтэс | □□□□□□□□□ |
| Эхлэх/дуусах (ц,м) | □□ □□ □□ □□ | Бүлэг ажиглалт№ | □□□ | Үйлчилгээ | □□□□□□□□□ |
| Бүлэг ажиглалтын хугацаа (мин) | □□ | Маягт № | □□□ | Тасаг/өрөө | □□□□□□□□□ |

| | | | |
|---|---|---|---|
| Мэргэжил □□□□□□ | Мэргэжил □□□□□□ | Мэргэжил □□□□□□ | Мэргэжил □□□□□□ |
| Код □□□ | Код □□□ | Код □□□ | Код □□□ |
| № □□□□□□ | № □□□□□□ | № □□□□□□ | № □□□□□□ |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 1 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 2 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 3 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 4 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 5 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 6 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 7 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 1 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 2 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 3 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 4 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 5 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 6 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 7 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 1 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 2 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 3 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 4 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 5 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 6 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 7 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 1 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 2 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 3 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 4 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 5 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 6 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 7 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 1 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 2 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 3 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 4 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 5 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 6 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

| Бо | Заалт | Үйлдэл |
|---|---|---|
| 7 | □ өвч өм | |
| | □ ар өм | □ үр |
| | □ шин да | □ уг |
| | □ өвч да | О үгүй |
| | □ орч да | |

4.2. Ажиглалт хийх аргачлал:

4.2.1. Ажиглагч нь гарын ариун цэврийг сахих "5 мөч", ямар үед гар угаах, халдваргүйжүүлэх, түүний техник, дарааллын талаар мэддэг, эрүүл мэндийн ажилтны янз бүрийн үйл ажиллагааны үед эдгээр мөчийг ялган таних, тодорхойлох чадвартай байна.

4.2.2. Ажиглагчийн маягт нь 4 босоо баганатай ба судалгаанд хамрагдаж байгаа хүн тус бүрийг тусгай баганад тэмдэглэнэ. Жишээлбэл: нэг ажиглалтын үед сувилагч, эх баригч 2 цуг ажиллаж байвал тэдний үйл ажиллагаа өөр өөр баганад тэмдэглэгдэнэ.

4.2.3. Ажиглагч нэгэн зэрэг 3-аас илүү хүнд ажиглалт хийхгүй.

4.2.4. Ажиглалтын маягтын ажиглалт тэмдэглэх хэсгийг дараах байдлаар ойлгоно.

| Бо<br>(Боломж) | Заалт<br>(Гарын эрүүл ахуй сахих заалт) | Үйлдэл<br>(Гүйцэтгэл) |
|---|---|---|
| 1 | □өвч.өм (Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө) | □ үр (ССГХБ-р халдваргүйжүүлсэн)<br>□ уг(Гараа угаасан)<br>О Үгүй (гарын эрүүл ахуй сахих ямар ч үйлдэл хийгээгүй) |
| | □ар.өм (Ариун ажилбарын өмнө) | |
| | □шин.да (Биеийн шингэнтэй хүрсний дараа) | |
| | □өвч.да (Үйлчлүүлэгчид хүрсний дараа) | |
| | □орч.да (Орчны эд зүйлд хүрсний дараа) | |

- **Боломж** - Гарын ариун цэвэр сахих зайлшгүй заалт гарч байна гэсэн үг. Боломж бүр үйлдэлтэй зохицож байх ёстой. Ажиглалтын явцад нэг дор гарын ариун цэвэр сахих хэд хэдэн заалт гарч болно. Боломж нь тухайн үйлдлийг бүртгэх нэгж болох бөгөөд заалт нь нэг эсвэл олон байхаас үл хамааран гарын ариун цэврийг сахих хэрэгцээ байгааг тодорхойлно.

- **Заалт** – Эрүүл мэндийн ажилтаны гарын ариун цэвэр сахих 5 мөч. Жишээлбэл: Таны ажиглаж байгаа сувилагч үйлчлүүлэгчийн биеийн шингэнд хүрсэн бол гарын ариун цэвэр сахих заалт гарч байна гэж ойлгон "□шин.да "гэсэн хэсэгт тэмдэглэгээ хийнэ. Сувилагч биеийн шингэнд хүрсний дараа гараа савандаж угаасан бол үйлдэл гэсэн хэсгийн "□ уг" гэсэн хэсэгт тэмдэглэнэ. Гар угаах үйлдэл хийгээгүй эсвэл спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэгч ашигласан бол буруу үйлдэл (биеийн шингэнд хүрсэн бол гар савандаж угаана) гэж үзэн "О Үгүй" гэсэн хэсэгт тэмдэглэгээ хийнэ.

- Нэг хүснэгтэд нэг үйлдлийг тэмдэглэнэ. Таны ажиглаж байгаа сувилагч дараагийн үйлчлүүлэгчид тариа хийх болоход гарын ариун цэвэр сахих дахин боломж гарч байна гэж ойлгон дараагийн мөрөнд шилжиж тэмдэглэгээг дээрхийн адил хийнэ.

- Гарын ариун цэвэр сахисан үйлдэл болон боломжийн хоорондын харьцаагаар эрүүл мэндийн ажилтны гарын ариун цэврийг сахих түвшин илэрхийлэгдэнэ. Жишээлбэл: Сувилагчийг 30 минут ажиглахад түүнд гарын ариун цэвэр сахих 18 боломж

гарсан, үүнээс гар угаах, халдваргүйжүүлэх зөв үйлдэл 7 хийсэн гэж үзвэл тухайн сувилагчийн гарын ариун цэвэр сахих түвшин 38,8% байна гэж үзнэ.

- Гарын ариун цэвэр сахих түвшинг мэргэжлийн төрлөөр, заалт тус бүрээр тооцоолж бас болно. Тухайлбал гарын ариун цэвэр сахих 5 заалтын аль заалт дээр эмнэлгийн ажилтан гар угааж, халдваргүйжүүлж байна гэдгийг ажиглагчийн маягт дээрээс тооцоолж гаргана. Заалт бүрээр гаргасан гарын ариун цэвэр сахих түвшингийн ач холбогдол нь эрүүл мэндийн ажилтаны мэдлэг, хандлагыг өөрчлөх сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход тусална.
- Ажиглалт хийх явцдаа үйлчлүүлэгчид хийгдэж байгаа ажилбарыг тасалдуулж болохгүй.

4.3. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах, халдваргүйжүүлэх нөхцөл бүрдүүлсэн эсэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг (1) Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал, (2) Гарын эрүүл ахуй сахилтыг сайжруулах чиглэлээр хийж буй үйл ажиллагаа гэсэн үнэлгээний хуудсын дагуу үнэлнэ.

**Нэг. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал**

| Д/д | Үнэлгээний асуумж | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| 1.1 | Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэгч хир хүртээмжтэй вэ? | Байхгүй эсвэл байгаа боловч спиртын агууламж нь баталгаажаагүй, арьс цочроож гэмтээдэг | 0 |
| | | Зарим нэг тасагт хүрэлцээтэй эсвэл тогтмол хангадаггүй | 1 |
| | | Байгууллагын хэмжээнд тогтмол хангадаг | 2 |
| 1.2 | Тусламж үйлчилгээний цэг бүрт спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэгч байгаа | Ихэнх тасгийн тусламж, үйлчилгээний цэгт байрлуулсан | 1 |
| | | Эмнэлгийн хэмжээнд тусламж үйлчилгээний бүх цэгт байрлуулсан | 2 |
| 1.3 | Гар угаах угаалтуур орны харьцаа | 1:10 – аас бага | 0 |
| | | Бүх тасагт хамгийн багадаа 1:10 | 1 |
| | | Эмнэлгийн хэмжээнд хамгийн багадаа 1:10, тусгаарлах өрөө, эрчимт эмчилгээний тасагт 1:1 | 2 |
| 1.4 | Мэдрэгчтэй, хөл, тохойгоор ажилладаг угаалтууртай | Байхгүй | 0 |
| | | Зарим тасаг, ажилбарын өрөөнд байдаг | 1 |
| | | Эмнэлгийн хэмжээнд бүх угаалтуур | 2 |
| 1.5 | Гар угаах ус нь шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг уу? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.6 | Гар угаахад нянгийн эсрэг шингэн саван ашигладаг уу? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 1.7 | Гарын угаалтуур бүрийн дэргэд нэг удаагийн хэрэглээний алчуур бий юу? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 1.8 | Шингэн саван, ССГХ нь зориулалтын савтай, сав нь цэвэр үү? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| | Нийлбэр дүн | | /16 |

**Хоёр. Гарын эрүүл ахуй сахилтыг сайжруулах чиглэлээр хийж буй үйл ажиллагаа**

| Д/д | Үнэлгээний асуумж | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| 2.1 | Гарын ариун цэврийн талаар эмч, эмнэлгийн ажилтанд сургалт хэр давтамжтай хийдэг вэ? | Хийдэггүй | 0 |
| | | Жилд нэг удаа | 1 |
| | | Жилд 3-аас доошгүй удаа хийдэг, шинэ ажилтнуудыг сургалтад хамруулдаг | 2 |
| 2.2 | Байгууллагын дотоод журам эсвэл халдвараас сэргийлэх журамд эмч, эмнэлгийн ажилтныг гар угаах, халдваргүйжүүлэх сургалтад хамруулах талаар тусгасан уу? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2.3 | Халдвар хяналтын сургагч багш болон ажилтаны сургалтад хамрагдсан, ур чадвар бүхий мэргэжилтэн сургалтыг хөтөлбөрийн дагуу хийдэг үү? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2.4 | Гарын ариун цэвэр сахилтын байдалд ажиглалтын судалгааг хэр давтамжтай хийдэг вэ? | Хийдэггүй | 0 |
| | | Жилд 1 удаа | 1 |
| | | Улирал бүр түүнээс олон удаа | 2 |
| 2.5. | Ажиглалтын судалгаагаар эмнэлгийн гарын ариун цэвэр сахилтын түвшин хэд байсан бэ? | 30%-иас бага | 0 |
| | | 31 – 50% | 1 |
| | | 51-80% | 2 |
| | | 80%-иас дээш | 3 |
| 2.6. | ССГХ, саван, нэг удаагийн алчуурны хэрэглээ, хангалт, хүрэлцээний байдалд дотоодын хяналт үнэлгээ хийдэг үү? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2.7. | Жилд 1-ээс доошгүй удаа эмнэлгийн ажилтнуудын гарын ариун цэврийн талаар мэдлэгийн түвшинг үнэлдэг үү? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2.8. | Жилд 1-ээс доошгүй удаа эмнэлгийн ажилтнуудын гар угаах, халдваргүйтгэх зөв техникийг үнэлдэг үү? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.9. | Өдөрт зарцуулагдаж буй ССГХ-ийн хэмжээг тооцож гаргадаг уу? | Тийм | 2 |
| | | Үгүй эсвэл хэмжиж байгаагүй | 0 |
| 2.10. | Гарын эрүүл ахуй сахихыг анхааруулсан санамж, зурагт хуудас байдаг уу? | Байхгүй | 0 |
| | | Зарим тасаг, нэгжүүдэд | 1 |
| | | Бүх тасаг, нэгжүүдэд байршуулсан | 2 |
| 2.11 | Гар угаах, халдваргүйжүүлэх зөв техникийг харуулсан санамж, зурагт хуудас байдаг уу? | Байхгүй | 0 |
| | | Зарим тасаг, нэгжүүдэд | 1 |
| | | Бүх тасаг, нэгжүүдэд байршуулсан | 2 |
| 2.12 | ССГХ-ийн зөв хэрэглээний талаар санамж, анхааруулга байдаг уу? | Байхгүй | 0 |
| | | Зарим тасаг, нэгжүүдэд | 1 |
| | | Бүх тасаг, нэгжүүдэд байршуулсан | 2 |
| 2.13 | ЭМ-ийн ажилтны гарын ариун цэвэр сахих өдрийг тэмдэглэн ямар нэгэн үйл ажиллагааг зохион байгуулдаг уу? | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2.14 | Гарын ариун цэвэр сахих талаар үйлчлүүлэгч нарт мэдээлэл хийдэг үү? | Тийм | 1 |
| | | Үгүй | 0 |
| **Хоёр дах хэсгийн нийлбэр оноо** | | | **... /28** |
| **Нийлбэр оноо** | | | **.../44** |

4.4. Нэг ба хоёр дахь хэсгийн нийлбэр дүнгээр үнэлнэ.

4.5. Тухайн байгууллагын нийлбэр оноо 0-12 байвал хангалтгүй, 12-24 бол дундаас доогуур, 24-30 дундаж, 30-38 дунджаас дээгүүр, 38-44 байвал хангалттай түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ДАВТАН ХЭРЭГЛЭГДДЭГ ЭМНЭЛГИЙН БАГАЖ, ХЭРЭГСЛИЙГ УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, АРИУТГАХ ЗААВАР

## Нэг. Ерөнхий зүйл

1. Эрүүл мэндийн байгууллагад давтан хэрэглэгддэг эмнэлгийн багаж хэрэгслийг (цаашид багаж хэрэгсэл гэх) угаах, ариутгах, халдваргүйжүүлэх энэхүү зааварт байгаа нэр томъёог дараахь байдлаар ойлгоно.

1.1. “багаж хэрэгслийг угаах” - багаж, хэрэгслийг цус, биеийн шингэн, бусад органик бохирдлоос цэвэрлэх,

1.2. “халдваргүйжүүлэх” - багаж хэрэгсэл дээр байгаа өвчин үүсгэгч бичил биетийг өвчин үүсгэхгүй хэмжээнд хүртэл цөөрүүлэх, устгах,

1.3. “Ангилах”- багаж, хэрэгслийг эрсдлийн байдлаас шалтгаалан өндөр, дунд, бага эрсдэлтэй гэж ялгах,

1.4. “Ариутгах” - хими, физикийн аргаар багаж материал дээр байгаа бүх төрлийн бичил биетүүдийг бүрэн устгах,

1.5. “Засварлах”- хугарсан, эвдэрсэн, зэвэрсэн багаж, хэрэгслийг сэлбэж засах, гацсан багажийг тослох,

1.6. Савлах” - цэвэр багаж, хэрэгслийг зориулалтын даавуу, цаасанд ороох, боох, вакуум цаасанд хийж наах,

1.7. “Техникийн хяналт” - тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, манометр, хавхлагууд, жийрэг, таг дарагч, боолт нь бүрэн ажиллагаатай эсэхийг хянах,

1.8. “Химийн хяналт” – Өнгө хувирагч цаасны өнгө хувиралт болон хүхэр, аспирин, амидопирин зэрэг химийн бодисын хайлах байдлаар хянах,

1.9. “Биологийн хяналт” - халуунд тэсвэртэй спортой нянгийн хяналт /уурын болон этилен оксидын автоклавт хэрэглэгдэх/

2. Энэхүү зааврыг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчийн зөөлөн эд, ясанд нэвтэрдэг, арьс, салстыг гэмтээдэг, цус, био шингэнд хүрэлцдэг давтан хэрэглэгддэг багаж, хэрэгслийн угаалга, халдваргүйжүүлэлт, ариутгалын үйл ажиллагаанд мөрдөнө.

3. Багаж, хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ багаж, хэрэгслийн хэрэглэх зориулалт, материалын халуун тэсвэрлэх чанар, хэлбэр, хэмжээ, бохирдолтын байдал, нянгийн гадна орчинд тэсвэрлэх чадвар зэргийг харгалзан улсын бүртгэлд бүртгэгдсэн химийн бодисуудыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

## Хоёр. Багаж хэрэгслийн ангилал

Багаж хэрэгслийг эрсдлийн байдлаас шалтгаалан 3 ангилна.

***Өндөр эрсдэлтэй*** - судас дотуур, эрхтэн түүний хөндий, эд рүү нэвтрэн орох багаж, хэрэгсэл

***Дунд эрсдэлтэй*** - салст бүрхэвч, гэмтэлтэй арьс салсттай хүрэлцдэг, оношлогооны дуран гэх мэт багаж хэрэгсэл

***Бага эрсдэлтэй*** – гэмтээгүй арьс салсттай хүрэлцдэг, хүний бие, арьс салстад хүрдэггүй багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж

## Гурав. Ариутгалын тасаг, хэсэгт тавигдах шаардлага

3.1. Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, 50-оос дээш ор бүхий сувилал, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд төвлөрсөн ариутгалын тасаг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмнэлэг болон дээр дурьдсанаас бусад сувилал, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд төвлөрсөн ариутгалын хэсэг ажиллуулна.

3.2. Төвлөрсөн ариутгалын хэсгийг зохион байгуулах боломжгүй эрүүл мэндийн байгууллага нь энэхүү зааврын шаардлагыг хангасан мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

3.3. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэг нь эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл, материалыг тасаг, нэгжүүдээс хүлээн авах, ангилах, угаах, халдваргүйжүүлэх, засварлах, савлах, ариутгах, хадгалах, түгээх, тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.4. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсгийн өрөөнүүд нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр, ариун гэсэн 3 бүсэд хуваагдах бөгөөд бохир багаж, хэрэгсэл, материалыг хүлээн авах, угаалга, халдваргүйжүүлэлт хийх, хатаах, засварлах, боох, савлах, ариутгах, ариун багаж, материал хадгалах зэрэг зориулалтын 5–8 өрөөтэй, төвлөрсөн ариутгалын хэсэг 3-5 өрөөтэй, цэвэр, бохир усны шугамд холбогдсон байна.

3.5. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэг нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, ариун хэсгээс бохир хэсэг руу чиглэсэн төвлөрсөн болон хэсгийн агааржуулалтын системтэй, бохир хэсгийн өрөөг агаарын сөрөг даралттай, цэвэр болон ариун өрөөг агаарын эерэг даралттай байхаар зохион байгуулсан байна.

3.6. Ариутгалын тасаг, хэсгийн өрөөний шал нь резинэн хулдаас, хана нь тосон будаг эсвэл шаазан хавтан, таазыг эмульсдсэн байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

3.7. Хийн болон уурын автоклав, хуурай халуунаар ариутгах шүүгээ, усны шүүлтүүр, угаагч машин, агааржуулалтын систем зэргийг суурилуулахдаа мэргэжлийн болон галын аюултай тэмцэх байгууллагаас зөвлөгөө, зөвшөөрөл авсан байна. Автоклавыг 1-2 давхарт байрлуулна.

3.8. Ариутгалын тасаг, хэсэгт албан ажил, сургалт, дадлагаар ажиллах ажилтан, мэргэжилтэн, оюутан нь хамгаалах хувцас хэрэгслийг иж бүрнээр нь өмсөж, ариун хэсгээс цэвэр, бохир хэсэг рүү нэвтэрнэ.

3.9. Тасаг, нэгжүүдээс багаж, хэрэгслийг хүлээж авах, түгээх цагийн хуваарьтай байна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд цагийн хуваарийг харгалзахгүй.

3.10. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгахад шаардлагатай дараах багаж, тоног төхөөрөмжтэй байна.

3.10.1. Автоклав (2 хаалгатай)
3.10.2. Хийн ариутгалын автоклав
3.10.3. Хуурай халууны шүүгээ
3.10.4. Хатаах шүүгээ
3.10.5. Угаагч машин (2 хаалгатай)
3.10.6. Ус нэрэгч, шүүгч аппарат, ус хэмжигч
3.10.7. Томруулдаг шил
3.10.8. Уут наагч машин
3.10.9. Багаж боох зориулалтын даавуу ба цаас, вакуум цаасан уут
3.10.10. Вакуум цаасан уут хэрчигч
3.10.11. Угаалга хийх зориулалттай нержээр хийгдсэн тосгуур
3.10.12. Усан болон хийн буу
3.10.13. Химийн хяналтын өнгө хувирагч цаас
3.10.14. Халуунд тэсвэртэй нянгийн тест, термостат
3.10.15. Ширээ, сандал, тавиур, компьютер, хэвлэгч, олшруулагч
3.10.16. Угаалга хийх сав, сэтгүүр
3.10.17. Халдваргүйжүүлэгч бодис
3.10.18. Багаж тослох тос
3.10.19. 96 хувийн спирт
3.10.20. Цаг
3.10.21. Анхан шатны бүртгэлийн маягтууд
3.10.22. Гар угаах, халдваргүйжүүлэх хэрэгсэл

3.11. Ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, ажиллах зааврыг байрлуулсан техник ашиглалтын дэвтрийг байнга хөтөлнө.

3.12. Багаж тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, тохиргоо хийж, бүртгэл хөтөлж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг гэрээний дагуу ханган нийлүүлэгч байгууллага болон инженер техникийн алба гүйцэтгэнэ.

3.13. Ариутгах үйл явцын аль нэг хэсэгт гэмтэл гарсан тохиолдолд тухайн гэмтсэн аппаратаар ариутгасан бүх багаж, материалыг хүлээн авсан тасаг, нэгжүүдээс нь эргүүлэн татаж, хэвийн ажиллагаатай аппаратад дахин ариутгана.

## Дөрөв. Ариутгалын тасаг, хэсгийн ажилтны үүрэг

4.1. Ариутгалын тасаг, хэсэгт ажиллах ажилтан нь вируст гепатит В-ийн дархлаажуулалтад хамрагдаж, жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

4.2. Ариутгалын тасаг, хэсэгт ажиллах эмнэлгийн мэргэжилтэн нь халдварын сэргийлэлт, хяналт, халдваргүйтгэл, ариутгал, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн чиглэлээр сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна.

4.3. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана.

4.4. Ариутгалын тасаг, хэсэгт тамхи татах, хоол хүнсний зүйл хадгалах, идэхийг хориглоно.

4.5. Төвлөрсөн ариутгалын цэвэр болон ариун хэсэгт ажиллах ажилтан нь халад буюу өмд, цамц, малгай, амны хаалт, гутал хэрэглэнэ. Бохир хэсэг рүү нэвтрэхийг хориглоно.

4.6. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсгийн бохир хэсэгт ажиллах ажилтан нь ус нэвтэрдэггүй халад, хормогч, ханцуйвчийг нэмэлтээр өмсөнө. Бохир хэсэгт ажилласан хувцастай бусад өрөөгөөр сэлгүүцэхийг хориглоно. Бохир хэсгээс гарахад хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж, гарын эрүүл ахуйг сахина.

4.7. Химийн бодис арьс, салстад үсэрсэн, санамсаргүй уусан тохиолдолд цаг алдалгүй хордолтоос сэргийлж саармагжуулах арга хэмжээг авна. Бодис хүрсэн хэсгийг савантай усаар угаах, ам, хамрыг ус буюу хор саармагжуулах уусмалаар зайлна. Боломжтой бол шүршүүрт орох хэрэгтэй.

4.8. Нунтаг бодистой харьцахдаа бургихаас сэргийлж, амьсгалын замыг хамгаалах үүднээс тусгай шүүлтүүр бүхий РУ-60М, РПГ-67 гэх мэт зориулалтын амны хаалтыг хэрэглэнэ.

4.9. Биеийн хүрэлцэх хэсэг, арьс салстанд химийн бодис хүрэхээс сэргийлж халат, бээлий (нунтаг тоос маягийн бодистой харьцахдаа хөвөн даавуун, харин шингэн бодистой харьцахдаа резинэн бээлий) ханцуйвч өмсөнө. Нүдний салстыг цочрохоос хамгаалж харьцаж буй бодисын онцлогоос хамаарч ПО-2, ПО-3, энгийн, тоосны эсрэг нүдний шилийг сонгоно.

4.10. Халдваргүйжүүлэх уусмал, бодистой харьцаж ажиллахдаа 40-50 минут тутамд 10-15 минут завсарлан цэвэр агаар амьсгалах бөгөөд ажил дууссаны дараа амаа усаар зайлж, гар нүүр болон биеийн ил гарсан хэсгийг (бодис хүрсэн байж болзошгүй) савантай усаар угааж зайлна.

4.11. Ажлын дараа зориулалтын хувцсыг дараах зааврын дагуу тайлна. Үүнд: Бээлийг гарнаасаа салгалгүй 5%-ийн содын уусмалд халдваргүйтгэж, дараа нь цэвэр усаар угааж зайлна. Хамгаалалтын нүдний шил, маск, гутал, халат, углааш зэргийг тайлна. Нүдний шил, респираторыг 5%-ийн кальцижуулсан содын уусмалд булхуулж, савантай усаар угааж зайлна. Бээлийгээ тайлж, гараа савантай усаар угааж, гарын арьсыг зөөлрүүлэх тос түрхэнэ. Гар хуурайшиж хагарсан, шархалсан үед ажиллаж болохгүй.

4.12. Ариутгал, халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

4.13. Багаж хэрэгслийг уусмалд бүрэн дүрж, ялангуяа гуурс, хөндий, суваг бүхий багажийг агаар үлдээхээргүйгээр уусмалаар бүрэн дүүргэж тавина.

4.14. Багаж материалыг халдваргүйжүүлэхэд халдваргүйтгэлийн хугацааг чанд баримтлан сэрүүлэгтэй цаг хэрэглэх бөгөөд хугацаа харснаас хойш нэмж багаж хийхийг хориглоно.

4.15. Халдваргүйжүүлж дууссан багаж хэрэгслийг уусмалаас гаргахдаа бээлийтэй гараар, хавчаараар эсвэл шүүлтүүр бүхий саваар авах нь үзүүртэй, иртэй зүйлд гараа гэмтээх болон уусмал асгарахаас сэргийлнэ.

4.16. Уусмал бохирдсон тохиолдол бүрт үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу сольж хэрэглэнэ.

**Тав. Багаж, хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах, хадгалах тээвэрлэх, түгээх явц**

| **А. Багаж, хэрэгслийг хэрэглэсэн тухайн тасаг, нэгжид** | |
|---|---|
| **Бохирлогдсон багаж хэрэгсэл** | Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэгтэй бол бохир багаж хэрэгслийг тасаг, нэгжид угааж, халдваргүйжүүлэхгүйгээр шууд зориулалтын битүү зөөврийн саванд хийж ариутгалын тасаг, хэсэгт хүргэнэ.<br>Төвлөрсөн ариутгалын хэсэггүй бол тухайн тасаг, нэгжид бохир багаж хэрэгслийн анхны халдваргүйжүүлэлтийг хийсний дараа гэрээт байгууллагад зориулалтын битүү зөөврийн саванд хийж, тээвэрлэн хүргэнэ. |
| **Б. Бохирын бүсэд** | |
| **Бохирлогдсон багаж хэрэгслийг хүлээн авах** | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн, ариун байдал нь алдагдсан, хадгалах хугацаа хэтэрсэн багаж, хэрэгсэл, материалыг зориулалтын бикс, контейнер, тэргэнцрээр зөөвөрлөн төвлөрсөн ариутгалын тасаг, хэсгийн бохир багаж, материал хүлээн авах хэсэгт “Маягт 1”-ын дагуу бүртгэн хүлээж авна. |
| **Бохир багаж хэрэгслийг угаах** | Багажийг зориулалтын угаалгын машин, хэт авиан цэвэрлэгч ашиглан аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн угаана.<br>Зориулалтын угаах машин, цэвэрлэгч байхгүй тохиолдолд 40-60 хэмийн бүлээн усаар халдваргүйтгэгч, угаагч уусмалын холимогийг бэлтгэн зориулалтын тосгуурт зөөлөн үстэй сойзоор үрж угаана.<br>Гуурс зэрэг хөндийтэй багаж, хэрэгслийн хөндийг усан буу ашиглан өндөр даралттай усаар шүршин угааж, халдваргүйжүүлнэ. |
| **Багаж хэрэгслийг хатаах** | Халдваргүйтгэгч бодисын үлдэгдлийг шүүсэн болон нэрмэл усаар сайтар зайлж, арилгаад хатаах шүүгээнд зохих хэмд хатаана. Хатаах шүүгээ байхгүй тохиолдолд ариун цаас, даавуугаар нэг бүрчлэн арчиж хатаана.<br>Гуурс мэтийн хөндийтэй багаж, хэрэгслийг нэрмэл усаар зайлж өндөр даралттай хийгээр үлээж хатаана. |

| | |
|---|---|
| **В. Цэвэр бүсэд** | |
| **Угаагдсан багаж хэрэгслийг шалгах, ангилан ялгах тослох, засварлах, бэлтгэх** | Багажийг хэмжээ, төрөл, зориулалтаар нь ялгана.<br>Бохирдол байгаа эсэхийг томруулдаг шилээр нэг бүрчлэн нягтлан шалгана.<br>Тослох болон бусад засвар үйлчилгээг хийнэ.<br>Дахин ашиглах боломжгүй бол нэгдсэн бүртгэлээс хасуулахаар тухайн тасаг, нэгжид илгээнэ.<br>Мэс засалд хэрэглэгдэх даавуу, халад, малгай, боолтын материалыг эвхэж бэлтгэнэ. |
| **Угаасан багаж хэрэгслийг боох, савлах** | Цэвэр, хуурай багаж, хэрэгслүүдийг цэвэр тавиур дээр тавьж, 1 хүнд ногдохоор буюу тухайн багаж хэрэгслийн хэрэглэгдэх байдлаар зориулалтын даавуу, цаасанд боох эсвэл вакумжуулсан цаасан уутанд багцалж савлана.<br>Мэс засалд хэрэглэгдэх даавуу, халад, малгай, боолтын материал зэргийг хэрэглэгдэх байдлаар зориулалтын даавуу, цаасанд боох эсвэл вакумжуулсан цаасан уутанд багцалж савлана. |
| | Савлаж бэлтгэсэн баглаа бүрт автоклавын хяналтын индикаторыг байрлуулж, ариутгасан огноо, хүчинтэй хугацаа, ариутгалын ажилтны код, багаж хэрэгслийн нэр, тоо тэмдэглэсэн шошго (бар код)-г наана. |
| **Ариутгах** | Савласан багаж, хэрэгслийг ариутгалын аппарат (өндөр даралтын уур, хуурай халууны агаар, хийн ариутгалын гэх мэт)- д хийж, аюулгүй ажиллагааны зааврын дагуу даралт тохируулан ариутгана.<br>Өндөр даралттай уур, хуурай халуун болон хийн аргаар ариутгаж болохгүй багаж хэрэгслийг химийн аргаар (хүйтэн) ариутгана.<br>Ариутгасан талаар “Маягт 2”- ыг хөтөлнө |
| **Г.Ариун бүсэд** | |
| **Ариун багаж хэрэгслийг хадгалах, хянах** | Ариутгасан багаж хэрэгслийг тэргэнцэр дээр түр хөргөсний дараа хадгалах хэсгийн зориулалтын тавиур дээр байрлуулна. |
| | Өнгө хувиргагч цаасны хувиралтаар ариутгагдсан эсэхийг хянана. |
| | Ариутгасан багаж материалын бүрэн бүтэн байдал алдагдаагүй тохиолдолд даавуун боодолтой бол 7 хоног, цаасан боодолтой бол 14 хоног ариун материал хадгалах зориулалтын шүүгээнд хадгална. |
| **Ариун багаж хэрэгслийг түгээх** | Тасаг нэгжүүдэд түгээсэн тэмдэглэлийг маягт 3-ийн дагуу хөтөлнө.<br>Зориулалтын бикс, тэргэнцрээр зөөвөрлөнө. |

**Халдварын эрсдэл багатай багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх, цэвэрлэх:**

1. Халдварын эрсдэл багатай гэмтээгүй арьс салсттай хүрэлцдэг багаж, хэрэгслийг (бумба, ванн) халдваргүйжүүлэх бодистой бүлээн усанд сайтар угаасны дараа цэвэр усаар зайлж хатаана.

2. Чагнуур, халууны шил, даралтны аппарат, чанд авиа болон физик эмчилгээний тоног төхөөрөмжийн датчик зэргийг 70 хувийн спирт болон зориулалтын халдваргүйжүүлэх бодисоор цэвэрлэж арчина.

**Анхаарах зүйл:**

1. Баглаа, боодол нь урагдаж, цоорсон, баглааны боолтыг задлах оролдлого хийгдсэн, чийгтэй, бохирлогдсон (даавуу ба цаас халтартсан), индикаторын өнгө гүйцэт хувираагүй тохиолдолд хангалттай ариутгал хийгдээгүй гэж үзэн дахин угаах, халдваргүйжүүлэх, савлах, ариутгах үйл ажиллагааг хийнэ.

2. Тасаг, нэгжид хэрэглэгдээгүй болон ариун байдал алдагдсан тохиолдолд дахин угааж, халдваргүйтгэн, савлаж, ариутгана.

**Зургаа. Төвлөрсөн ариутгалын тасаг, хэсгийн чанарын хяналт, үнэлгээ**

6.1. Эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэсэн багаж, хэрэгсэл, материалын ариутгалын чанарыг техник, хими, биологийн аргаар хянана.

6.2. Техникийн хяналтаар тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, манометр, хавхлагууд, жийрэг, таг дарагч, боолт нь бүрэн ажиллагаатай эсэхийг тус тус шалгана.

6.3. Химийн хяналтанд өнгө хувирагч цаас хэрэглэх бөгөөд өнгө нь өөрийн заасан хэмжээнд хувирсан тохиолдолд ариутгалын үйл ажиллагааг хэвийн явагдсан гэж тооцно.

6.4. Уурын нэвчилт, агаарын шилжилт хөдөлгөөнийг “Bowie Disk” тест ашиглан ариутгах төхөөрөмжийн дотор байрлуулан сард 1-2 удаа хянана.

6.5. Биологийн хяналт нь халуунд тэсвэртэй **G. Steromaphilus** /уурын ариутгалд/ **B. Steromaphilus** /этилен оксид/ нянгийн өсгөвөр, халуун тогтоогуурыг шаарддаг бөгөөд ердийн болон түргэвчилсэн байдлаар хянана. Уурын ариутгалд хэрэглэгдсэн ердийн хяналтын /хуруу шилтэй/ нянгийн өсгөврийг 56 хэмийн халуун тогтоогуурт 48 цаг, түргэвчилсэн хяналтын /өнгө хувирагч цаас/ өсгөврийг 1-3 цаг, этилен оксидын ариутгалд хэрэглэгдсэн ердийн хяналтын нянгийн өсгөврийг 37 хэмийн халуун тогтоогуурт 48 цаг, түргэвчилсэн хяналтын өсгөврийг 4 цаг байлгаж хянана. Энэ хяналтыг улиралд 1 удаа хийнэ.

6.6. Ариутгагдсан багаж, материалын ариун чанар шалгах, ариутгалын тасаг, хэсгийн эд зүйлсээс арчдас, агаараас сорьц авч нян судлалын лабораторит сард 1 удаа шинжилж хянана. Нян судлалын лабораторигүй эрүүл мэндийн байгууллага гэрээгээр гүйцэтгүүлж болно.

6.7. Техникийн болон химийн хяналтыг халдвар хяналтын болон ариутгалын ажилтан нар өдөр бүр, тархвар судлаач, чанарын менежерүүд 7 хоногт 1 удаа хийнэ.

6.8. Ариутгагдсан боодолтой багаж, материалын бүртгэлийг өдөр тутам шалгаж, хэрэглэх тасаг нэгжид хугацаандаа шилжсэн эсэхэд хяналт тавина.

6.9. Ариутгалын бүртгэл, хяналтын хуудсыг ариутгах төхөөрөмж тус бүрээр өдөр бүр хөтөлж, хяналтын үзүүлэлтийг наах буюу бичнэ. Техникийн үзүүлэлтэд тухайн төхөөрөмжийн ариутгах хэм, даралт, хугацаа тэмдэглэгдэнэ. Эсвэл тухайн төхөөрөмжөөс хэвлэгдэн гарч байгаа хяналтын цаас наагдана.

6.10. Төвлөрсөн ариутгалын тасаг /нэгж/-т багаж, материалыг хүлээн авсан бүртгэлийн хуудсыг 2 хувь үйлдэж, төвлөрсөн ариутгалын тасаг/нэгж/, тухайн тасаг, эмнэлэгт хадгална.

6.11. Эрүүл мэндийн ажилтны нэрийг гаргацтай, татлахгүй бичнэ.

6.12. Тусламж үйлчилгээнд хэрэглэж байгаа багаж, хэрэгслийн угаалга, халдваргүйжүүлэлт, ариутгал, ариутгалын тасаг, нэгжийн үйл ажиллагаанд халдвар хяналтын ажилтан, тархвар судлаач эмч, чанарын алба дотоодын хяналтыг хийнэ.

6.13. Ариутгалын үйл ажиллагааг дараах шалгуур хуудсаар үнэлж дүгнэнэ.

| д/д | Үнэлгээний асуумж | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| 1 | Ариутгалын тасаг, хэсгийн урсгал зөв зохион байгуулагдсан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2 | Ариун, цэвэр, бохир хэсэг нь бүрэн тусгаарлагдсан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 3 | Өрөөний шал, хана, тааз нь эрүүл ахуй шаардлага хангасан | Шал нь - Зориулалтын зузаан резинен хулдаас,<br>Хана нь шаазан хавтан эсвэл тосон будаг,<br>Тааз эмульсдсэн бол | 2 |
| | | Дээрх үзүүлэлтээс аль нэг нь шаардлага хангахгүй бол | 1 |
| | | 2 буюу түүнээс дээш бол | 0 |
| 4 | Өрөө тасалгааны эрүүл ахуйн шаардлага | Шал, хана, таазны будаг нь хуурааагүй, хулдаас нь урагдаж цоороогүй бол | 2 |
| | | Шал, хана, таазанд урагдаж цоорсон гэмтэлтэй бол | 0 |
| 5 | Агааржуулалт | Агааржуулалтын нэгдсэн системтэй, хэвийн ажиллагаатай | 2 |
| | | Хэсгийн агааржуулалтын системтэй, хэвийн ажиллагаатай бол | 1 |
| | | Зөвхөн салхивчаар агааржуулалт хийгддэг | 0 |
| 6 | Ариутгалын тасаг халуун, хүйтэн усаар хангагдсан | Төвлөрсөн усан хангамжид холбогдсон халуун, хүйтэн устай | 2 |
| | | Зөөврийн усан хангамжтай боловч ус халаах, нөөцлөх, бохир ус зайлуулах | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| | | боломж бүрдүүлсэн | |
| | | Зөвхөн хүйтэн устай | 0 |
| 7 | Зөөврийн сав, бикс, тэргэнцэртэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 8 | Угаах төхөөрөмжөөр хангагдсан | Багаж, хэрэгсэл угаах угаалгын автомат машинтай бол | 2 |
| | | Зориулалтын угаалгын зөөлөвчтэй угаалтуурт гараар угаадаг | 1 |
| | | Түмпэнд хийж угаадаг | 0 |
| 9 | Ус шүүгчтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 10 | Ус нэрэгчтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 11 | Хатаах тоног, төхөөрөмжөөр хангагдсан | Хатаах шүүгээтэй | 2 |
| | | Арчиж хатаадаг | 1 |
| | | Өрөөнд тавьж хатаадаг эсвэл шууд ариутгадаг | 0 |
| 12 | Хуурай халууны шүүгээтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 13 | Хэт авиан цэвэрлэгчтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 14 | Уурын автоклавтай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 15 | Автоклав нь ариутгалын үйл ажиллагаанд ачаалалгүй хүрэлцдэг | Тийм | 2 |
| | | Зарим үед ачаалал ихтэй байдаг | 1 |
| | | Үгүй | 0 |
| 16 | Дуран угаах, халдваргүйжүүлэх автомат машинтай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 17 | Хийн плазмын ариутгагчтай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 18 | Пакетлагч машинтай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 19 | Багаж хэрэгслийг боох, савлах | Хэрэглэх байдлаар багцалж зориулалтын боолтоор боодог | 2 |
| | | Хэрэглэх байдлаар багцалж даавуунд боодог | 1 |
| | | Багцлахгүйгээр биксэнд хийж ариутгадаг | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | Ариутгалын үйл ажиллагааг индикатороор хянах | Хими, биологийн тест, уурын тархалтыг зааврын дагуу хянадаг бол | 2 |
| | | Зөвхөн химийн индикатороор хянадаг бол | 1 |
| | | Химийн индикатороор хяаяа хянадаг эсвэл хяналт байхгүй бол | 0 |
| 21 | Ажилтнуудыг ХСХ-ын талаар сургалтад хамруулдаг эсэх | Жилд 1-ээс доошгүй удаа сургалтад хамруулдаг | 2 |
| | | Хийдэггүй | 0 |
| 22 | Ус нэвтэрдэггүй хамгаалах, хувцас хэрэгслээр хангасан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 23 | Өртөлтийг бүртгэдэг, өртөлтөөс сэргийлэх иж бүрдэлтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 24 | Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 25 | Ажилтан нь ариутгагчийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан | Ажилтнууд нь сургалтад хамрагдсан | 2 |
| | | Зарим нэг ажилтан нь сургалтад хамрагдаагүй бол | 1 |
| | | Ариутгагчийн сургалтад хамрагдсан хүн байхгүй | 0 |
| | **Нийлбэр оноо** | | **.../50** |

6.14. Тухайн байгууллага нийлбэр оноо 0-15 байвал хангалтгүй, 16-25 бол дундаас доогуур, 26-40 дундаж, 41-50 байвал хангалттай түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

## Долоо. Ариутгах, халдваргүйжүүлэх, шавж, мэрэгч устгах бодист тавигдах шаардлага

7.1. Эрүүл мэндийн байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй олон улсын мэргэжлийн байгууллагаас зөвлөмж болгож буй бодисыг (цаашид бодис гэх) ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж мэрэгч устгалын зориулалтаар хэрэглэнэ.

7.2. Бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн онд хэрэглэх химийн бодисын жагсаалтад орсон, идэвхи найрлага, тогтвортой байдал, физик, химийн шинж чанар, шошго, найруулах, хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавартай байна.

7.3. Бодис нь хадгалах, тээвэрлэхэд чанараа амархан алдахгүй, үйлчлэх чадвар сайтай, хэрэглэхэд хялбар, аль болох шингэн хэлбэртэй, багаж, хэрэгслийн өнгө, чанарт сөрөг нөлөөгүй, тэсэрч дэлбэрэх, галын аюулгүй байх нийтлэг шаардлагыг хангасан байна.

7.4. Эрүүл мэндийн байгууллага нь бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, бодисын үйлчлэх хугацааг мөрдөнө.

7.5. Бодистой харьцан ажилладаг ажилчдад бодисыг бэлтгэх, хэрэглэх, хадгалах, устгах, хор, аюулын талаар мэдээллээр хангаж, сургалт зохион байгуулна.

7.6. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.

7.7. Ариутгах, халдваргүйжүүлэх зорилгоор хэрэглэгдэх бодисуудыг доорх байдлаар ангилан, хэрэглэнэ. Үүнд:

1. Үжлийн эсрэг /антисептик/ - Мэс заслын өмнө гар угаах, гар халдваргүйжүүлэх, үйлчлүүлэгчийн арьс салст, умайн хүзүү, үтрээг эмчилгээ болон мэс ажилбарт бэлтгэх зэрэгт хэрэглэнэ.
2. Халдваргүйжүүлэгч /дезинфектант/

- **Хүчтэй халдваргүйжүүлэгч:** Багаж хэрэгсэл ба бусад зүйлийг халдваргүйжүүлэх, химийн аргаар ариутгахад хэрэглэнэ.
- **Сул (энгийн) халдваргүйжүүлэгч**: Шал, ширээний тавцан зэрэг хатуу эдлэлийн гадаргууг цэвэрлэх, халдваргүйжүүлэхэд хэрэглэнэ.

7.8. Нунтаг бодисыг урагдаж цооройгүй уутанд хийж, , агааржуулалт бүхий зориулалтын агуулахад, зориулалтын тавиур дээр, бодисын онцлогоос хамаарч, амархан задардаг бодисыг хүрэн бор өнгийн шилэнд эсвэл хуванцар саванд хийж, нарны шууд тусгалаас хол, сэрүүн нөхцөлд хадгална.

7.9. Бодисын гадна талд тэмдэглэгээ тавьж, түүн дээр бодисын нэр, үйлдвэрлэсэн он, хадгалах хугацааг зааж, байнга хянаж тэмдэглэл хөтөлнө.

## Найм. Ариутгах, халдваргүйжүүлэх, шавж, мэрэгч устгах бодист хордсон үед авах арга хэмжээ

8.1. Ариутгах, халдваргүйжүүлэх, шавж мэрэгч устгах хор бодистой ажиллаж байгаа тасаг, нэгжид доорх эм, хэрэгсэл бүхий яаралтай тусламжийн хайрцаг, шүүгээг зайлшгүй байлгаж хяналт тавьж ажиллана.

| № | Эмийн нэр | Тоо хэмжээ |
|---|---|---|
| 1 | Альбуцид 30% уусмал | 1 фл |
| 2 | Атропин 0.1% | 50 амп |
| 3 | Идэвхижүүлсэн нүүрс | 500.0 |
| 4 | Аммиак 10% (нашатырын спирт) | 100.0 |
| 5 | Валериан (ханд, шахмал) | 1 фл |
| 6 | Марганец | 500.0 |
| 7 | Кальцийн хлорид | 200.0 |
| 8 | Марганц кали | 50.0 |
| 9 | Ургамлын тос | 200.0 |
| 10 | Зэсийн сульфат | 50.0 |
| 11 | Новокайн 2% | 20.0 |
| 12 | Хүнсний сод | 200.0 |
| 13 | Устөрөгчийн хэт исэл | 1 фл |
| 14 | Сулруулсан давс | 50.0 |

| | | |
|---|---|---|
| 15 | Зүрхний бэлдмэл | 2 фл |
| 16 | Гич | 50 ширхэг |
| 17 | Нүдний дусаагуур | 3 ширхэг |
| 18 | Нүд угаах зориулалтын төхөөрөмж эсвэл том амсартай сав | 1 ширхэг |
| 19 | Ариун бинт | 10 ширхэг |
| 20 | Хөвөн | 100.0 |
| 21 | Иод | 100.0 |

8.2. Бодисууд нь хамар, залгиур хоолой, бронхын салст бүрхүүлийг цочроосноор хамраас нус гоожих, хуурай ханиалгах, нүд хорсох, загатнах, нулимс асгарах, хүнд хордсон үед амьсгаадах, цээжний араар өвдөх, дотор муухайрах, бөөлжих зэрэг шинж илэрч болно. Идэвхитэй хлор агуулсан халдваргүйтгэх бодис арьсанд хүрэхэд арьс хуурайших, холцруутах шинж илэрнэ. Фенол, бензилхлорфенол зэрэг бодис арьсанд хүрэхэд арьсны үрэвсэл, арьс түлэгдэх ерөнхий хордлогын шинж илэрдэг.

8.3. Бодисонд хордсон тохиолдолд яаралтай авах арга хэмжээ:

- Хордсон газраас яаралтай холдуулж, цэвэр агаараар амьсгалуулна.
- Бодис асгарч, цацагдсан хувцсыг тайлуулж, бодисыг хөвөн даавуугаар зөөлөн арчиж, шингээж авах ба үрж нухаж болохгүй.
- Арьсыг 5-10%-ийн нашатырын спирт эсвэл 2%-ийн содын уусмалаар цэвэрлэнэ. Хэрэв дээрхи бодисууд байхгүй бол арьсыг савантай урсгал усаар угааж цэвэрлэнэ.
- Нүдэнд халдваргүйжүүлэх уусмал орсон бол урсгал цэвэр усаар эсвэл 2%-ийн хүнсний содын уусмалаар 5-10 минутын туршид угаана. Хэрэв нүдний салстад цочрол их өгсөн бол альбуцидын уусмалаар зайлах ба өвдөлттэй байвал 2%-ийн новокайны уусмал хэрэглэнэ. Хүүхэн хараа нарийсаж, харааны хямрал өөрчлөлт илэрвэл 0.05%-ийн хүхэр хүчлийн атропин эсвэл 0.1%-ийн атропиныг устай 1:1 харьцаагаар хольж зайлах байдлаар угаана.
- Залгиурын салст цочирсон бол 2%-ийн хүнсний содын уусмал уулгах эсвэл содын уусмалаар утах, ханиалгаад байвал гич, бумба тавьж болно.
- Химийн бодисыг санамсаргүй тохиолдлоор залгисан бол цэвэр ус эсвэл марганцийн цайвар ягаан өнгийн /1:5000, 1:10000/ уусмалаас уулгаж, дараа нь бөөлжүүлнэ. Бөөлжүүлэхийн тулд цочроох янз бүрийн аргыг хэрэглэж болно. Үүнд: механик цочрол (хүүхэн хэл, хэлний угийг цочроох), гичийн тусламжтайгаар (нэг стакан бүлээн усанд 1 цайны халбага хуурай гич хийх) цочроож, энэ ажилбарыг 2 удаа давтана. Бөөлжсөний дараа ходоодыг 2%-ийн хүнсний содын уусмалаар (1 стакан усанд нэг цайны халбага сод хийнэ) угаана.

Маягт 1

## АРИУТГАЛЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

**Ариутгалын төрөл**: Уурын, хуурай халууны, хийн, химийн, этилен оксидын /зур/ 20.....оны .....сарын.....өдөр

**Аппаратын нэр, марк** :_____

| № | Ариутгасан зүйлийн нэр | Тоо хэмжээ | Ариутгасан хугацаа | | | Хяналт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эхэлсэн цаг | Дууссан цаг | Ариутгалын аппаратаас гаргасан цаг | Химийн | Биологийн | Техникийн үзүүлэлт |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

**Ариутгалын ажилтан:** ...../ /

/гарын үсэг / /нэр/

Маягт 2

## ТӨВЛӨРСӨН АРИУТГАЛЫН ТАСАГ /НЭГЖ/-Т БАГАЖ, МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Эмнэлэг, Тасгийн нэр: _____

20....оны.....сарын.....өдөр.....цаг.....минут

| № | Багаж материалын нэр/ | Тоо ширхэг | Хүлээлгэж өгсөн хүний нэр | Хүлээж авсан хүний нэр |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |



107

Маягт 3

## БАГАЖ, МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Эмнэлэг, Тасгийн нэр: _____

20....оны.....сарын.....өдөр.....цаг.....минут

| № | Багаж материалын нэр/ | Ариутгалд орсон огноо | Тоо ширхэг | Хүлээлгэж өгсөн хүний нэр | Хүлээж авсан хүний нэр |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

# ХУВИЙН ХАМГААЛАХ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл нь үйлчлүүлэгчээс, эмнэлгийн ажилтанд, эмнэлгийн ажилтнаас үйлчлүүлэгчдэд, үйлчлүүлэгчдийн дунд эмнэлгийн ажилтнаар дамжин бичил биетэн тархахаас хамгаалах үүрэгтэй.

1.2. Энэхүү зааврыг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтан бүр дагаж мөрдөнө.

1.3. Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэлд малгай, амны хаалт, нүдний шил, нүүрний халхавч, бээлий, халад, өмд, цамц, хормогч, гутал хамаарна.

1.4. Хамгаалах хувцас хэрэгсэл нь угаах, халдваргүйжүүлэх, ариутгахад боломжтой материалаар хийгдсэн байна.

1.5. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг хэрэглэх зааврыг тусгай журмаар зохицуулна.

## Хоёр. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх

2.1. **Малгай нь** үс бохирдох, үсэнд агуулагдах нянгаар үйлчлүүлэгч халдварлахаас хамгаалах бөгөөд битүү далдалсан, хөвөн даавуун болон цаасан материалаар хийгдсэн байна. Эмчилгээ, үйлчилгээний бүхий л ажилбарын үед өмсөнө.

2.2. **Амны хаалт нь** агаар дуслын замаар бусдад халдвар дамжуулахаас хамгаалах бөгөөд төрөх, нярай, хагалгааны өрөөнд ажиллах, дархлаа нь суларсан хүмүүст үйлчлэх, биеийн хөндийд хатгалт хийх, хог хаягдалтай харьцаж ажиллах болон амьсгалын замын ямар нэгэн халдвараар өвчилсөн, эрүүл мэндийн ажилтан өмсөнө. Амны хаалтыг 2 цаг тутамд солино.

2.2.1 Дараах тохиолдолд өндөр шүүлтүүртэй амны хаалт (N95, N 100, 3M) хэрэглэнэ. Үүнд:

- Тарваган тахал,
- Боом,
- Шувууны томуу,
- АЦХаХ,
- Уушгины түрхэц эерэг сүрьеэ, эмэнд дасалтай сүрьеэ
- Хорт бодис найруулах
- Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис найруулах үед

2.2.2. Шүүлтүүртэй амны хаалтыг зүүх дараалал:

2.2.2.1. Аяга хэсгийг гар дотроо, хамрын хэсгийг хуруунуудын үзүүрт, толгойн уяаг гарт сул унжуулж байрлуулна.

2.2.2.2. Эрүүний доод хэсгээс хамрын дээд хэсэг хүрэхээр байрлалд аваачин дээд талын уяаг нь чангалж татаад толгойны ар талд дээд хэсэгт хөдөлгөөнгүй тогтооно.

2.2.2.3. Доод уяаг нь чихний доод хэсэгт хүзүүний орчимд тогтооно.

2.2.2.4. Хоёр гарынхаа хурууны үзүүрүүдээр хамрын хэсэгт байгаа металл дээр байрлуулж, хамрынхаа хэлбэрт тохируулна.

2.2.3. Амны хаалтны тохирсон эсэхийг шалгах:

2.2.3.1. гараараа амны хаалтны өмнө талаас барьж огцом амьсгаа гаргахад хамгаалалт дотор нэмэх даралт үүсч гадагш хий гарахгүй байна.

2.2.3.2. Гүнзгий амьсгаа авахад сөрөг даралт үүсч хамгаалалт таны нүүрэнд наалдана. Хэрвээ нүх гарсан, зөв байрлаагүй, эсвэл бүч сул бол дахин шалгана.

2.3. **Хамгаалагч шил** нь цус болон биеийн шингэн, лабораторийн урвалж, хорт бодис эмнэлгийн ажилтны нүд рүү цацагдахаас хамгаална. Ариутгал, мэс засал, эх барих, лаборатори зэрэг өндөр эрсдэлтэй ажилбарын үед нүдний шил, нүүрний хаалтыг хэрэглэнэ. Нүдний шил, нүүрний хаалтыг хэрэглэсний дараа 70 хувийн этилийн спиртийн уусмалаар арчих буюу дүрж халдваргүйжүүлнэ.

2.4. **Бээлий нь** эмнэлгийн ажилтны гар бохирдохоос хамгаалах бөгөөд урагдаж цоорооогүй нэг удаагийн бээлийг хэрэглэнэ. Бээлийг өмсөхийн өмнө, тайлсаны дараа гарыг нянгийн эсрэг үйлчилгээтэй савангаар савандаж угаана. Нэг үйлчлүүлэгчид нэг бээлий хэрэглэнэ. Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх уусмалаар бээлийг арчихгүй. Бээлийг дахин хэрэглэхгүй.

2.4.1. Бүх төрлийн мэс ажилбар, төрөлт удирдах, төвийн судасны ажилбар, хими эмчилгээ, цустай хавьтах ажилбаруудын үед мэс заслын ариун бээлий өмсөнө.

2.4.2. Судсаар шингэн залгах, салгах, судас тариа, шүдний эмчилгээ, цус юүлэх, үтрээний үзлэг, мөгөөрсөн хоолойн гуурсаар соруулах, ажилбарууд, цус болон биеийн шүүрэл, тэдгээрээр бохирлогдсон эд зүйлстэй харьцах, салст бүрхүүл, гэмтсэн арьс, халдвартай эд зүйлстэй хүрэлцэх, халдварт өвчний дэгдэлт, яаралтай тусламжийн үед нэг удаагийн үзлэгийн бээлий хэрэглэнэ.

2.4.3. Хэрэглэсэн бээлийг тайлах:

- Нэг талын бээлийтэй гарын хурууны үзүүрээр нөгөө гарын бээлийний гадна талаас татаж дотор талыг гадагш эргүүлэн тайлна.

- Тайлсан бээлийг бээлийтэй гарт атгаж бээлийгүй гарын хуруу нөгөө гарт байгаа бээлийний дотор талаар оруулж урагш татан дотор талыг нь гадагш эргүүлэн тайлна.
- Бээлийг тайлахад нэг бээлий нь нөгөө бээлийний дотор орсон байна.

2.4.4. Бээлийг тайлахгүйгээр өрөөнөөс гарах, бусад газраар явах, нүд, хамар, амандаа хүрэх, буруу хадгалсан, урагдаж цоорсон бээлийг хэрэглэхийг хориглоно.

2.4.5. Хэрвээ бээлий халдвартай материалаар бохирлогдсон, үйлдлийн явцад цоорч урагдсан тохиолдолд тэр даруй бээлийг журмын дагуу тайлан устгалд өгч, гараа сайтар угааж, халдваргүйжүүлээд дахин цэвэр бээлий өмсөнө.

2.4.6. Зузаан резинэн /ахуйн зориулалтын/ бээлийг бохир багаж, хог хаягдал ба цагаан хэрэглэлтэй хүрэлцэх, байр, орчны цэвэрлэгээ болон бохирдсон гадаргууг цэвэрлэхэд өмсөнө. Энэ төрлийн бээлийг хэрэглэсний дараа халдваргүйжүүлэн угааж, хуурайгаар нь хадгална.

2.5. **Халад нь** цагаан өнгөтэй, урт ханцуйтай, хөвөн даавуун материалтай, бариу биш, нэвт гэрэлтдэггүй, ухлаадас нь эгэмнээс доошгүй, энгэр товчтой, өвдөгнөөс доош 1-2 сантиметр урттай байна. Халадны зүүн ханцуйнд мөрнөөс доош 10 сантиметрт эмнэлгийн эмблемийг хадаж, өөрийн нэр бүхий энгэрийн тэмдгийг зүүн энгэртээ байнга зүүнэ. Халадны дотуур ажлын онцлогоос шалтгаалан цамц, өмд өмсөнө.

2.6. **Резинэн болон пластик хормогч, ханцуйвч** нь цус болон биеийн бусад шингэнээр хувцас бохирдохоос хамгаалах бөгөөд ариутгал, мэс засал, төрөх, эмгэг анатомийн тусламж үйлчилгээний явцад, цус болон ямарваа нэгэн шингэн зүйлтэй харьцах тохиолдол бүрт өмсөнө. Шингэн нэвтрэхээргүй материалаар хийгдсэн байна. Ажилбарын явцад, тайлах үед нөмрөг, хормогчийн гадаргууд хүрэхгүй байхад анхаарна. Хэрэглэсний дараа халдваргүйжүүлэх уусмалд дүрэх буюу арчиж халдваргүйжүүлнэ.

2.7. **Гутал нь** хүнд болон хурц үзүүртэй зүйл унах, цус, биеийн шингэнээр бохирлогдох, халуун зүйл асгарч түлэгдэхээс хөлийг хамгаалах бөгөөд урдууraa битүү, намхавтар өсгийтэй /3-5 см/, зөөлөн ултай, чийг татдаггүй байна. Мөн гутлын гадуурх нэг удаагаар хэрэглэгдэх углааш хэрэглэж болно.

2.8. Эрүүл мэндийн ажилтнууд хамгаалах хувцас хэрэгсэлтэй эмнэлгийн орчноос бусад газар сэлгүүцэх, өөрийн тасаг, нэгжид өмссөн хувцастай бусад тасаг, нэгж, хурал, зөвөлгөөн, эмнэлгийн хоолны газар, бие засах өрөөнд орох, тасаг, нэгжид болон гэртээ аваачиж угаахыг хориглоно.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02-өдрийн 137 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫГ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗААВАР

## Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн ажилтан (цаашид ажилтан гэх) нь ажил үүргээ гүйцэтгэх явцад халдварт өртөх, өртсөн тохиолдолд бусдад халдвар тараах эрсдэлтэй байдаг.

1.2. Зүүнд хатгуулах, хурц үзүүртэй, иртэй багажинд зүсэгдэх гэх мэтээр арьс гэмтэх, халдварлагдсан биологийн шингэн ам, хамар, нүдний салстад үсрэх, үрэвссэн болон гэмтээгүй арьстай удаан хугацаанд хүрэлцэх зэрэгт цусаар дамжих халдварт өртөх эрсдэлтэй.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь дараах чиглэлээр ажилтныг халдвараас сэргийлэх арга хэмжээг авна.

1.3.1. халдварт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх
1.3.2. халдварт өртсөний дараа урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хянах

1.4. Өртөлтийн дараах сэргийлэлт (ӨДС) гэж хүний дархлал хомсдлын вирус, B, C, D вируст гепатит болон цусаар дамжих бусад халдварт өртсөн үед халдвар авах эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг хэлнэ.

## Хоёр: Халдварт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх

2.1. Эрүүл мэндийн байгууллага нь хуваарийн дагуу ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, дархлаажуулах, хувийн хамгаалах хувцас хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна.

2.2. Ажилтны аюулгүй байдал, ажлын байран дахь эрсдэлт өртөлт, өртөлтийн дараах арга хэмжээний талаар улирал бүр сургалт зохион байгуулна.

2.3. Ажилтныг ажилд авахдаа В вируст гепатит, сүрьеэ, халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран зэрэг өвчний эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан эсэхийг баталгаажуулах, эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн хуудас нээж, түүнд тэмдэглэн, хувийн хэрэгт хавсаргана. Ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгална.

## Ажилтны эрүүл мэндийн хуудас

1. Овог _____ 2. Нэр _____
3. Нас ___ 4. Хүйс: ☐ Эр ☐ Эм
4. Албан тушаал: _____

### А.Эрүүл мэндийн үзлэг, оношлогоо, шинжилгээ

| Үзлэг | Оношлогоо | Он/сар/өдөр | Эмнэлгийн нэр | Эмчийн гарын үсэг |
|---|---|---|---|---|
| Дотор | | | | |
| Мэдрэл | | | | |
| Чих, хамар, хоолой | | | | |
| Нүд | | | | |
| Мэс засал | | | | |
| ЭХО | | | | |
| Цээж гэрэлд харах | | | | |
| Биохими | | | | |
| Маркер B, C, D | | | | |
| ХДХВ, Тэмбүү | | | | |

Б. Дархлаажуулалт:

| **Баталгаажуулах** | **Дархлаажуулах** |
|---|---|
| Гепатит В:<br>◯ Тийм ◯ Үгүй ◯ Мэдэхгүй | Ажилтан бүр<br>В Вирус гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулах<br>В Вирус гепатитын эсрэг дархлаажуулалтын<br>дархлал тогтоц үзэх _____ |
| Сүрьеэ:<br>◯ Тийм ◯ Үгүй ◯ Мэдэхгүй | |
| Халдварт саа:<br>◯ Тийм ◯ Үгүй ◯ Мэдэхгүй | *Ажил мэргэжлийн онцлогоос:*<br>Сүрьеэ _____<br>Татран _____<br>Балнад _____ |
| Сахуу, хөхүүл ханиад, татран:<br>◯ Тийм ◯ Үгүй ◯ Мэдэхгүй | |
| Улаанбурхан, гахай хавдар, улаанууд:<br>◯ Тийм ◯ Үгүй ◯ Мэдэхгүй | |

### В. Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийн дүгнэлт:

_____

_____

_____

---

---------- Гарын үсэг

----------он --------- сар --------- өдөр

2.4. Эрүүл мэндийн байгууллага нь ажилтныг В вируст гепатит, томуу, улаанууд, гэдэсний балнад, тарваган тахал, сүрьеэгийн эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар болон сайн дурын хэлбэрээр дархлаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

2.5. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн нь нийт ажилтны эрүүл мэндийн үзлэгийн талаар мэдээллийн сан бий болгож, ажилтны эрүүл мэнд хариуцсан эмч, тархвар судлаач эмч хяналт тавьж ажиллана.

2.6. Бүх тасаг, нэгжид өртөлтийн дараах сэргийлэлтийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай спирт, шархны наалт, боолт, самбай, цус тогтоох цацлага болон наалт, ретровирусийн эсрэг эм, бензатинпенициллин G 2.4 сая нэгж, цефиксим 400 мг /өргөн хүрээний нянгийн эсрэг бэлдмэл/ бүхий цомгоор хангасан байна.

2.7. Ажилтан нь цусаар дамжих халдварын эрсдэлт өртсөн үед өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.7.1 Ажилтан эрсдэлд өртсөн даруйд нэн яаралтай дараах арга хэмжээг авна.

2.7.1.1. Зүүнд хатгуулсан бол айж, сандрахгүй, зүссэн, хатгасан шархтай хэсгийг савантай усаар угаана.

2.7.1.2. Нүд рүү биологийн шингэн үсэрсэн тохиолдолд цэвэр ус эсвэл физиологийн уусмал, зориулалтын нүд угаагчаар угаана. Саван, халдваргүйжүүлэх бодис хэрэглэж болохгүй.

2.7.2 Эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан тохиолдол бүрийг бүртгэнэ. Бүртгэлд дараах зүйлийг тэмдэглэсэн байна.

2.7.2.1. Эрсдэлд орох үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байсан тасаг, кабинет, үйлчлүүлэгчийн өвчний түүхийн дугаар,

2.7.2.2. Зүүнд хатгуулсан тохиолдолд зүүний хэмжээ, зүүний төрөл, хэзээ хаана хэрхэн хатгуулсан, хатгасан газраас цус гарч байсан эсэх, хийсэн тарианы хэмжээ

2.7.2.3. Салсттай хүрэлцсэн тохиолдолд: хатгалтын гүн, тариа хийсэн газраас цус гарч байсан эсэх, хийсэн тарианы хэмжээ

2.7.3 Эрүүл мэндийн ажилтан эрсдэлд өртсөн тохиолдлыг даруй харьяалагдах удирдах албан тушаалтан, тархвар судлаач эмчид мэдэгдэнэ.

2.7.4 Халдварын эрсдэлийн үнэлгээг тархвар судлаач эмч, эмнэл зүйч эмчтэй хамтран хийнэ.

- Ажилтны эрүүл мэндийн болон гэмтлийн байдалд үнэлгээ хийнэ.
- Үйлчлүүлэгчийн халдвартай эсэх, халдварын үе шат, вирусийн ачаалал тооцно.

- Үйлчлүүлэгчийн өвчлөлийн байдал тодорхойгүй, шинжилгээ өгөхөөс татгалзсан тохиолдолд үйлчлүүлэгчийн онош, эмнэл зүйн шинж тэмдэг, зан үйлийг харгалзана.

2.7.5. Халдварын эрсдлийн үнэлгээнд үндэслэн өртөлтийн дараа халдвараас сэргийлэх эмчилгээ, шинжилгээг хийнэ. Үүнд:

- Үйлчлүүлэгч тэмбүүгийн халдвартай, шинжилгээ өгөхөөс татгалзсан, өвчлөлийн байдал тодорхойгүй эсвэл эх уурхай тодорхойгүй бол урьдчилан сэргийлэх зорилгоор бензатинпенициллин G 2,4 сая нэгжээр нэг удаа булчинд тарина.
- Үйлчлүүлэгч ХДХВ-ийн халдвартай, шинжилгээ өгөхөөс татгалзсан, өвчлөлийн байдал тодорхойгүй эсвэл эх уурхай тодорхойгүй бол ретровирусийн эсрэг эмийг аль болох хурдан (эрсдэлт өртөлтөөс хойш 72 цагаас хэтрүүлэлгүй) ууна. Эмчилгээний үргэлжлэх хугацаа, тун хэмжээг мэргэжлийн байгууллагын зөвлөгөөний дагуу шийдвэрлэнэ.
- Ажилтан нь В вируст гепатитын эсрэг дархлаажуулалтад хамрагдаагүй, дархлаажуулалтад хамрагдсан ч дархлал тогтоогүй (<10 mIU/ml), эх уурхай нь HBsAg эерэг тохиолдолд В вируст гепатитын эсрэг вакцин, иммуноглобулинаар эрсдэлд өртсөний дараа 48 цагийн дотор, 7 хоногоос хэтрэлгүй дархлаажуулна.

2.8. Тухайн эрүүл мэндийн ажилтан эрсдэлд өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ авч байх үед цус болон бусад эрхтний донор болохгүй байхыг зөвлөнө.

2.9. Эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа ЭТҮХХ-ын эрсдэлд өртсөн тохиолдолд шинжилгээ, ӨДС-ийн эмчилгээг тухайн байгууллага хариуцаж хийлгэнэ.

## Гурав. Халдварт өртсөний дараа авах арга хэмжээ, хяналт

3.1 Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчийг томилон ажиллуулна. Тухайн эмч нь эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, хяналтын асуудлыг хариуцаж, нууцыг хадгалж холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллана.

3.2 Ажилтан нь халуурсан, арьсанд тууралт гарсан, үүссэн шарх сорви нь халдварлагдсан, халдварын сэжиг илэрсэн тохиолдолд, тасгийн дарга, эрхлэгч, халдвар хяналтын багт мэдэгдэнэ.

3.3 Халдварт өвчтэй болох нь тогтоогдсон ажилтныг халдвар дамжих эрсдлээс шалтгаалан хөдөлмөр зохицуулалт хийх асуудлыг халдвар хяналтын баг шийдвэрлэнэ.

3.4 Эрүүл мэндийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхижил $\geq 10^4$ GE/ml тохиолдолд хэвлий, цээжний хөндий, зүрх, үе мөч, гэмтэл, мэдрэлийн мэс засал, төрөх, эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбарт оролцуулахыг хязгаарлах арга хэмжээ авна.

3.5 Эрүүл мэндийн ажилтны HBV, HCV вирусийн идэвхжилийг жилд 2 удаа шинжилнэ.

3.6 Эрүүл мэндийн ажилтанд ХДХВ-ийн халдвар илэрсэн тохиолдолд мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбар, шүд, эх барих, чих хамар хоолой гэх мэт бусад ажилбар бүхий эмнэлгийн тусламж үйлчилгээнд оролцуулахыг хориглоно.

3.7 Цусаар дамжих халдвартай болох нь тогтоогдсон эрүүл мэндийн ажилтантай байгуулах гэрээнд дараах асуудлыг тусгасан байна.

3.7.1. Ажилтны эрүүл мэндийг хариуцсан эмчийн хяналтад байж жилд 2 удаа вирусийн идэвхжилийг шинжилгээгээр хянах, өвчний явц, эмчилгээний талаар зөвлөгөө авах,

3.7.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх асуудлаар давтан сургалтад хамрагдах,

3.7.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх заавар журмыг чанд мөрдөж ажиллах,

3.7.4. Ажлын байр өөрчлөгдөх, вирус идэвхжсэн, өөр төрлийн өвчин эмгэг илрэх зэрэг үйлчлүүлэгчид халдвар дамжуулах эрсдэлтэй тохиолдолд ажилтны эрүүл мэнд хариуцсан эмчид мэдэгдэх,

3.7.5. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад алдаа гарч үйлчлүүлэгч халдварт өртөх эрсдэл үүссэн тохиолдолд богино хугацаанд харьяалагдах удирдах албан тушаалтан, тархвар судлаач эмчид мэдэгдэх,

3.7.6. Хэрэв ажилтанд ХДХВ-ийн халдвар илэрвэл гэрээг дахин шинэчлэх хөдөлмөр зохицуулалт хийхийг зөвшөөрөх,

## Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны халдвараас сэргийлэх арга хэмжээг үнэлэх

4.1 Халдвар хяналтын баг нь эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд дотоодын хяналтыг хийнэ.

4.2 Дотоод хяналтыг дараах шалгуур хуудсаар үнэлж дүгнэнэ.

4.3 Үнэлгээг тийм онооны нийлбэр дүнг, үнэлгээ хийгдсэн асуумжийн авбал зохих оноонд харьцуулж хувиар гаргана.

| Д/д | Үнэлгээний асуумж | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| **Нэг. Эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ** | | | |
| 1. | Ажлын байрны аюулгүй байдал, | Үгүй | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| | ажилтны халдвараас сэргийлэх чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулсан байх | Тийм | 1 |
| 2. | Төлөвлөгөөний хэрэгжилт | 50 %-аас бага | 0 |
| | | 51-89% | 1 |
| | | 90%-аас их | 2 |
| 3. | Ажилтны аюулгүй байдал, халдвараас сэргийлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| 4. | Шинээр ажилд орж буй ажилтанд ажлын байран дахь эрсдлийн талаархи сургалт зохион байгуулсан байх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| 5. | Шинээр ажилд орж буй ажилтануудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан эсэх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| 6. | Шинээр ажилд орогсдыг В вирус гепатитын эсрэг дархлаажуулалтад хамруулсан эсэх | 50 %-аас бага | 0 |
| | | 51-89% | 1 |
| | | 90%-аас их | 2 |
| 7. | Ажилтнуудын эрүүл мэндийн талаар мэдээллийн сантай эсэх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| 8. | Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан эсэх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| 9. | Ажилтнуудын эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийж эрүүлжүүлэх арга хэмжээ авсан эсэх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| **Хоёр. Өртөлтийн дараах сэргийлэлт** | | | |
| 10. | Өртөлтийн дараах сэргийлэлтийн анхны тусламжийн цомгоор хангасан эсэх | Байхгүй | 0 |
| | | Зарим тасаг нэгжийг хангасан | 1 |
| | | Бүх тасаг нэгжид хангасан. | 2 |
| 11. | Эрсдэлийг бүртгэх бүртгэлтэй | Үгүй | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| | эсэх | Тийм | 1 |
| 12. | Эрсдэлт өртөлтийн дараа өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ авсан эсэх | Эрсдэл бүртгэгдээгүй | 3 |
| | | 30%-иас бага | 0 |
| | | 31 – 50% | 1 |
| | | 51-80% | 2 |
| | | 80%-иас дээш | 3 |
| **Бүгд** | | | **..... / 17** |

4.4. Тухайн байгууллагын нийлбэр онооны хувь 60%-аас бага байвал хангалтгүй, 60-70% бол дундаас доогуур, 71-90% дундаж, 91-100% байвал хангалттай гэж үнэлээд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
5 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ЗААВАР

## Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн байгууллагын нийт талбайг гадаад болон дотоод орчин гэж ангилна.

1.2 Дотоод орчинд хамаарах талбайг тасаг, нэгжийн үйл ажиллагаа, халдварын эрсдэлийн зэргээр А, В, С бүсэд хуваан, бүс тус бүрт тохирсон цэвэрлэгээг хийнэ. (хүснэгт 1)

1.3 Цэвэрлэгээ хийхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг угааж хадгалах нөхцөлөөр бүрэн хангасан байна.

1.4 Цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалд тоос сорогч, хивс угаах машин, цэвэрлэгээний тэргэнцэр, хувин, шалны мод, даавуун алчуур, цонх, шил толь цэвэрлэгч, шүршигч сав, сойз, хөөсрүүлэгч материал, шүүр, хогийн хутгуур, хогийн уут хамаарна.

## Хоёр: Цэвэрлэгээний ерөнхий зарчим

2.1 Цэвэрлэгээ хийх журам, цэвэрлэгээний хуваарийг халдвар хяналтын баг боловсруулж батлуулсан байна.

2.2 Халдвар хяналтын баг нь эрүүл мэндийн ажилтнуудад цэвэрлэгээ хийх давтамж, цэвэрлэгээний материалыг цэвэрлэх, хадгалах, цэвэрлэгээ хийх уусмалыг бэлтгэх талаар сургалтыг зохион байгуулна.

2.3 Цэвэрлэгээ хийх үед ахуйн хэрэглээний бээлий, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.

2.4 Цэвэрлэгээнд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, материал нь бохирлогдоогүй, цэвэр байх бөгөөд хэрэглэсний дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж, цэвэр усанд зайлж, хатаасан байна.

2.5 Эрүүл мэндийн байгууллагын хана шал, бусад тавилга, хэрэгсэл эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн гадаргууг арчиж цэвэрлэхдээ тоос, бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж чийгтэй алчууураар арчиж цэвэрлэнэ.

2.6 Хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлээс эхэлж дээрээс доош нь чиглэлтэй цэвэрлэгээг хийнэ.

2.7 Цэвэрлэгээ хийх явцад цэвэрлэгээний ус бохирдоход бичил биетэнийг орчинд тараах эрсдэлтэй тул бохирдсон уусмалыг тухай бүрд солино.

2.8 Тасаг нэгж бүр цэвэрлэгээний тэргэнцэртэй байх ба цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалыг өөр тасаг, нэгжид ашиглах, хооронд нь сольж хэрэглэхийг хориглоно.

2.9 Цэвэрлэгээнд хэрэглэгдэх материалыг өнгөөр ялгаж, хэрэглэнэ.

| Зориулалт | Материалын өнгө |
|---|---|
| Ариун цэврийн өрөөний суултуурт | Улаан, ягаан өнгө |
| Ариун цэврийн өрөөний гар угаалтуур болон бусад гадаргууг | Шар өнгө |
| Үйлчлүүлэгчийн палат, өрөөнүүдийн тоног төхөөрөмж, хэрэгслүүд, хана, ор, цонх г.м | Цагаан, цэнхэр өнгө |
| Шал | Шалны зориулалтын алчуур, таних тэмдэгжүүлсэн байна. |

2.10 Их цэвэрлэгээг 2 долоо хоногт 1 удаа, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.

2.11 Эрүүл мэндийн байгууллагын гадна талбайд сард 1 удаа их цэвэрлэгээг хийнэ. (Хүснэгт 1)

| Бүс | Тухайн бүсэд хамаарах тасаг нэгж | Цэвэрлэгээ хийх уусмал | Цэвэрлэгээ хийх давтамж |
|---|---|---|---|
| **А халдварын эрсдэл өндөр** | Тусгаарлах, мэс засал, төрөх, боолт, тарианы, ариутгал, цусны албаны боксын, лабораторн, сүрьеэ, халдварт, амбулаторийн ажилбарын, угаалгын бохирын хэсэг, сэхээн амьдруулах, эрчимт, төрсний болон мэс заслын дараах, нярай, хог хаягдлын цэг, ариун цэврийн өрөө гэх мэт | Халдваргүйжүүлэх уусмал, Халдваргүйжүүлэгч, угаагч нунтгийн холимог уусмал | Бохирдсон тухай бүр, Өдөрт 3-аас доошгүй удаа |
| **В халдварын эрсдэл дунд** | Гал тогоо, амбулаторийн ажилбарын бус өрөөнүүд, эмийн сан, эмчийн өрөө, физик эмчилгээ, сувилагчийн пост, рентген, хэт авиан оношилгоо, зүрхний бичлэг, угаалгын газрын хатаалга, индүүдлэг, хадгалах өрөө, төрөхийн болон мэс заслын өмнөх, цус цуглуулах өрөө гэх мэт | Халдваргүйжүүлэх уусмал, Халдваргүйжүүлэгч, угаагч нунтгийн холимог уусмал | Бохирдсон тухай бүр, Өдөрт 2-оос доошгүй удаа |
| **С халдварын эрсдэл бага** | Захиргаа, сургалтын өрөө, хонгил, хүлээлгийн өрөө, бүртгэл, өлгүүр гэх мэт | Угаалгын нунтаг бүхий уусмал | Өдөр тутам |

## Гурав: Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх

3.1. Эрүүл мэндийн ажилтан нь асгарсан, цацагдсан цус, биологийн шингэн дээр нойтон алчуур тавьж үлдээхгүй, халдвар гэнэтийн ослоос сэргийлж нэн даруй халдваргүйжүүлэн цэвэрлэнэ. (Хүснэгт 2)

3.2. Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэнийг халдваргүйжүүлэн цэвэрлэх цомог, иж бүрдлийг бэлтгэсэн байна.

Хүснэгт 2

| Хэмжээ | Цэвэрлэгээ |
|---|---|
| Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэн бага (диаметр-10 см-с бага) | • Хувийн хамгаалах хувцас хэрэглэлийг бүрэн өмсөнө.<br>• Нэг удаагийн алчуур буюу самбай тавьж, халдваргүйжүүлэх бодис цацах буюу шүршиж халдваргүйжүүлнэ.<br>• Бохирлогдсон нэг удаагийн алчуур буюу самбайг халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.<br>• Халдваргүйжүүлэгч, угаалгын нунтаг бүхий алчууpаар арчина.<br>• Гар угаана. |
| Асгарсан, цацагдсан цус, биологийн шингэн их хэмжээтэй (диаметр-10 см-с их) | • Хувийн хамгаалах хувцас хэрэглэлийг бүрэн өмсөнө.<br>• Нэг удаагийн алчуур буюу самбайг тавьж, халдваргүйжүүлэх бодис цацах буюу шүршиж халдваргүйжүүлнэ.<br>• Бохирлогдсон нэг удаагийн алчуур буюу самбайг халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.<br>• Халдваргүйжүүлэгч бодис цацна.<br>• Тодорхой хугацааны дараа (халдваргүйжүүлэгч бодисын төрөл, агууламжаас шалтгаалан) арчина.<br>• Гар угаана. |

## Дөрөв: Мэс засал түүнтэй адилтгах өрөөний цэвэрлэгээ

4.1. Тухайн өдрийн мэс засал эхлэхийн өмнө тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбайг угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэх ба мэс засал эхлэхээс 1 цагийн өмнө дуусгасан байна.

4.2. Мэс ажилбар хооронд болон дараа тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч, бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбайг халдваргүйжүүлэгч уусмалын үйлдвэрлэгчийн зааврын дагуу халдваргүйжүүлэн угааж цэвэрлэнэ.

4.3. Тухайн өдрийн сүүлийн мэс заслын дараа тоног төхөөрөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч, бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбай зэргийг халдваргүйжүүлэгч, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэнэ.

4.4. Инженер техникийн ажилтан нь мэс заслын өрөөний техник хэрэгслүүд, тоног төхөөрөмжийн ажиллагааг тогтмол хянаж, цэвэрлэж, эвдрэл гэмтэл гарсан даруй засварлах арга хэмжээ авна.

4.5. Агаарын хэм тохируулагч, агаар сорох хэсгийг инженер техникийн ажилтан тогтмол шалган, долоо хоног тутам цэвэрлэж, засвар үйлчилгээ хийнэ.

## Тав: Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх давтамж

Эрүүл мэндийн байгууллагын дотоод орчинд халдварын эрсдэлийн зэргээс хамааран хамгийн багадаа доорхи давтамжтай цэвэрлэгээг хийж гүйцэтгэнэ.

| Эд хогшил | Цэвэрлэгээ хийх хамгийн бага давтамж | | |
|---|---|---|---|
| | өндөр эрсдэлтэй | дунд эрсдэлтэй | бага эрсдэлтэй |
| Лифт | Өдөр тутам | Өдөр тутам | Өдөр тутам |
| Тааз | Бохирлогдсон тохиолдолд | | |
| | Сард 2 удаа | Сард 1 удаа | Жилд 1 удаа |
| Шал | Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | Өдөр тутам |
| Цонхны гадна тал | Сард 2 удаа | Сард 1 удаа | Улиралд 1 удаа |
| Цонхны дотор тал | Өдөр тутам | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа |
| Дулааны халаагуур (радиатир) | Өдөр тутам | Долоо хоногт 1 удаа | Сард 1 удаа |
| Агааржуулалтын сараалж нүх | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | Сард 1 удаа |
| Тасаг нэгжид орох хаалга | Өдөр тутам | Өдөр тутам | Долоо хоногт 1 удаа |
| Өвчтөний өрөөний хаалга | Өдөрт 2 удаа | Өдөр тутам | |
| Хаалганы бариул | Өдөр тутам | Өдөр тутам | Өдөр тутам |
| Гэрлийн унтраалга | Өдөр тутам | Өдөр тутам | Өдөр тутам |
| Хөшиг | Сард 1 удаа | Сард 1 удаа | Сард 1 удаа |
| | Орны хөшиг - Долоо хоногт 1 удаа | Сард 1 удаа | |
| Ор | Өдөр бүр | Өдөр бүр | |
| Өвчтөний орны дэргэдэх ширээ | Өдөрт 2 удаа, хэрэглэсний дараа | Өдөр тутам | |
| Нярайн инкубатор | Өдөр бүр Үйлчлүүлэгч хооронд, 1 хүүхдэд хэрэглэж байвал 3 хоногт 1 удаа | | |
| Толь | Өдөр тутам | Өдөр тутам | Долоо хоногт 1 удаа |
| Өвчтөн зөөвөрлөх тэргэнцэр | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | |
| Эм био бэлдмэл хадгалах хөргүүр | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | |
| Эмийн шүүгээ | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | |
| Гар халдваргүйтгэгч уусмалын сав | Өдөр тутам, халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт | Өдөр тутам, халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт | Өдөр тутам, халдваргүйжүүлэгч уусмалыг солих бүрт |
| Матрас гудас | Өвчтөн хооронд, долоо хоногт 1 удаа | Өвчтөн хооронд, сард 1 удаа | |

| | | | |
|---|---|---|---|
| Гар угаалтуур | Хэрэглэсэний дараа өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | Өдөр тутам |
| Ариун цэврийн суултуур | Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | Өдөр тутам |
| Хогийн сав | Өдөрт тутам | Өдөр тутам | Өдөр тутам |
| Цэвэрлэгээний багаж, хэрэгсэл | Хэрэглэсний дараа | Хэрэглэсний дараа | Хэрэглэсний дараа |
| Дуслын хөл | Хэрэглэхийн өмнө ба дараа | Хэрэглэхийн өмнө ба дараа | |
| Дуслын шахуурга, хүчилтөрөгч оксиметр | Хэрэглэхийн өмнө ба дараа | Хэрэглэхийн өмнө ба дараа | |
| Зүрхний монитор | Хэрэглэсний дараа, өдөр тутам | Хэрэглэсний дараа, өдөр тутам | |
| Эмийн тэргэнцэр | Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | |
| Хог хаягдал зөөвөрлөх тэргэнцэр | Хэрэглэсний дараа | Хэрэглэсний дараа | Хэрэглэсний дараа |
| Цагаан хэрэглэл зөөвөрлөх тэргэнцэр | Хэрэглэсний дараа, Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | |
| Компьютер, принтер | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа |
| Компьютерийн гар | Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | Өдөрт 1 удаа |
| Суурин утас | Өдөрт 3 удаа | Өдөрт 2 удаа | Өдөрт 1 удаа |
| Зураг | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа | Долоо хоногт 1 удаа |
| Үйлчлүүлэгчийн өрөөний зураг | Үйлчлүүлэгч хооронд, өдөр тутам | Үйлчлүүлэгч хооронд, долоо хоногт 1 удаа | |

### Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээний үр дүнг үнэлэх

6.1. Халдвар хяналтын алба баг нь цэвэрлэгээний чанарт дотоодын хяналт хийнэ.

6.2. Дотоод хяналтыг дараах шалгуур хуудсаар үнэлж дүгнэнэ.

6.3. Үнэлгээг тийм онооны нийлбэр дүнг, үнэлгээ хийгдсэн асуумжийн авбал зохих оноонд харьцуулж хувиар гаргана.

| Цэвэрлэгээний шалгуур: | | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| **Нэг. Барилга байгууламжын хэсгийн цэвэрлэгээ** | | | |
| Галын гарц, хонгил, хонгилын шат, шатны бариул | Хонгилын шат, галын гарц, шат, үүдэвч, тоос шороогүй, аалзны тор, тамхины иш, шувууны сангас, шаралсан навч унаагүй хог хаягдалгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Хана, цонхны хүрээ, тааз | Хана, таазны дотор тал нь тоосгүй, толбогүй бохирдолгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Хана, таазны бэхэлгээ, тоноглолууд (унтраалга, залгуур) тоос, бохирдолгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Гэрлийн бүрхүүл нь тоосгүй, цэвэр байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| Цонхны дотор тал | Шилний гадаргуу, хүрээ, тавцан нь хурууны мөр болон бусад бохир, халтар толбогүй цэвэрхэн байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Хаалга | Хаалганы дотор болон гадна тал, хаалганы хүрээ нь тоос шороогүй, бохирдолгүй цэвэрлэгдсэн байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Шал | Шал, шалны хүрээ, булан тохой нь тоос шороогүй, бохир толбогүй, цаас болон хог хаягдал хаягүй, ус болон шингэн асгараагүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Цэвэрлэсэн нойтон шалан дээр явган хүн болгоомжтой явах талаар тэмдэглэгээ тавих. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Агааржуулах нүх | Агааржуулах нүх, агааржуулалтын хэсэг нь тоос шороогүй, ямар нэгэн өнгөр тогтоогүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| **Хоёр. Тавилга, хэрэгслийн цэвэрлэгээ** | | | |
| Цахилгаан хэрэгсэл | Цахилгаан хэрэгсэл нь тоос шороогүй, ямар нэг толбо, өнгөргүй байх | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Агаар сэлгэх мотор нь тоос шороогүй, бохирдолгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Тавилга | Тавилга, тавиур, ширээ, сандал, хувцасны шүүгээний гадаргуу нь толбо, өнгөргүй, тос, бусад зүйлсийг асгаагүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Тавилгын хөл, дугуйн хөлнүүд, тавилгын булан тохой, хүрээ, завсар нь бохир толбогүй, тоос шороогүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Агуулахын хэрэгсэл | Агуулахын хэсэг нь тоос шороогүй, ямар нэг зүйл асгараагүй, цэвэр байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Ариун цэврийн хэрэгсэл | Шаазан болон хуванцар гадаргуутай суултуур бүрэн, гэмтэлгүй, зэв үүсээгүй, бохир ямар нэг толбогүй, өнгөргүй, өтгөнөөр бохирлогдоогүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Ариун цэврийн өрөөний ханан дахь тавцангууд нь мөөгөнцөртөөгүй, тоосгүй цэвэр байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Ус дамжуулах хоолойнууд нь тоосгүй ямар нэг толбо үүсээгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Ариун цэврийн өрөөний хог хаягдлын сав нь хөл ажиллагаатай, тагтай, гэмтэл, хагаралгүй, цэвэрлэгдсэн байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |

| Гурав. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ | | | |
|---|---|---|---|
| Өвчтөнд хэрэглэх тоног төхөөрөмж | Өвчтөнд хэрэглэх тоног төхөөрөмж нь хүний цус болон бусад биологийн шингэнээр бохирлогдоогүй, ямар нэг бохир толбогүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Тоног төхөөрөмжийн хөл болон дугуйн хөлнүүд нь тоос шороогүй, ямар нэгэн бохир толбогүй, цэвэрхэн байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| Цэвэрлэгээний тоног төхөөрөмж | Цэвэрлэгээний материалыг өнгөөр ялгасан. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Цэвэрлэгээний бодис, хэрэгсэл хангалттай байх. /угаалгын нунтаг, халдваргүйжүүлэх уусмал, ахуйн бээлий гэх мэт / | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Цэвэрлэгээний материал хадгалах өрөөтэй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Цэвэрлэгээний тэргэнцэртэй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| | Цэвэрлэгээний тэргэнцэр нь тоос шороогүй, асгарсан шингэнгүй байх. | Үгүй | 0 |
| | | Тийм | 1 |
| **Нийлбэр оноо** | | | **.... /25** |

6.4. Тухайн байгууллагын нийлбэр онооны хувь 60%-аас бага байвал хангалтгүй, 60-70% бол дундаас доогуур, 71-90% дундаж, 91-100% байвал хангалттай түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээ авч ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06 сарын 02-ны өдрийн 187 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД НЭГ УДААГИЙН ЗОРИУЛАЛТААР ХЭРЭГЛЭХ БАГАЖ, МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

| Хэрэглээний төрөл | Жагсаалт |
|---|---|
| Нийтлэг хэрэглээ | • Хувийн хамгаалах хувцас (шүүлтүүртэй болон мэс заслын, нэг удаагийн амны хаалт, малгай, халад, бээлий, хормогч)<br>• Зүү, тариур<br>• Аюулгүй хайрцаг<br>• Уян зүү<br>• Боолтын материал<br>• Судасны уян гуурс<br>• Шээсний уут<br>• Давсагны шээлгүүр<br>• Нугасны хатгалтын зүү,<br>• Бургуйн хошуу,<br>• Хэл дарагч<br>• Гар арчих цаасан алчуур<br>• Хамрын хос гуурс<br>• Хүчилтөрөгчийн хошуувч<br>• Хэвтрийн эмчлүүлэгчийн дор дэвсэх жийргэвч дэвсгэр |
| Төрөх, эмэгтэйчүүд, нярай | • Төрөлтийн иж бүрдэл<br>• Нярайн иж бүрдэл<br>• Уян бинт<br>• Үтрээний толь, хүйн хавчаар, хамрын хос гуурс, ургийн ус хагалагч<br>• Эмэгтэйчүүдийн орны хулдаас, үр хөндөх вакум соруулах багажийн гуурс |
| Мэс засал, эрчимт эмчилгээ, | • Хагалгааны иж бүрдэл<br>• Боолтын иж бүрдэл<br>• Хатгалтын иж бүрдэл<br>• Стендийн иж бүрдэл<br>• Мэс заслын хутганы ир,<br>• Оёдлын зүү, утас,<br>• Зонд, эгэмний зүү дернажийн гуурс, интертусер, апкат зүү, зонд уртасгагч, амьсгалын гуурс, жижиг крант, чиглүүлэгч (проводник),<br>• Уушги тэлэгч, уушигны соруулагч самбар<br>• Тархи, хэвлийг холбогч гуурс,<br>• Соруулах гуурс, хошуу<br>• Урсгуур<br>• Гипсэн дотор өмсөх зөөлөвч<br>• Силденгерийн зүү, интертусер, апкат зүү, жижиг крант, |

| | |
|---|---|
| | чиглүүлэгч<br>• Зонд болон соруулгын гуурс хошуу<br>• Гарын хөөсрүүлэгч материал<br>• Түлэгчийн хошуу<br>• Дурангийн 1 удаагийн трокар<br>• Тэлэгч (эндоклип)<br>• Цөсний замын зураг авалтын гуурс<br>• Гемодиализын иж бүрдэл<br>• Хагалгааны талбай тусгаарлах даавуу<br>• Дурангийн аппартны хийлэгч гуурс<br>• Уян бинт<br>• Ивэрхий нөхөх тор<br>• Цус тогтоох губка<br>• Шархны наалт<br>• Шархны хавчаар (stepler)<br>• Шарх тусгаарлах наалт<br>• Судасны үдээс<br>• Тракор |
| Лаборатори | • Хуруу шил,<br>• Өндөг цоологч,<br>• Пипетикийн хошуу,<br>• Вакумтейнер<br>• Зүү<br>• Ийлдсийн сав, бамбар, сорьцны сав,<br>• Петрийн аяга, дусаагуур, гогцоо, бүрхүүл шил<br>• Цэрний сав, |
| Цусны алба, банктай газрууд | • Цусны уут, ийлдсийн сав |

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ТУСГААРЛАН СЭРГИЙЛЭЛТИЙН ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврыг ЭТҮХХ, халдварт өвчин, олон эмэнд тэсвэржсэн нян (ОЭТН)-ийн халдвартай үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага, ажилтнууд дагаж мөрдөнө.

1.2. Тусгаарлан сэргийлэлтийн үндсэн зарчим нь үйлчлүүлэгчдийн дунд болон үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтны хооронд халдвар дамжин тархахаас сэргийлэхэд оршино.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгаарлах арга хэмжээг зохион байгуулна. Хэвтэн эмчлэх, сувилах үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллага бүр халдварын сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөө, клиник, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд түр тусгаарлах боломжоор хангагдсан байна.

1.4. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварууд, цочмог халдварт өвчтэй, хоёрдогч халдвар, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай, халууралт, суулгалт, бөөлжилт, ханиалгах, тууралтат халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг тусгаарлах арга хэмжээ авна.

1.5. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварууд, цочмог халдварт өвчтэй үйлчлүүлэгчийг халдвартын эмнэлэг, тасагт, уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй үйлчлүүлэгчийг сүрьеэгийн эмнэлэг, тасагт, ЭТҮХХ, хоёрдогч халдвар, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийг тасагт нь тусгаарлана.

## Хоёр. Халдвартай үйлчлүүлэгчийг тусгаарлан сэргийлэх ерөнхий зарчим

2.1. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин, тархах эрсдэл өндөртэй, өндөр хоруу чанартай үүсгэгчээр үүсгэгдсэн халдварын үед үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөнд (чанд тусгаарлалт-strict isolation) тусгаарлана. Тусгаарлах өрөө нь агаарын сөрөг даралттай байна. Үйлчлүүлэгчийг нэг нэгээр нь байрлуулж, тусгаарлах өрөөнд ороходоо иж бүрэн хувийн хамгаалах хэрэгслийг өмсөнө.

2.2. Үүсгэгч нь агаар дуслын замаар тархах эрсдэлтэй, халдварын үед амьсгалын замын тусгаарлалт (respiratory isolation) хийнэ. Үйлчлүүлэгчийг тусгай өрөөнд байлгана. Нэг төрлийн үүсгэгчээр үүсгэгдсэн халдвартай үйлчлүүлэгчдийг нэг өрөөнд байлгаж болно Уушгины сүрьеэтэй, цэрэнд Mycobacterium tuberculosis илэрсэн үйлчлүүлэгчийг агаарын шүүлтүүртэй, сөрөг даралттай өрөөнд тусгаарлаж, орох хүн бүр шүүлтүүртэй амны хаалт хэрэглэнэ.

2.3. Шууд болон дам хавьтлаар тархдаг халдварын үед хавьтлын тусгаарлалт (contact isolation) хийнэ. Нэг төрлийн үүсгэгчээр үүсгэгдсэн халдвартай үйлчлүүлэгчдийг

нэг өрөөнд байлгаж болно. Үйлчлүүлэгчтэй ойр зайд харьцах хүн амны хаалт зүүх, бөөлжих зэрэг эрсдэлтэй үед хормогч, бээлий өмсөнө.

2.4. Цус, биеийн шингэнээр халдвар дамжин тархах өндөр эрсдэлтэй үед үйлчлүүлэгчийг тусгаарлах шаардлагагүй. Үйлчлүүлэгч, түүний биеийн шингэнтэй хүрэлцэх бол халад, бээлий хэрэглэнэ.

2.5. Хавьтал, амьсгалын замаар дамжих халдварын үед ор хоорондын зай 2 метр байна. Өрөө, тасалгаа хүрэлцэхгүй тохиолдолд өвчтний ор хоорондын зайг аль болох хол, гэхдээ толгой-хөл гэсэн зарчмаар зөрүүлж байрлуулна.

2.6. Дэгдэлтийн үед ижил халдвартай эмчлүүлэгчдийг бүлэглэн байрлуулах бөгөөд эдгээр өрөөнүүд нь бусад халдвар аваагүй эмчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг хэсгээс тусгаарлагдсан хэсэгт (өрөө болон тасаг) байна.

## Гурав. Тусгаарлах өрөөнд (чанд тусгаарлалт) баримтлах дэглэм

3.1. Тусгаарлах өрөө нь хөл хөдөлгөөнөөс зайдуу, гадагш нэвт гарах хаалгатай, агаарын сөрөг даралттай, халдвараас сэргийлэх дэглэм мөрдөх нөхцөлийг хангасан, дотроо бие засах өрөө, гар угаах угаалтууртай байна.

3.2. Тусгаарлах өрөө нь халдвартай, завсрын, халдваргүй гэсэн 3 бүстэй байна.

3.2.1. Халдвартай бүс /Улаан бүс буюу үйлчлүүлэгчийн өрөө/: Үйлчлүүлэгчийн өрөө нь агаарын сөрөг даралттай байна.

3.2.2. Завсрын бүс /Шар бүс буюу дамжин өнгөрөх өрөө/: Энэ өрөөнд хамгаалалтын хувцсыг тайлах, халдваргүйжүүлэлт хийнэ. Хог хаягдлын уут, сав байна.

3.2.3. Халдваргүй бүс /Ногоон бүс/ нь - Эмнэлгийн бусад хэсэг.

3.3. Тусгаарлах өрөөний хаалганы гадна халдвартайг илтгэх тэмдэглэгээтэй, хаалгыг байнга хаалттай байлгана.

3.4. Тусгаарлах өрөөнд орохын өмнө халдваргүй бүсэд хамгаалах хувцас хэрэгслийг иж бүрэн өмсөнө.

3.5. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний сэжиг бүхий үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөний гаднах хаалгаар оруулна. Эмнэлэг дотор оношилогдож өөр тасаг нэгжээс шилжиж ирж байгаа бол үйлчлүүлэгчид шүүлтүүртэй амны хаалт зүүлгэж, дотор хаалгаар оруулна.

3.6. Тусгаарлах өрөөний багаж, хэрэгслийг өөр тасгуудад дамжуулж хэрэглэхгүй, нэг удаагийн багаж хэрэгслийг давтан хэрэглэхгүй. Давтан хэрэглэдэг багаж хэрэгсэл ашигласан тохиолдолд зориулалтын бикс, зөөврийн сав, контейнероор битүүмжлэн ариутгалын тасагт хүргэнэ.

3.7. Цагаан хэрэглэлийг угаахаас өмнө халдваргүйжүүлнэ. Эсвэл шууд устгалд оруулна.

3.8. Лабораторийн шинжилгээний сорьцыг “биоаюултай” гэсэн тэмдэглэгээ бүхий зориулалтын тагтай саванд битүүмжлэн зөөвөрлөнө.

3.9. Өвчний түүх бусад баримт бичиг, хамгаалах хувцас хэрэгсэл (бээлий, халад, амны хаалт гм)-ийг тусгаарлах өрөөний гадна талд хадгална.

3.10. Дархлаажуулалт бүхий халдварын үед тусгаарлах өрөөнд тухайн халдварын эсрэг дархлаатай ажилтныг сонгон ажиллуулна.

3.11. Эргэлтийг хязгаарлана. Зайлшгүй шаардлагаар орох тохиолдолд халдвараас сэргийлэх дэлгэрэнгүй зааварчилгаа өгч эмнэлгийн ажилтны нэгэн адил иж бүрэн хамгаалах хувцас өмсөнө.

3.12. Эмнэлгийн бусад хэсэгт халдвар дамжихаас сэргийлж халдвартай үйлчлүүлэгчийг тусгаарласан өрөөнөөс зөөвөрлөх, шилжүүлэхийг хязгаарлана. Зайлшгүй шаардлагаар шилжүүлэх бол халдвар дамжих зам, тархах эрсдлээс хамаарч сэргийлэх арга хэмжээ авна.

## Дөрөв. Халдвар тархахаас сэргийлэх

4.1. Үйлчлүүлэгчдийн дунд цочмог халдварт өвчин оношлогдвол тухайн халдварт өвчний удирдамжийн дагуу халдвараас сэргийлэх арга хэмжээг авна.

4.2. Амьсгалын замын халдварын шинжтэй үйлчлүүлэгчдийг эмнэлэгт гаднаас орж ирэхэд нь амны хаалт зүүлгэнэ.

4.3. Амбулатори, өрх, клиникийн эмнэлэгт үйлчлүүлэгчийг ОУЭМД-ээр зохицуулагддаг халдварын сэжигтэй гэж оношилсон тохиолдолд үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтнуудад амны хаалт зүүлгэн орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж түргэн тусламж дуудна. Түргэн тусламж дуудахдаа халдварын сэжигтэй гэдгийг анхааруулна.

4.4. Хэвтэн эмчлэх, сувилах тасаг, нэгжүүдэд хоёрдогч халдвар, метициллинд тэсвэртэй алтлаг стафилококк (MRSA), ванкомицинд тэсвэртэй энтерококк (VRE), өргөтгөсөн үйлдэлтэй беталактамаза ялгаруулдаг нян, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийг тасаг, нэгжид нь нэг хүний өрөөнд тусгаарлана. Халдвар тархахаас сэргийлж дараах арга хэмжээг авч ажиллана.

4.4.1 Тусгаарласан өрөөний хаалганд анхааруулга тэмдэглэгээг тавина. Халдвараас сэргийлэх дэглэмийг эмнэлгийн ажилтнууд, эргэлтээр ирэгсэд бүгд дагаж мөрдөнө

4.4.2 Тухайн үйлчлүүлэгчтэй харьцах ажилтны тоог аль болох хязгаарлаж, боломжтой бол тусламж үзүүлэх эмнэлгийн ажилтныг тусад нь томилон ажиллуулна. Ил шарх, арьсны тууралттай ажилтнуудыг ажиллуулахгүй.

4.4.3 Үйлчлүүлэгчийг өөр тасагт шилжүүлэх бол очих тасаг нэгжийн ажилтнуудад өвчтөний халдварын талаар мэдэгдэнэ. Шилжүүлэх тохиолдолд халдвар дамжих зам, тархах эрсдэлээс хамаарч сэргийлэх арга хэмжээ авна.

4.4.4 Өвчний түүх, жор, халуун, зүрхний цохилт, даралт тэмдэглэх хуудсуудыг тасгийн гадна байрлуулна.

4.4.5 Тусгаарласан өрөөнд орохдоо хамгаалах хувцас хэрэгслийг өмсөнө.

4.4.6 Өрөөний цонх нээж, хаалгыг байнга хаалттай байлгана

4.4.7 Гар угаах дэглэмийг чанд мөрдөнө.

4.4.8 Мэс засал, дуран, боолтын өрөөнд шархыг цэгцлэх үед хормогч, бээлий өмсөнө. Бохир боолтын материалыг улаан өнгийн уутанд цуглуулан шууд битүүмжлэн устгана. Давтан хэрэглэгдэх багаж хэрэгслийг төвлөрсөн ариутгалын тасагт хүргүүлэхээс өмнө халдваргүйжүүлнэ.

4.4.9 Цагаан хэрэглэл, хөнжлийг бохирдсон тохиолдол бүрт солино.

4.4.10 Эргэлтийг аль болох хязгаарлах, эргэлтээр ирсэн хүмүүсийг үйлчлүүлэгч болон түүний орчны эд зүйлд хүрэхгүй байхыг анхааруулна.

4.4.11 Үйлчлүүлэгчийн өрөөнд амны хаалт, халад, бээлий, малгай, улавчийг шууд тайлж, шар өнгийн уутанд цуглуулна.

4.4.12 Цэвэрлэгээний ажилтнуудад өрөөг тусдаа алчуур, хэрэгслээр цэвэрлэх ёстойг анхааруулна. Өрөөнд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг энэхүү тушаалын 5 дугаар хавсралтын дагуу хийнэ.

4.4.13 Даралтын аппарат, чагнуур, пульсоксиметр, халууны шил, хэт авианы аппаратны хулгана, зүрхний цахилгаан бичлэг хийх аппаратын холболтын хавчаар зэрэг үйлчлүүлэгчдэд үзлэг оношлогоо хийхэд хэрэглэсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашигласны дараа 70% спиртээр арчиж халдваргүйжүүлнэ.

4.4.14 Үйлчлүүлэгч эмнэлгээс гарахад өрөөнд их цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ. Цагаан хэрэглэл, хөшгийг халдваргүйжүүлж, угаана.

4.5. Сүрьеэгийн эмнэлэг, тасагт сүрьеэгийн халдвартай үйлчлүүлэгчийг халдвартай, халдваргүй, эмэнд тэсвэржилт зэргээр нь ялгаж тусгаарлан хэвтүүлнэ..

4.5.1. Уушгины идэвхтэй хэлбэрийн, түрхэц эерэг, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй үйлчлүүлэгчдэд тусламж үзүүлэхдээ эмнэлгийн ажилтан, сахиур, эргэлтээр ирэгсэд N95 болон шүүлтүүртэй амны хаалтыг зүүнэ.

4.5.2. Үйлчлүүлэгч бусад тасгаар оношилгоо хийлгэхээр явахдаа амны хаалтыг байнга зүүнэ.

4.5.3. Гуурсан хоолойг дурандахдаа сүрьеэгийн хэлбэрээс нь үл хамааран N95 болон шүүлтүүртэй амны хаалт зүүж, халад бээлий өмсөнө.

4.5.4. Амбулаторийн үзлэгийн үед ханиалгаж байгаа үйлчлүүлэгчдэд амны хаалт зүүлгэнэ.

12

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# ШҮДНИЙ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДЭГЛЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврыг шүдний тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бүх эмнэлгүүд дагаж мөрдөнө.

1.2 Шүдний эмнэлгийн байр нь эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй байдлыг хангасан, халуун, хүйтэн усанд холбогдсон, хана, тааз нь угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой, гадаргуу нь гөлгөр, нүх, заадалгүй байна.

1.3 Төвлөрсөн шугамны шүүлтүүргүй усыг шүдний өрмийн төхөөрөмж, хэт авианы цэвэрлэгч, үйлчлүүлэгчийн шүдний эмчилгээ, ам зайлахад хэрэглэхгүй, шүдний эмчилгээнд ундны усны стандартыг хангасан усыг хэрэглэнэ.

1.4 Хүүхдийн үзлэгийн болон эмчилгээний өрөө нь насанд хүрэгчдийнхээс тусдаа, хүүхдэд зориулсан орчинг бүрдүүлсэн байна.

1.5 Үзлэгийн өрөөнд багаж, эм материал болон бусад хэрэгслийг ил задгай хадгалах, байршуулах, амьд болон хиймэл цэцэг, чимэглэл, хивс, дрож гэх мэт тоос, шороо цуглуулах зүйлс тавихгүй.

1.6 Нэг эмч 1-2 сувилагчтай ажиллана.

1.7 Мөнгөн усны хольцтой /амалгаман/ пломбо хэрэглэхгүй.

1.8 Өрмийн төхөөрөмжинд холбогдсон шугам нь ус шүүгчтэй эсвэл шүүсэн усыг хэрэглэнэ.

## Хоёр. Эмнэлгийн орчин, баримтлах дэглэм

2.1. Эмнэлгийн орчныг энэхүү тушаалын 5 дугаар хавсралтын дагуу халдварын эрсдлийн зэргээр ангилж, цэвэрлэгээг хийнэ.

2.2. Үзлэг бүрийн дараа хэрэглэгдсэн хэт авианы чулуу авагч, агаар усны шүршүүр зэрэг хүний ам руу ордог ус агаартай холбоотой бусад төхөөрөмжийн ус ба агаарыг 20-30 хором урсгаж гоожуулна.

2.3. Шүдний тусламж үйлчилгээг үзүүлж байгаа үзлэгийн өрөөг дараах байдлаар ангилан, халдварын эсрэг дэглэм баримтлан ажиллана.

| Бүс | Хамаарагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгслүүд | Ажиллах эмнэлгийн мэргэжилтэн | Баримтлах дэглэм |
|---|---|---|---|
| Эмнэлзүйн бүс | Шүдний тусламж үйлчилгээний тоноглол бүхий | Эмч дангаараа буюу | ✓ Үзлэг бүрийг эхлэхийн өмнө тухайн эмчилгээнд хэрэглэгдэх багаж, хэрэгслийг ариун |

| | | | |
|---|---|---|---|
| | үзлэгийн ор, орны дагалдах хэрэгсэл, тавцан, өрөмний суурь, рентген зураг харах дэлгэц, соруулгын хошууны суурь болон хоолойнууд, шүлсний сав, тосгуурын цорго, сандлын товчлуур, эмч сувилагчийн үзлэгийн сандал | сувилагчийн хамт | дэлгэц цаас буюу никель тавиур дээр байршуулна. Мөн рентген зураг, нэг удаагийн бохирын сав, энгэрэвч, зэргийг үзлэгийн тавцанд тавьж бэлдэнэ.<br>✓ Тоног төхөөрөмжийн солих боломжгүй хүрэлцэх гадаргуу, бариул (ус, агаарын, соруулагчийн), пломбо шарах гэрлийн аппаратны хошуунд нэг удаагийн хамгаалалтын наалт наана.<br>✓ Үзлэг бүрийн дараа гадаргуугийн уут, ороогч цаасыг гадаргууг бохирдуулахгүйгээр авна.<br>✓ Үзлэг, эмчилгээний явцад бохирлогдсон хөвөн, марль, хазалтын цаас, сувгийн цаас, илүүдэл материал зэргийг хог хаягдлын бохирын сав руу шууд хаяна.<br>✓ Сувгийн эмчилгээний үед бохирдсон суваг өргөсгөгчийг цэвэрлэхдээ ариутгасан сальфеткаар арчих, эсвэл зориулалтын сувгийн багаж цэвэрлэгч сав бүхий даавуу болон самбайгаар цэвэрлэнэ. Самбайг үжлийн эсрэг уусмалаар норгож чийглэнэ.<br>✓ Үзлэг, эмчилгээ дуусмагц хэрэглэгдсэн бүх зүйлсийг ялган ангилалт хийж нэг удаагийн багаж хэрэгслийг устгалд оруулна.<br><u>Аюулгүй хайрцаганд:</u><br>Сувгийн хар зүү<br>Зөөлц авагч<br>Хутганы ир<br>Зүү, 1 удаагийн тариур<br>Ампул<br>Дахин хэрэглэгдэх боломжгүй сувгийн багаж зэргийг хаяна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Шар уутанд:<br>1 удаагийн сорогчийн хошуу<br>Хөвөн марлин бөмбөлөг,<br>Сувгийн цаас, трунд<br>Хазалтын цаас<br>Илүүдэл материалууд<br>Халдваргүйжүүлэлт хийсэн самбай<br>Гадаргуугийн нааалтууд<br>Бээлий, малгай, амны хаалт<br>✓ Давтан хэрэглэгдэх бохир багаж, хэрэгслийг зориулалтын шингэн нэвтрэхгүй, тагтай саванд хийж, ариутгалын тасаг, хэсэг рүү шууд зөөвөрлөнө.<br>✓ Үзлэгийн ор бүрийн хажууд аюулгүй хайрцгийг байрлуулна.<br>✓ Өрөө бүрт гарын угаалтуур, шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэгч, гишгүүр бүхий эмнэлгийн хог хаягдлын сав байна.<br>✓ Бага бохирдолтой хэсгийн гадаргуугаас эхлэн бохирдол ихтэй хэсгийн гадаргуу руу нэг чиглэлээр арчиж халдваргүйжүүлнэ.<br>✓ Өрөм болон хий, усны, чулуу авагчийн хошууны суурь, хоолойн гадаргууг маш их бохирдолтой гэж үзэн халдваргүйжүүлэх бодис шүршиж арчих эсвэл халдваргүйтгэлийн бодистой нэг удаагийн самбайгаар арчина.<br>✓ Үзлэгийн орны тавцанд багаж, материалыг байнга байршуулах, үлдээхийг хориглоно.<br>✓ Өдрийн үзлэг дууссаны дараа үзлэгийн орны шугамын халдваргүйжүүлэлтийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийнэ. |
| Цэвэр бүс буюу дээрх бүсээс гадагш 1-1,5 м зайд хамаарах хэсэг | Ариутгасан багаж хэрэгсэлтэй сав, хөвөн, самбай, ариун бээлий, гэрлийн аппарат хэрэгсэл, эмчилгээний болон пломбоны материалууд ханын шүүгээ саванд далд байрлана. | Сувилагч | ✓ Цэвэр бүсийн сувилагч 2-3 эмчийн дунд ажиллаж болно.<br>✓ Ариутгасан багаж хэрэгслийг ханын битүү шүүгээ саванд хуурай, тоосгүй орчинд хадгална.<br>✓ Ариутгалын хугацаа нь ариутгасан багажны савалгаан дээр тэмдэглэсэн байна.<br>✓ Ариутгасан багажийг ариутгасан хугацаагаар нь эхэлж хэрэглэх байдлаар байршуулна.<br>✓ Хэрэглэхийн өмнө уутны бүтэн байдал алдагдаж бохирдох, хадгалах хугацаа дууссан эсэхийг хянана.<br>✓ Цэвэр бүсийн сувилагч нь гарын эрүүл ахуйн дэглэмийг баримтлан эмнэлзүйн бүсэд ажиллаж байгаа эмч, сувилагчид шаардлагатай ариун багаж, цэвэр материалыг зааврын дагуу нэмэлтээр бэлдэж, дамжуулж өгнө.<br>✓ Гэрлээр хатуурагч хуванцар материалыг хэрэглэх тохиолдолд зориулалтын саванд таслан авч, дамжуулж өгнө.<br>✓ Үзлэг эхлэхийн өмнө ба дараа гадаргуугийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.<br>✓ Цэвэр бүсийн сувилагч эмнэлзүйн бүсэд давхар ажиллахгүй.<br>*Цэвэр бүсэд ажиллах сувилагч түр хугацаагаар байхгүй тохиолдолд :*<br>✓ Эмнэлзүйн бүсэд ажилласан бээлийтэй гараар цэвэр бүсэд нэвтрэх, ариун багаж, цэвэр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | материал, эд зүйлстэй харьцахыг хориглоно.<br>✓ Цэвэр багаж, материалтай харьцах үед нэмэлтээр цэвэр хямсаа хэрэглэнэ.<br>✓ Хямсаагаар авах боломжгүй нягт эргэдэг таглаатай, сав баглаа боодолтой зүйлтэй харьцах тохиолдолд бээлийг тайлж, гарыг угаасаны дараа дахин бээлий өмсөж харьцана. |
| Эрсдэлгүй бүс буюу цэвэр бүсээс гадагш хамаарах бүх хэсэг | Эмчийн тэмдэглэл хөтлөх ширээ, журнал, компьютер, үзэг, үзлэгийн карт | Эмч, сувилагч | ✓ Үзлэг эхлэхийн өмнө ба дараа гарын эрүүл ахуйг сахина.<br>✓ Үйлчлүүлэгчид хэрэглэгдсэн ариун багажны хяналтын цаасан туузыг үйлчлүүлэгчийн карт буюу журналд нааж үйлчлүүлэгч баталгаажуулна. |

2.4 Дээрхи бүсүүдэд үзлэг бүрийн дараа эрсдэлгүй бүсээс эхлэн цэвэр бүс, эмнэлзүйн бүс гэсэн дарааллаар халдваргүйжүүлэлт хийнэ

2.5. Гадаргуугийн хамгаалалтыг солих боломжгүй хүрэлцэх гадаргуу болох шүдний креслын толгой, удирдах товчлуурууд, гэрлийн бариул, товчлуурууд, шүлс сорогчийн хоолой болон удирдлага, рентгений товчлуур, ус агаарын шүршигчийн бариул, үйлчлүүлэгчийн толины, гэрлийн аппаратны бариул ба хошуу, үзлэгийн орны тавцан зэрэг үйлчлүүлэгч болон эмнэлгийн ажилтны гар хүрэлцэх хэсгүүдэд халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх зорилгоор өнгөгүй, нийлэг ороолт, уут хоолой, нийлэг тууз, нийлэг артай цаас зэрэг гадаргуугийн наалтыг хэрэглэнэ.

2.6. Эрүү нүүрний жижиг мэс ажилбар (шүд авахаас бусад), шүдний имплант хийх эмнэлэг нь мэс ажилбарын өрөөтэй байх ба өрөө нь мэс заслын өрөөнд тавигдах шаардлагыг хангасан байна. Мэс ажилбарын өрөө нь шүдний ор эсвэл мэс заслын ор, шүлс соруулагч зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж, эм, багаж, хэрэгслээр хангагдсан, тоног төхөөрөмжид гадааргуугын хамгаалалтыг хэрэглэж халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөнө. Мэс ажилбарын өрөөнд ажиллах эмч, сувилагч ариун бээлий, халад, малгай өмсөж ариун багаж хэрэгслийг ашиглаж 6 гараар (1 эмч, 2 сувилагч) ажиллана. Мэс ажилбарын өрөөгүй, шаардлага хангаагүй эмнэлэгт эрүү нүүрний жижиг мэс ажилбар (шүд авахаас бусад), имплант хийхийг хориглоно.

2.7. Үзлэг бүрийн дараа бээлийг тайлахаас өмнө халдварлагдсан хамгаалалтын наалтыг болгоомжтой авч эмнэлгийн хог хаягдлын саванд хийж, бээлийг тайлан гарын эрүүл ахуйг сахина.

2.7. Гадаргууд хамгаалалтын наалт наасан, наагаагүй байснаас үл хамааран үзлэг бүрийн дараа өдөр бүр ажлын эхэнд болон төгсгөлд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийнэ.

2.8. Хамгаалалтын уут, ороогч гялгар цаасыг нэг удаа хэрэглээд хаяна.

## Гурав. Шүдний тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх багаж хэрэгслийн ангилал

3.1. Багаж хэрэгслийг хэрэглэх байдлаас шалтгаалж халдвар дамжуулах эрсдэл дээр тулгуурлан доорх байдлаар ангилна.

| Багажны ангилал | Багажны эрсдэл |
|---|---|
| Өндөр эрсдэлтэй | Өндөр эрсдэлтэй багажинд зөөлөн эд болон ясанд нэвтрэхэд ашиглагддаг бахь, чулуу авагч, чулуу авагчийн хошуу, ясны цүүц, мэс заслын багаж, бахь, ёзоор авагч (элеватор), зажем, яс хусагч, хагалгааны багажнууд, өрөм, үзлэгийн хямсаа, зонд, экскеватор, гладильник, зүү баригч, рабар дамын хавчаар, сувгийн багажнууд, төмөр матриц зэрэг орно. |
| Дунд зэргийн эрсдэлтэй | Дунд зэргийн эрсдэлтэй салст, шүлс, гэмтэлтэй арьсанд хүрэлцэх багажууд. Үүнд: Ам тэлэгч, толь, ус, агаар шүршигчийн төмөр хошуу, шүлс сорогчийн төмөр хошуу, хуванцар бариултай сойз, баригч, рентген хальс баригч, мэс заслын хайч, нэг удаа хэрэглэхээр савлагдсан пломбоны материал шахагч буу, шүдний өнгө тохируулагч, хиймэл шүдэлбэр өнгөлөх чулуу, резин, шётка зэрэг орно. |
| Бага эрсдэлтэй | Халдвар тараах эрсдэл багатай багаж хэрэгсэлд, зөвхөн бүтэн арьсанд хүрэлцдэг рабар дамын хүрээ, хэвний материал шахагч буу,нүүрний нум тогтоогч, рентген аппаратын толгой, хормогч, гэрлийн аппарат, нүүрний халхавч, нүдний шил, энгэрэвч зэрэг багаж, хэрэгсэл орно. |

3.2 Өндөр болон дунд эрсдэлтэй багаж хэрэгслийг халдваргүйжүүлж, угааж, ариутгана. Бага эрсдэлтэй бол халдваргүйжүүлж угаана, ариутгал хийх шаардлагагүй.

3.3. Нэг удаагаар хэрэглэх багаж, хэрэгсэлд доор дурдсан багаж хэрэгсэл багтах бөгөөд үзлэг, эмчилгээнд хэрэглэсэний дараа аюулгүй хайрцаг, эмнэлгийн хог хаягдлын саванд шууд хаяна. Үүнд:

- Зүү
- Тариа
- 1 удаагийн тариур
- Хутганы ир
- Оёдлын утас
- Багс
- Зөөлц авагч
- Сувгийн хар зүү
- Брекет
- Бөгж
- Нум
- Тюба

- Легатурын утас
- Резин (өнгийн, холбогч, татлагын, зай гаргагч)
- Урьдчилан сэргийлэх үзлэгт зориулагдсан үзлэгийн багц
- Цаасан энгэрэвч
- Бээлий
- Гадаргуугын наалт
- Шүлс сорогчийн хуванцар нарийн хошуу
- Ус агаар шүршигчийн хуванцар хошуу

3.4. Нэг удаагийн багаж, хэрэгслийг дахин ариутгаж хэрэглэхгүй.

## Дөрөв. Шүдний эмнэлэгт давтан хэрэглэгдэх багаж, хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах, хадгалах тээвэрлэх, түгээх явц

4.1. Шүдний тусламж үйлчилгээнд давтан хэрэглэгддэг багаж, хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах, хадгалах, тээвэрлэх, түгээх үйл явц нь энэ тушаалын 2 дугаар хавсралтын дагуу зохицуулагдана.

4.2. Шүдний эмнэлгийн ариутгалын хэсэг нь шүдний багаж, хэрэгсэл цэвэрлэн халдваргүйжүүлэх, ариутгахад зориулагдсан ариун, цэвэр, бохир бүсээр тусгаарлах боломжтой өрөөтэй, энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын шаардлагыг хангасан байна.

4.3. Ариутгалын хэсгийг зохион байгуулах боломжгүй шүдний эмнэлэг нь шаардлага хангасан мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болох бөгөөд бохир багаж хэрэгслийг халдваргүйжүүлсэний дараа шилжүүлнэ.

4.4. Ариутгалын хэсэг нь нүүр амны тусламж үйлчилгээний төрөл, хэрэглэгдэж буй багаж материалын тоо, овор, хэмжээнээс хамааран дараах тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, анхан шатны бүртгэл маягтуудтай байна. Үүнд:

4.3.1 Уурын автоклав

4.3.2 Өрмийн хошуу ариутгагч

4.3.3 Хатаах шүүгээ

4.3.4 Угаагч машин, хэт авианы угаагч аппарат

4.3.5 Ус нэрэгч, шүүгч, ус хэмжигч

4.3.6 Томруулдаг шил

4.3.7 Уут наагч машин

4.3.8 Багаж боох зориулалтын даавуу ба цаас, цаасан уут

4.3.9 Багажны угаалга хийх зориулалттай зэвэрдэггүй төмрөөр (нержээр) хийгдсэн тосгуур

4.3.10 Гар угаах тосгуур

4.3.11 Химийн хяналтын өнгө хувиргагч цаасан тууз (индикатор)

4.3.12 Халуунд тэсвэртэй нянгийн тест (сорил), термостат

4.3.13 Ширээ, сандал, тавиур

4.3.14 Угаалга хийх сав, ёрш, урт бариултай сойз

4.3.15 Халдваргүйжүүлэгч бодис

4.3.16 Сэрүүлэгтэй цаг

4.3.17 Багажны савалгаанд ариутгасан болон дуусах хугацааг тэмдэглэх дардас

4.3.18 Тэмдэглэл бичих үзэг, бал

4.3.19 Анхан шатны бүртгэлийн маягтууд

4.5. Шүдний эмнэлгийн ариутгалын хэсэг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон халдваргүйжүүлэлт, ариутгалын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл хяналттайгаар суурилуулан ажиллуулна.

4.6. Багаж хэрэгслийг халдваргүйжүүлэх, угаах, ариутгах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ тухайн багажны хэрэглэх зориулалт, материалын халуунд тэсвэрлэх чанар, хэлбэр хэмжээнээс хамаарч халдваргүйжүүлэлт, ариутгал хийнэ. Ариутгал, халдваргүйжүүлэлтэд улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны заавар нь зохих журмаар баталгаажсан бодисыг сонгон хэрэглэнэ. Бодисыг хэрэглэх, найруулахдаа үйлдвэрлэгчийн зааврыг баримтлана.

4.7. Шүдний зарим багаж хэрэгслийн онцлогоос шалтгаалан халдваргүйжүүлж, угаах, ариутгахдаа дараах зүйлийг анхаарна.

4.7.1. Халдваргүйжүүлэлт хийхдээ уусмалд багаж бүрэн дүрэгдсэн байхаар хийнэ. Бодисын халдваргүйжүүлэлт хийх хугацааг барина.

4.7.2. Багажийг гараар угааж байгаа тохиолдолд сойз хэрэглэж зай завсарыг бүрэн цэвэрлэнэ. Ультрасоник болон багажны угаалгын автомат машиныг ашиглаж болох ба энэ үед сойздон угаах шаардлагагүй.

4.7.3. Халдваргүйжүүлэлт хийсний дараа халдваргүйтгэх бодисын үлдэгдэл багажнаас арилтал цэвэр усаар сайтар зайлна.

4.7.4. Багаж хэрэгслийг хатаасны дараа зориулалтын цаасанд үзлэг, эмчилгээнд хэрэглэгдэх байдлаар нь багцалж савлана.

4.7.5. Сувгийн багаж, өрөмийг хэрэглээнээс хамаарч багцалж, эсвэл ширхэгээр нь савлаж ариутгана. Сувгийн багажийг багцаар ариутгахдаа зориулалтын нүхэн суурьтай төмөр саванд байршуулж ариутгана. Ширхэгээр савлан, битүүмжилж ариутгасан сувгийн багаж, өрөмийг цэвэр саванд задлахгүйгээр ариутгасан савалгаатай нь байршуулж хэрэглэнэ. Өрмийг ариутгасны дараа зориулалтын тавиурт (хуванцар, битүү тагтай нүх бүхий суурьтай) хийх бол тавиурыг химийн аргаар ариутгасан байна. Багажны ариутгасан сар өдрийг тэмдэглэнэ.

4.7.6. Автоклавт ариутгахын өмнө индикаторын цаас бүрэн наагдсан, тэмдэглээ бүрэн хийгдсэн эсэх, битүү савалгаатай байгаа эсэхийг шалгана.

4.7.7. Хэрэглэхийн өмнө ариутгасан багаж, хэрэгслийн битүүмжлэл алдагдсан эсэхийг шалгана. Битүүмжлэл алдагдсан цоорсон, урагдсан, иртэй багаж, хэрэгслийн үзүүр ил гарсан тохиолдолд хэрэглэхгүйгээр ариутгалын хэсэг рүү буцаана.

4.7.8. Савлаж ариутгасан багаж хэрэгслийн битүүмжлэл алдагдаагүй бол 14 хоног дотор хэрэглэж болно.

4.7.9. Сувгийн эмчилгээнд нэг удаагаар хэрэглэгдэх зөөлц авагч болон сувгийн хар зүүг анх хэрэглэхээс өмнө химийн аргаар ариутгана.

4.7.10. Шүдэлбэр, хэв, хазалтын тэмдэглэл, хоршихуйн хэрэгслийг цэвэрлэж, хэвний материалын шинж чанарт нөлөөлөхгүй халдваргүйжүүлэгч бодисоор шүршиж халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар шүрших буюу зайлна.

4.7.11. Хиймэл шүдний лабораторид хэрэглэдэг өрөм, өнгөлөгч, шлиф, мотор гэх мэт төхөөрөмжийг өндөр халуунд тэсвэрлэх чанар эсвэл бохирдлын зэргийг харгалзан өндөр даралтын уур, хуурай халуун, химийн аргын аль нэгээр ариутгах ба халдваргүйжүүлнэ.

4.12. Хурдан эргэлттэй шүдний өрмийн хошууг төхөөрөмжөөс салгахын өмнө шугамын усаар 10 – 20 сек орчим хурдан шүршиж, өрмийн толгойд байгаа үйрмэг, гадны биетийг зайлуулна.

4.13. Өрмийн толгой (наконечик) хэрэглэсний дараа салган авч халдваргүйжүүлэлт, ариутгал хийнэ. Өрмийн толгойг зориулалтын тосоор тосолно. Өрмийн суурь хэсгийг өдөр бүрийн үзлэгийн дараа халдваргүйжүүлж цэвэрлэнэ.

4.14. Гэрэлтэй өрмийн толгойг этилийн болон изопропилын спиртээр норгосон алчуураар арчиж халдваргүйжүүлэн ариутгана. Хүчтэй химийн уусмал, саван буюу угаагч нунтагтай усаар булхуулж угаахгүй.

4.15. Чулуу авагчийн бариулыг халдваргүйжүүлж, ариутгана.

4.8. Өндөр даралттай уур, хуурай халуун болон хийн аргаар ариутгаж болохгүй шүдний тусламж үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа зарим багаж хэрэгслийг химийн (хүйтэн) аргаар ариутгана. Үүнд:

- Үзлэгийн толь
- Хуванцар матриц
- Ам тэлэгч
- Мэс заслын хайч
- Электрокогуляцын хошуу
- Фрейз, чулуу
- Резин суулгагч
- Брекет баригч
- Банд авагч бахь
- Банд суулгагч бахь
- Брекет авагч бахь
- Таслагч бахь
- Омега бахь
- Твийд бахь
- Хавчуур
- Янгс бахь
- Нум хэлбэржүүлэгч бахь
- Гажиг заслын бахь /нумны, шувуун хошуут/
- Зуурмагийн шил
- Хүчил бондны сав

- Эмийн хундага
- Шпатель
- Их багтаамжтай шүлс сорогчийн хошуу
- Рабар дамын хүрээ, баригч
- Рентгены хальс баригч
- 1удаагаар савлагдсан ломбоны материал шахагч буу
- Хэвний материал шахагч буу
- Шүдний өнгө тохируулагч
- Резин өнгөлөгч
- Өнгөлгөөний чулуу
- Шёткан диск зэрэг хамаарагдана.

4.8. Химийн ариутгалд хэрэглэх бодис нь өндөр түвшний халдваргүйжүүлэх үйлдэлтэй, зориулалтын бодис байна. Химийн ариутгал хийсний дараа ариун усаар зайлж, хатаах шүүгээ эсвэл ариутгасан даавуугаар арчиж хатаагаад, зориулалтын цаасанд боож нян устгах гэрэл бүхий шүүгээнд хадгална.

## Тав. Чанарын хяналт, үнэлгээ

5.1. Төвлөрсөн ариутгалын чанарын хяналт, үнэлгээ нь уг тушаалын 2 дугаар хавсралтын дагуу зохицуулагдана.

5.2. Шүдний өрмийн төхөөрөмжинд холбогдсон усны шугамын цэвэршүүлэгчээр гарсан усны чанарыг тархвар судлагч эмч, халдвар хяналтын ажилтан хянана.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02-өдрийн 187 дугаар тушаалын
9 дүгээр хавсралт

# ЭМНЭЛГИЙН ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ЦАГААН ХЭРЭГЛЭЛ УГААХ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага нь орны тоо, хүчин чадалдаа тохирсон зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл, ЭМА-ны ажлын хувцас угаах угаалгын газартай байна.

1.2. Угаалгын газар бохир хэрэглэлийг ангилан ялгах, халдваргүйжүүлэх, угаах, индүүдэх, цэвэр хэрэглэлийг хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

1.3. Халдваргүйжүүлэлт, угаалга нь бичил биетний тоог бууруулдаг, халуун индүүгээр индүүдэх нь бичил биетнүүдийг устгадаг тул индүүдэх үйлчилгээг тасаг, нэгжид хийхгүй угаалгын газарт хийнэ.

1.4. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангах цэвэрхэн, өнгө үзэмжтэй цагаан хэрэглэлээр хангагдсан байна.

1.5. Үйлчлүүлэгч өөрөө хүсвэл мэс засал, төрөх, сэхээн амьдруулах, тусгаарлах, халдварт, сүрьеэгийн тасгаас бусад тасгуудад цагаан хэрэглэлээ авчирч хэрэглэж болох ба эмнэлгээс гарахад нь угааж, халдваргүйжүүлэх зааврыг өгнө.

1.6. Үйлчлүүлэгчийн цагаан хэрэглэлийг бохирдсон тохиолдол бүрт солино.

## Хоёр. Угаалгын газарт тавигдах шаардлага

2.1. Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр хэсэгтэй байна. Бохир хэсэгт бохир хэрэглэлийг ангилан ялгах, угааж халдваргүйжүүлэх, цэвэр хэсэгт индүүдэх, хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Угаалгын газрын өрөө тасалгаа нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр, бохир усны шугамд холбогдсон, зөөврийн усан хангамжтай үед угаалгын үйлчилгээнд хүрэлцэхүйц хэмжээний ус нөөцлөх савтай, ус зөөвөрлөх, халаах хэрэгслээр хангагдсан байна.

2.3. Угаалгын газрын өрөөний шал нь резинэн хулдаас, ус зайлуулах хоолойтой, хана нь шаазан хавтан, таазыг эмульсдсэн байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

2.4. Угаалгын газаргүй эрүүл мэндийн байгууллагууд нь нярайн даавуу болон мэс ажилбар, төрөлтөд хэрэглэх даавуун хэрэглэлээс бусад зөөлөн эдлэл, цагаан

хэрэглэл, ажлын хувцсыг халдваргүйжүүлэх, угаах, индүүдэх үйл ажиллагааг зохих зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

2.5. ЭМА-ны ажлын хувцас, нярай, мэс засал, төрөхийн цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг тус, тусад нь, бусад тасгийн цагаан хэрэгслийг халдварын эрсдэл өндөртэй (халдварт, сүрьеэгийн тасаг, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийн, цус, шээс, гэх мэт биологийн шингэнээр бохирлогдсон), халдварын эрсдэл багатай гэж ангилж угаах тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

## Гурав. Ангилан ялгах, халдваргүйжүүлэх

3.1. Ор хөнжлийн даавуу, дэрний уут, гудас, матрасны гаднах уутыг үйлчлүүлэгч эмнэлгээс гарах болон бохирдсон тохиолдол бүрт цэвэр хэрэгслээр солиж бохир хэрэгслийг угаалгад өгнө.

3.2. Үйлчлүүлэгчийн орноос бохир цагаан хэрэглэлийг авахдаа орчинд бохирдлыг тараахаас сэргийлж хуйлах, эвхэх байдлаар авна. Бохир цагаан хэрэглэлтэй харьцаж байгаа ажилтан бээлий өмссөн байна.

3.3. Гудас, матрас нь эмнэлгийн зориулалттай гаднах өнгө нь ус нэвтэрдэггүй бол тасагт нь халдваргүйжүүлж, угааж болно.

3.4. Хөнжил, бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг угаалгын газарт өгч халдваргүйжүүлж, угаалгана.

3.5. Хөвөнтэй, угаахад тохиромжгүй материалаар хийгдсэн хөнжил, гудас, матрас, дэрийг биологийн шингэнээр бохирлогдоогүй бол дезкамер болон озоноор халдваргүйжүүлэлт хийнэ.

3.6. Тасаг, нэгж бүр бохир хэрэгслийг зөөвөрлөх ус нэвтэрдэггүй зориулалтын уут, тэргэнцэртэй байна. Даавуун уут хэрэглэж байгаа тохиолдолд уут нь бариултай байх ба зөөвөрлөх ажилтан бээлий өмсөнө.

3.7. Бохир хэрэгслийг уутанд дүүргэж хийхгүй ¾ хүртэл хэмжээгээр хийнэ. Бохир хэрэгслийг зөөвөрлөж байгаа уут нь цэвэр хэрэгслийн уутнаас өнгөөр ялгасан байна. Уутыг угааж, халдваргүйжүүлж, индүүднэ.

3.8. Бохир хэрэгслийг тасаг, нэгжээр нь бүртгэн хүлээн авч бохирдолтын байдлаар нь халдвартай үйлчлүүлэгчийн, биологийн шингэнээр бохирлогдсон, хир ихтэй гэх мэтээр ангилан угаалгад шилжүүлнэ.

3.9. Бохир хэрэгсэлтэй ажиллаж байгаа ажилтан халдвараас сэргийлэх сургалтад хамрагдсан байх ба цоордоггүй, усанд тэсвэртэй бээлий, халад, хулдаасан хормогчоор хангагдсан, хэрэглэж хэвшсэн байна.

## Дөрөв. Угаах, хадгалах

4.1. Угаалганд эмнэлгийн зориулалттай халдваргүйжүүлэх үйлчилгээтэй угаалгын бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэнэ.

4.2. Халдваргүйжүүлэх үйлчилгээгүй ахуйн зориулалтын угаалгын бодис хэрэглэж байгаа үед бохир хэрэгслийг эхэлж халдваргүйжүүлсний дараа угаана. Халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, хэрэглэнэ.

4.3. Хагас автомат угаалгын машин болон гараар угааж байгаа тохиолдолд мушгиж, сэгсэрсний дараа цэвэр усаар угаалгын бодисын үлдэгдлийг арилгал угаана.

4.4. Угаах хэрэгслийн халдварын эрсдлээс шалтгаалан эрсдэл багатайгээс эхэлж угаана. Угаалга хооронд машин, савны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг хийж дараагийн хэрэгслийг угаана.

4.5. Угаалгаас гарсан хэрэгслийг халуун агаараар хатаах төхөөрөмжийг ашиглан хатаахаас гадна нарны гэрэлд хатааж болно.

4.6. Цэвэр хэрэгслийг шалнаас дээш 10-15 см өргөгдсөн, хангалттай хэмжээний тавиур бүхий шүүгээнд хадгална.

4.8. Цагаан хэрэгслийг зориулалтын уутанд багцалж савлана. Цэвэр хэрэгслийг тасаг нэгж рүү зөөвөрлөх уут тусдаа байна.

## Тав. Угаалгын газрын үйл ажиллагааг үнэлэх шалгуур

5.1. Үнэлгээг тийм онооны нийлбэр дүнг, үнэлгээ хийгдсэн асуумжийн авбал зохих оноонд харьцуулж хувиар гаргана.

| д/д | Үнэлгээний асуумж | Хариулт | Оноо |
|---|---|---|---|
| 1 | Угаалгын тасаг, нэгжийн урсгал зөв, эрүүл ахуйн шаардлагын дагуу зохион байгуулагдсан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 2 | Угаалгын тасаг нь цэвэр, бохир хэсгээр тусгаарлагдсан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 3 | Угаалгын тасаг халуун, хүйтэн усаар хангагдсан | Төвлөрсөн усан хангамжид холбогдсон халуун, хүйтэн устай | 2 |
| | | Зөөврийн усан хангамжтай боловч ус халаах, нөөцлөх, бохир ус зайлуулах боломж бүрдүүлсэн | 1 |
| | | Зөвхөн хүйтэн устай | 0 |
| 4 | Цагаан хэрэглэл зөөвөрлөх тэргэнцэртэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 5 | Угаах төхөөрөмжөөр хангагдсан | Төрөлжүүлж угаах угаалгын машин хангалттай | 2 |
| | | Угаалгын машин хүрэлцээгүйгээс нэг угаалгын машин ашиглаж ээлжилж | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| | | угаадаг | |
| | | Гараар угаадаг | 0 |
| 6 | Хатаах тоног, төхөөрөмжөөр хангагдсан | Хатаах машинтай | 2 |
| | | Зориулалтын хатаах тавиуртай | 1 |
| | | Хатаах хэрэгсэлгүйгээс сэгсрээд шууд индүүддэг эсвэл зориулалтын бус хатаагчтай | 0 |
| 7 | Индүүдэх тоног төхөөрөмжөөр хангагдсан | Зориулалтын бул индүүтэй | 2 |
| | | Ахуйн зориулалтын индүүтэй | 1 |
| | | Индүүддэггүй | 0 |
| 8 | Эмнэлгийн зориулалтын халдваргүйжүүлэх үйлчилгээтэй угаалгын бодис хэрэглэдэг | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 9 | Угаалгын газрын ажилтан нь халдвараас сэргийлэх талаар сургалтад хамрагддаг | Жилд 1-ээс доошгүй удаа сургалтад хамруулдаг | 2 |
| | | Хийдэггүй | 0 |
| 10 | Ажилчидыг ус нэвтэрдэггүй хамгаалах, хувцас хэрэгслээр бүрэн хангасан | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 11 | Өртөлтийг бүртгэдэг, өртөлтөөс сэргийлэх иж бүрдэлтэй | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 12 | Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 13 | Цэвэр хэрэгслийг багцалж савладаг | Тийм | 2 |
| | | Үгүй | 0 |
| 14 | Хадгалах шүүгээ нь тавиур хүрэлцээтэй, битүү | Хүрэлцээтэй, битүү | 2 |
| | | Хүрэлцээтэй боловч задгай | 1 |
| | | Хүрэлцээгүй | 0 |
| 15 | Бохир, цэвэр хэрэгслийг зөөвөрлөх уут тасаг бүрт тусдаа хангалттай хэмжээгээр байдаг | Эмнэлгийн хэмжээнд бүх тасгуудад хангалттай | 2 |
| | | Зарим тасгуудад хангалтгүй | 1 |
| | | Хангалтгүй | 0 |
| | **Нийлбэр оноо** | | **30** |

5.2. Тухайн байгууллагын нийлбэр оноо 0-10 байвал хангалтгүй, 11-20 бол дундаж, 21-30 байвал хангалттай сайн түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

140

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06 сарын 02-ны өдрийн 187 дугаар тушаалын 10 дугаар хавсралт

# ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ДУРАН, ТҮҮНИЙ ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙГ УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ, АРИУТГАХ ЗААВАР

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврыг оношилгоо, эмчилгээнд хэрэглэгддэг дурангийн багаж, тэдгээрийн дагалдах хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагаанд мөрдөх бөгөөд дуран тус бүрийн үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмжийг харгалзан угааж, халдваргүйжүүлж, ариутгана.

1.2. Дурангийн халдваргүйжүүлэлт, ариутгалд дуранг гэмтээхгүйгээр тохирсон бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэх бөгөөд энэ нь олон улсын худалдаанд зөвшөөрөгдсөн, хоол ба эмийн аюулгүй хэрэглээний стандартаар баталгаажсан байна.

1.3. Дурангийн халдваргүйжүүлэлт, ариутгал хийх өрөө нь агааржуулалтын төхөөрөмжтэй байна

1.4. Цэвэрлэгээнд хэрэглэгдэж байгаа сойз, алчуур зэргийг нэг удаагаар хэрэглэнэ.

1.5. Амьд сорьцын шинжилгээний (биопси) хавчуур, тарианы зүү болон улаан хоолойн хураагуур судсыг боох, цөс, нойр булчирхайг сэтгүүрдэх шинжилгээ, салстын доогуур хуулж авах зэрэг ажилбарын үед багажийг нэг удаагаар хэрэглэх бөгөөд дахин ариутгаж хэрэглэхгүй.

1.6. Дуран түүний дагалдах хэрэгсэлтэй ажиллахдаа үйлдвэрлэгчээс гаргасан хэрэглэх арга, аюулгүй ажиллагааг баримтлах бөгөөд үйлдвэрээс тогтоосон техникийн ажлын хугацаанд ханган нийлүүлэгч байгууллага болон инженер техникийн алба үнэлгээг хийж, гэмтэл гарсан тохиолдолд хэрэглээнээс хасах буюу засварлана.

## Хоёр. Цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах

2.1. Дуран түүний дагалдах хэрэгслийг угааж, халдваргүйжүүлэх, ариутгах, хадгалахдаа дараах зааврыг баримтлана.

| | |
|---|---|
| Анхны цэвэрлэгээ, угаалга, халдваргүйжүүлэлт | Дуранг үйлчлүүлэгчээс сугалж авсаны дараа гэрэл үүсгэгч болон процессороос салгалгүйгээр шууд гадна талыг нойтон алчууraар удирдлагын хэсгээс төгсгөл хэсэг рүү шувтарч арчин дуранд наалдсан салст цусыг арилгана.<br><br>Агаар, усны сувгийг 200 мл халдваргүйжүүлэгч+цэвэрлэгч |

| | | |
|---|---|---|
| | | (детергент) уусмалаар соруулж угаана.<br><br>Сувгийн тохируулагчтай (адаптор) тохиолдолд тохируулагчийг таглана. Тохируулагчгүй тохиолдолд агаар, усны товчийг зөөлөн болон хүчтэй дарж үлээлгэнэ.<br><br>Дуранг гэрэл үүсгүүр болон процессороос салгана.<br><br>Уснаас хамгаалах тагийг углана.<br><br>Зориулалтын тэргэнцэрээр төвлөрсөн ариутгалын тасаг, хэсэгт зөөвөрлөнө. |
| Шалгах | | Угаахын өмнө зориулалтын даралт хэмжигчээр шалгах ба хэмжигч байхгүй үед урсгал усны тосгуурт дуранг далд ортол ус хийж хийн бөмбөлөг тасралтгүй гарч байгаа эсэхийг шалгана. |
| Дурангийн гадна угаалга | | Шүүлтүүрээр шүүгдсэн бүлээн урсгал усаар зориулалтын зөөлөвчин ханатай тосгуурт халдваргүйжүүлэгч+цэвэрлэгч (детергент) уусмал хэрэглэж дурангийн цорго, суваг, холбоос болон бүх салах хэсгүүдийг хамруулан зөөлөн хөөсрүүлэгч материал, алчуураар дурангийн гадна талыг хөөсрүүлэн угаана. |
| Дурангийн жижиг хэсгийн угаалга | | Жижиг, зөөлөн сойзоор дурангийн бүх салдаг хэсгүүд, биопсийн оролт, ус, агаар дамжуулах, соруулах сувгийн товч, ажлын сувгийн таг зэргийг халдваргүйжүүлэгч+цэвэрлэгч (детергент) уусмалаар олон дахин сойздож угаана. |
| Соруулах болон ажлын сувгийг сойздож угаах | | Халдваргүйжүүлэгч+цэвэрлэгч (детергент) уусмалаар зориулалтын сойз ашиглан дотор сувгийг угаана. |
| Зайлах | | Халдваргүйжүүлэлт хийсний дараа дурангийн гадна болон дотор талыг цэвэр усаар сайтар зайлж хатаана. |
| Ариутгал | Химийн /хүйтэн/ аргаар ариутгах | Дурангийн ариутгалд глютаральдегид, ортофталальдегид агуулсан бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.<br><br>Зориулалтын танканд ариутгалын бодисыг хийж дуранг бүрэн далд орохоор дүрж үйлдвэрлэгчээс гаргасан хугацааг баримтлан ариутгана. Ариутгах уусмалд хийх дуран, дагалдах хэрэгсэл нь цэвэр, хуурай байна.<br><br>*Зайлах*<br><br>Ариутгалын уусмалаас дуранг авч ариун нэрмэл усаар ариутгалын бодисын үлдэгдлийг арилтал зайлна. Сувгыг соруулах соруурт залгаж 200мл-с ихгүй ариун нэрмэл усаар зайлна. |

| | | |
|---|---|---|
| | | *Хатаах*<br>70%-н спиртийн 10мл уусмалыг сувгууд руу хийж хатаана. Эсвэл зориулалтын хийн буугаар үлээлгэж хатаана.<br>Жич: Сүрьеэгийн халдвартай эмчлүүлэгчид хэрэглэсэн дуранг халдваргүйжүүлэхдээ глютаральдегидын уусмалаас илүүтэйгээр ортофталальдегид хэрэглэх нь илүү үр дүнтэй. |
| | Зориулалтын автомат машинаар ариутгах | Дуран болон салдаг хэсгүүд, дагалдах хэрэгслүүдийг хамтад нь ариутгах бөгөөд аюулгүй ажиллагааны зааврыг баримтална.<br>Машинд доголдол гарсан тохиолдолд дахин ариутгалд оруулна.<br>*Хатаах*<br>70%-н спиртийн 10мл уусмалыг сувгууд руу хийж хатаана. Эсвэл зориулалтын хийн буугаар үлээлгэж хатаана. |
| **Хадгалах** | | Зориулалтын шүүгээнд босоо байдлаар унжуулж өлгөөд бүх товч, тагийг салгаж хадгална. |

2.2. Амьд сорьцын шинжилгээний (биопси) хавчуур нь давтан хэрэглэгдэх зориулалттай бол сойздон угааж, халдваргүйжүүлсний дараа хатааж автоклавт эсвэл хийн аргаар ариутгаж хэрэглэнэ.

2.3. Гогцоо, тэлэгч (клип) тавигчийг хэрэглэсний дараа гар болон үзүүр хэсгийг устөрөгчийн хэт исэл бүхий угаалгын уусмалд хийж 30 минут байлгана. Гадна, дотор хэсгийг сайн угааж усаар зайлан хатааж автоклавт эсвэл хийн аргаар ариутгана.

2.4. Хавчуур, саг (баскет) хавчуурын дотор суваг болон гадна талыг сайтар угааж халдваргүйжүүлсний дараа цэвэр усаар зайлж хатаагаад автоклавт эсвэл хийн аргаар ариутгана.

2.5. Усны шахуургын савыг өдөр бүр хэрэглэсний дараа халдваргүйтгэж, хуурайгаар хадгална.

## Гурав. Дурангийн ариутгалын чанарыг үнэлэх

Дурангийн багажны ариутгалын чанарыг тархвар судлаач эмч нян судлалын аргаар улирал тутам хянаж, бүртгэл хөтөлнө.

1. Дурангийн суваг дотор 20-30 мл ариун физиологийн уусмал хийж зайлж түүнээс арчдас авч, тэжээлт орчинд шууд тарих

2. Дурангийн гадаргуу болон орчин тойрны эд зүйлс, дуран хадгалах шүүгээ зэргээс арчдас авч тэжээлт орчинд тарьж, нян ургуулах шинжилгээг хийнэ.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02-өдрийн 187 дугаар тушаалын
11 дүгээр хавсралт

# ХАЛДВАРЫН ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ ТАСАГ, НЭГЖҮҮДИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗААВАР

## Нэг. Амаржих газар, төрөх тасгийн халдварын сэргийлэлт, хяналт

1.1. Амаржих газар, төрөх тасаг нь хүлээн авах, төрөхийн өмнөх, төрөх, төрсний дараах, нярай, дутуу нярайн тасагтай, халдварын сэжигтэй эх, нярайг тусгаарлах боломжийг бүрдүүлэн, халдвараас сэргийлэх заавар, журмуудыг чанд мөрдөн ажиллана.

1.2. Эх, нярайг тандалт хийж халдварын сэжигтэй эх, нярайг эрт илрүүлэх, яаралтай тусгаарлан халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээ авна.

1.3. Төрөх, мэс ажилбар, нярайн өрөөний тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тухайн тасагт ажиллаж буй сувилагч хариуцан хийнэ.

1.4. Биеийн шингэн, салст, шарх, шалбархайтай арьстай хүрэх, нярайг хуурайлах, живх солих, бохирдсон материалтай харьцах бүрд нэг удаагийн бээлий өмсөнө.

1.5. Төрөлт удирдахдаа ариун бээлий өмсөнө. Эхийн биеийн шингэнд хүрсэн бээлийтэй гараар нярайд хүрч болохгүй.

1.6. Төрөх үйл явц эхэлсэн халдварт өвчтэй болон сэжигтэй (биеийн халуун 37 хэмээс дээш, ураг орчмын шингэн шүүрч гараад 12 цагаас дээш болсон, үтрээний цэвэршилтийн зэрэг 3, 4, нянгийн болон вирусын гаралтай халдвартай нь шинжилгээгээр батлагдсан, хяналтын хуудасгүй, төрөх үйл ажиллагаа эмнэлгийн бус орчинд явагдсан, шинж тэмдэггүй боловч шээсэн дэх нянгийн тоо $10^5$ нянгийн ургалттай, халдварын болон халдварын бус гаралтай арьсны өвчтэй, шимэгч хорхойн тээгч, амьсгалын дээд, доод замын хурц үрэвсэлтэй, ураг эх дотроо эндсэн г.м) эхчүүдийг тусгаарлах өрөөнд төрүүлэх боломжоор хангасан байна.

1.7. Төрөлт бүрийн дараа орыг цэвэрлэж, халдваргүйжүүлнэ.

1.8. Нярайг заавар журмын дагуу дархлаажуулж, эхэд гарын эрүүл ахуй, хувийн ариун цэвэр сахих зөвлөмж өгнө.

1.9. Нярайд хэрэглэх тоног, төхөөрөмж, багаж хэрэгслийг халдваргүйжүүлэхэд хор нөлөөгүй халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэнэ. Фенол агуулсан халдваргүйжүүлэх бодис хэрэглэхгүй.

1.10. Нярайг өөр эх дамжуулан хөхүүлэхийг хориглоно.

1.11. Амаржих газар, төрөх, нярайн тасгуудыг жил бүр хэсэгчлэн буюу бүрэн хааж засвар, их цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийнэ.

1.12. Эх, нярай сахиуртай бол сахиурт халдварын сэжиг илрүүлэх үзлэг шинжилгээ хийж, хувийн ариун цэвэрт хяналт тавина. Халдварын шинж тэмдэг

илэрвэл сахиулахыг хориглоно. Сахиур нь эмнэлгийн нөхцөлд тохиромжтой, цэвэр хувцастай байна.

**Хоёр. Мэс заслын тасагт баримтлах халдварын сэргийлэлт, хяналт**

2.1. Мэс заслын тасаг нь мэс заслын нэгдсэн хэсэг (блок), сэхээн амьдруулах, сэрээх өрөөтэй байх ба хагалгааны дараах хэсэг болон боолт нь цэвэр ба идээт мэс заслын гэж тусгаарлах боломжийг бүрдүүлсэн байна.

2.2. Мэс заслын хэсгийн өрөөний шал нь резинэн хулдаас, хана нь тосон будаг эсвэл шаазан хавтан, таазыг эмульсдсэн байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй байна.

2.3. Мэс заслын дараах идээт үжилтэй, шархны халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг тасагт нь тусгаарлана.

2.4. Мэс засалд орсон үйлчлүүлэгчийн ор, дэрний цагаан хэрэглэлийг 3 хоног буюу бохирдсон тохиолдол бүрт солино.

2.5. Мэс заслын өмнөх халдварын сэргийлэлт, хяналт:

2.5.1. Үйлчлүүлэгчийг мэс заслын өмнө халдварыг илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, эмчлэх

2.5.2. Цусан дахь сахарын хэмжээг хянах, их тохиолдолд бууруулах

2.5.3. Мэс заслын өмнөх эмнэлэгт байх хугацааг аль болох багасгах

2.5.4. Арьсанд гэмтэл үүсдэг учраас зүслэгийн талбайн үсийг хусаж арилгахгүй үсийг гуужуулах, эсвэл богиносгож хайчлах

2.5.5. Арьсны халдваргүйжүүлэлт хийх

2.5.6. Мэс заслын баг нь гар угаах, халдваргүйтгэх зааврын дагуу гарын эрүүл ахуйг сахих. Гар угаахад сойз хэрэглэж болохгүй. Өглөө бүр эхний хагалгааны өмнө хумс цэвэрлэгчээр хумсны завсрыг цэвэрлэнэ.

2.5.7. Нянгийн эсрэг сэргийлэлтийг зааврын дагуу хийнэ.

2.5.8. Мэс заслын иж бүрдэл, шаардлагатай хэрэгслийг бэлтгэсэн байна.

2.6. Мэс заслын үеийн халдварын сэргийлэлт, хяналт:

2.6.1. Мэс заслын шалгах хуудсыг хөтөлнө. Шаардлагагүй ажилбарыг аль болох хязгаарлана.

2.6.2. Мэс заслын баг нь ариун бээлий, халад, ус нэвтэрдэггүй хормогч, мэс заслын амны хаалт, үс бүрэн халхалсан малгай өмсөнө.

2.6.3. Мэс засалд хэрэглэгдэх багаж хэрэгсэл нь ариун байна. Ариун бус зааврын дагуу ариутгагдаагүй багаж хэрэгслийг мэс засалд хэрэглэхийг хориглоно.

2.6.4. Мэс заслын өрөө нь шүүлтүүр бүхий механик агааржуулах системтэй, агаарын эерэг урсгалтай, цаг тутамд 20 удаа агаар сэлгэлт хийхээр тохируулсан байна. Мэс заслын өрөөний агаар, шүүлтүүр цэвэр байна.

2.6.5. Мэс заслын өрөөний хаалга хаалттай байх ба үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтаны орох хаалга тусдаа байна.

2.6.6. Мэс заслын явцад өрөөнд онцын шаардлагагүйгээр гаднаас хүн орох, сэлгүүцэх, утсаар ярих, багийн гишүүд хиймэл хумс, хумс урт ургуулахыг хориглоно.

2.6.7. Мэс заслын туршид үйлчлүүлэгчийн биеийн температур 36.5-37 хэм, цусан дахь сахарын хэмжээ <200mg/dL байвал зохино.

2.6.8. Урсгуур хэрэглэж байгаа бол хаалттай урсгуур тавина.

2.6.9. Мэс засал дууссаны дараа орчны эд зүйл, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг хийж дараагийн ажилбарыг эхэлнэ.

2.7. Мэс ажилбарын дараах халдварын сэргийлэлт, хяналт

2.7.1. Шаардлагагүй бол шарханд аль болох хүрэхгүй байх

2.7.2. Урсгууртай бол өдөр бүр хянах ба урсгуур шаардлагагүй бол авах

2.7.3. Мэс заслын дараа хавсарсан болон дагалдах өвчин эмгэггүй бол шархны халдвараас сэргийлэх зорилгоор нянгийн эсрэг эмчилгээ хийхийг хориглоно.

2.7.4. Мэс заслын шархны халдварыг илрүүлэх тандалтыг тухайн эмнэлэгт хийх ба эмнэлгээс гарснаас хойш харъяалах эрүүл мэндийн байгууллага нь хийнэ.

## Гурав. ЭТҮХХ амьсгалын замын халдварын сэргийлэлт, хяналт

3.1. Эрчимт эмчилгээний тасагт үйлчлүүлэгчдийг уушгины хатгалгаа, амьсгалын доод замын халдвараас сэргийлнэ.

3.2. Уушгины хатгалгаа нь амьсгалын замын нарийн хэсэгт бөглөрөл үүсэх, ам, залгиур, ходоодны шүүрэл амьсгалын замд сорогдох, зохиомол амьсгалд халдварлагдаж бохирлогдсон төхөөрөмж хэрэглэх, асаргаа, сувилгаа, эмчилгээний явцад халдвараас сэргийлэх дэглэм мөрдөхгүй байснаас үүдэлтэй байдаг.

3.3. Хэвтрийн хүнд өвчтэй, цээж, хэвлийн хөндийн хагалгаанд орсон, амьсгалын аппараттай үйлчлүүлэгчдийн цээжний хэржигнүүр, халуурал, цэрний байдал, ханиалга, амьсгалын тоо, цээжний зураг, нян судлалын шинжилгээний үзүүлэлтээр тандана.

3.4. Мэс заслын дараа уушгины хатгалгаанаас сэргийлэх

3.4.1. Мэс заслын өмнө уушгины эмгэгийг эмчлэх

3.4.2. Эсрэг заалтгүй бол орны толгой хэсгийг өндөр байлгах, хөдөлгөөнтэй байлгах, байрлалыг сольж байх

3.4.3. Үжлийн эсрэг (антисептик) уусмалаар амны хөндийг өдөрт 2-3 удаа цэвэрлэх

3.4.4. Онцын шаардлагагүй бол амьсгалын замыг соруулахаас зайлсхийх

3.4.5. Мэс заслын дараа ханиах, амьсгалуулах дасгал, ханиалга өдөөх доргилттой массаж хийх, аль болох гүнзгий амьсгалуулах

3.4.6. Өвдөлтийг намдаах, тайвшруулах эмийг зохистой хэрэглэх

3.5. Амьсгалын аппараттай холбоотой хатгалгаанаас сэргийлэх

3.5.1 Асаргаа, сувилгаа, эмчилгээний явцад гарын эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийг сахих

3.5.2 Цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих, соруулахад гуурс болон бусад хэрэгсэл нь ариун байх, бохирдуулахаас сэргийлэх, бээлийг давтан хэрэглэхгүй

3.5.3 Эсрэг заалтгүй бол орны толгой хэсгийг өндөр байлгах, хөдөлгөөнтэй байлгах, байрлалыг сольж байх

3.5.4 Ам, залгиур, ходоодны шүүрэл амьсгалын замд сорогдож халдвар үүсгэхээс сэргийлэх, амны хөндийг үжлийн эсрэг уусмалаар цэвэрлэх, ходоод хэт дүүргэхээс сэргийлж хоолыг бага багаар өгөх

3.5.5 Төлөвлөгдөөгүй ажилбар хийхгүй байх: Тухайлбал гуурсыг авах, дахин суулгах зэргээс зайлсхийх

3.5.6 Цагаан мөгөөрсөн хоолойд амьсгалын гуурс тавихдаа аль болох амаар өгөх, энэ нь хамраар дамжуулж хийхээс халдварын эрсдэл багатай

3.5.7 Стрессийн гаралтай ходоодны шарх, ходоодны үрэвсэл үүсэх эрсдэлтэй үйлчлүүлэгчдээс бусад тохиолдолд ходоодны шүүрэл дарах $H_2$-рецепторыг саатуулагч, протоны шахуурга хориглогч эмийг хэрэглэхээс зайлсхийх

3.5.8 Агаар чийгшүүлэгч, хүчилтөрөгч өтгөрүүлэгчид ариун усыг хэрэглэх

3.5.9 Амьсгалын аппаратны гуурсанд цугларсан конденсацийг тодорхой хугацаанд гаргах ба энэ үед гуурсыг хаалттай байлгах, конденсаци үйлчлүүлэгчийн амьсгалын зам руу буцаж урсахаас хамгаалагдсан байх

3.5.10 Зохиомол амьсгалын давтан хэрэглэдэг төхөөрөмж, хэрэгслийг ариутгаж, зөв хадгалж хэрэглэнэ. Дахин хэрэглэдэг эд, ангиудыг хүйтэн эсвэл уурын аргаар ариутгана. Халуун болон чийгт мэдрэг багаж хэрэгслийг бага температурт ариутгаж хэрэглэнэ. Химийн ариутгал хийсэн бол ариун усаар зайлна. Ариун ус байхгүй бол усыг 0,2 микроны шүүлтүүрээр шүүсэн ус хэрэглэнэ. Хатаах шүүгээ эсвэл изопропилын спирт болон агаараар хатаана. Савлаж бохирдлоос сэргийлж хадгална.

3.5.11 Амьсгалын аппаратыг задалж дотор талыг нь халдваргүйтгэж, ариутгах шаардлагагүй

3.5.12 Амьсгалын хүрээний эд ангиудыг нэг л үйлчлүүлэгчид хэрэглэх ба ба амьсгалын аппаратны гуурс, амьсгал гаргах хавхлага, агаар чийгшүүлэх хэрэгсэл нь гэмтсэн, илэрхий бохирдсон үед солино. Илэрхий бохирдоогүй, механик гэмтэл үүсээгүй үед солих шаардлагагүй. Дараагийн үйлчлүүлэгчид хэрэглэхийн өмнө давтан хэрэглэх эд, ангийг цэвэрлэж халдваргүйтгэнэ, нэг удаагаар хэрэглэх хэсгийг шинээр солино.

3.5.13 Нянгийн эсрэг бэлдмэлийн хэрэглээнд эм зүйч, тархвар судлагч эмч хяналт тавих

3.5.14 Амьсгалын аппараттай үйлчлүүлэгчдийн дунд уушгины хатгалгааг илрүүлэх тандалтыг эмчлэгч эмч, тархвар судлаач эмчтэй хамтран хийнэ.

## Дөрөв. Сүрьеэгийн эмнэлэг, тасагт баримтлах халдварын сэргийлэлт, хяналт

4.1. Сүрьеэгийн эмнэлгийн бүх тасаг, эмчилгээний цэг нь шүүлтүүр бүхий механик агааржуулалтын системтэй, байгалийн агааржуулалт хийх салхивчтай, агаарын сөрөг даралт үүсгэн агаарыг гадагшлуулах боломжтой байна.

4.2. Сүрьеэгийн эмнэлэг, тасгийн хүлээн авах тусдаа байна. Хүлээн авах нь эмэнд дасалтай сүрьеэ, түрхэц эерэг уушгины сүрьеэ, уушгины бусад эрхтний болон түрхэц сөрөг гэсэн 3 өрөөтэй байна.

4.3. Сүрьеэгийн эмнэлэг, тасгийн ажилтан болон үйлчлүүлэгчийн орох хаалга тусдаа байна.

4.4. Сүрьеэгийн эмнэлэг, тасаг нь хэвтэн эмчлүүлэгчээс эмнэлгийн ажилтаныг тусгаарласан хаалттай байна. Эмнэлгийн ажилтан хэвтэн эмчлүүлэх хэсэгт орохдоо хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, шүүлтүүртэй амны хаалтыг зүүнэ.

4.5. Сүрьеэгийн эмнэлэг, тасагт үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэхдээ:

- Эмэнд тэсвэртэй сүрьеэ,
- Түрхэц эерэг уушгины сүрьеэ,
- Уушгины бусад эрхтний болон түрхэц сөрөг сүрьеэг гэж тусгаарлан эмчилнэ.

4.6. Сүрьеэтэй эмчлүүлэгчийн өрөө болон заал, хүлээлгийн хэсэг бүрт нян устгах үйлчилгээтэй хэт ягаан туяаны гэрэл, дезар, агаар цэвэршүүлэгч байна.

4.7. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй эмчлүүлэгчийг эмчлэх, сувилах үед баримтлах дэглэм

4.7.1. Цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг байгаа эмэнд тэсвэртэй сүрьеэтэй эмчлүүлэгчийг эмчийн хяналтанд тусгаарлан эмчилнэ.

4.7.2. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй эмчлүүлэгчийг эмчлэх тасагт эмэнд тэсвэржилтийн хэлбэрээр ангилан хэвтүүлнэ.

4.7.3. Цэрний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээ эерэг эмэнд тэсвэртэй сүрьеэтэй эмчлүүлэгчид эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхдээ шүүлтүүртэй амны хаалт (N95, N100, 3M ) хэрэглэнэ.

4.7.4. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй байж болзошгүй эмчлүүлэгчийн сорьцонд шинжилгээ хийх эмч, лаборант нар шүүлтүүртэй амны хаалт (N95, N100, 3M) хэрэглэнэ.

4.7.5. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй эмчлүүлэгчид цэрний өсгөвөрлөх шинжилгээний хариу 2 сар дараалан сөрөг болтол амны хаалт хэрэглүүлж, цэрийг зориулалтын саванд цуглуулж, өдөр бүр халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйтгэнэ.

4.8. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэгээр эмчлүүлж байгаа эмчлүүлэгчийн эмчилгээг халдвартай, халдваргүйгээр нь тус тусдаа өрөөнд хийх, нэг өрөөтэй бол цагийн хуваарь гарган халдваргүй үйлчлүүлэгчийн эмчилгээг эхэлж хийхээр зохицуулна.

4.9. Сүрьеэгийн эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх сургалтанд хамруулсан байна.

## Тав. Шээлгүүртэй холбоотой бөөр шээсний замын халдварын сэргийлэлт, хяналт

5.1. Шээлгүүр тавих эмнэлгийн мэргэжилтэн нь сургагдсан байна. Шээлгүүр тавих хэрэгслийг урьдчилан багцалж бэлтгэнэ.

5.2. Шээлгүүрийг ариун багаж, хэрэгслээр үжилгүйжүүлэх техникийг баримтлан тавина. Үүнд:

5.2.1 Шээлгүүр тавихын өмнө шээсний сүвийг повидион иод, 0,2%-н хлоргексидины уусмалаар халдваргүйжүүлнэ

5.2.2 Шээсний сүв, сувагт гэмтэл үүсгэхгүй байх үүднээс нэг удаагийн ариун тос хэрэглэнэ. Эсвэл өвдөлт намдаах гель хэрэглэж байгаа бол шээлгүүр оруулахаас 3 минутын өмнө гелийг хийнэ.

5.2.3 Ариун шээлгүүрийг үйлчлүүлэгчийн орчны эд зүйл, биеийн бусад хэсэгт хүргэхгүй, шээлгүүрийн орох хэсэгт гар хүрэхгүйгээр тавина.

5.2.4 Шээлгүүр тавьсан ажилбарын тэмдэглэл хөтлөнө.

5.3 Шээлгүүрийн гуурсыг үйлчлүүлэгчийн гуянд хөдөлгөөнгүйгээр бэхэлж тогтооно, шээс цуглуулах уутыг давсагнаас доор түвшинд байрлуулна. Гуурс, шээс цуглуулах уут шаланд хүрэхээргүй байна.

5.4 Үйлчлүүлэгч хөдлөхөд шээлгүүр дахь шээс давсаг руу буцаж урсахаас сэргийлж гуурсыг хаах, хаалттай шээлгүүрийг хэрэглэнэ.

5.5 Шээс цуглуулах уутны ¼ хэсэг шээсээр дүүрэхэд суллана. Уут шээсээр хэт дүүрэх нь уутанд хүрэлцэх үед буцаж урсаж шээсний замын халдвар үүсгэх эрсдэлтэй. Шээсийг суллахдаа үжилгүй техникийг (Уутны хаалтыг нээхийн өмнө ба дараа гар угаах эсвэл халдваргүйжүүлэх, нэг удаагийн бээлий өмсөх, уутны хаалтыг спирттэй хөвөнгөөр арчиж халдваргүйжүүлэх) баримтлан суллана. Уутны доод талаас дээш харуулж барьж хэрхэвч болохгүй

5.6 Шээс цуглуулах уутанд шээс дүүрээгүй бол 8 цаг тутамд суллана.

5.7 Том диаметртэй шээлгүүр нь шээсний сүвний салстад даралт үүсгэж гэмтээдэг, цус зогсонгишлоос хэсэг газар үхждэг тул аль болох жижиг диаметртэй шээлгүүрийг сонгож хэрэглэнэ. Мөн нянгийн эсрэг үйлчилгээтэй шээлгүүрийг (мөнгөний хольцтой, бактерийн эсрэг үйлчилгээтэй материалаар хийгдсэн г.м) хэрэглэж болно.

5.8 Заалтгүй бол давсаг угаахгүй, үжлийн эсрэг (антисептик) уусмалаар давсаг угаах, нянгийн эсрэг бэлдмэл хэрэглэх нь салст бүрхэвчийг гэмтээх аюултай бөгөөд шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвараас сэргийлэхгүй эмэнд тэсвэртэй нянг бий болгодог.

5.9 Шээсний шээлгүүртэй үйлчлүүлэгчийн шээсэнд нян судлалын шинжилгээ хийж хяналт тавих шаардлагатай ба шээснээс шинжилгээнд дээж авахдаа үжилгүй техникийг баримтлан дээж авах хэсгээс ариун нэг удаагийн зүү тариураар соруулж авна.

5.10 Шээсний шээлгүүртэй хүн бүрт нянгийн эсрэг эмчилгээг зөвлөхгүй, шээсний замын халдварын эрсдэл өндөртэй, халдварын эмнэлзүйн шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийн шээлгүүрийг солих үед урьдчилан сэргийлэх тунгаар нэг удаа нянгийн эсрэг сэргийлэлт хийнэ.

5.11 Давсаг дүүрэн шээстэй үед шээлгүүр тавихгүй

5.12 Шээсний шээлгүүртэй үйлчлүүлэгчдэд тандалт хийж шээсний шинжилгээнд нянгийн тоо $10^5$ ихэсэх, олон төрлийн нян ургах, цагаан эсийн тоо олшрох болон халуурах, умдаг дээр өвдөх, дизури, идээтэй шээх зэрэг эмнэл зүйн шинж тэмдгийг илрүүлж сэжигтэй тохиолдлыг мэдээлэн, хариу арга хэмжээ авч ажиллана.

## Зургаа. Судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэх

6.1. Венийн судсанд гуурс тавьж эмчилгээг хийх нь хатгалтын тоог цөөрүүлэх ч гадны биет оруулж байгаа учраас хүний бие хариу урвал үзүүлдэг. Үүний үр дүнд уян зүүний дотор болон гадна гадаргууд биофилм, фибрин үүсдэг. Энэ нь өөхөн эдийн үрэвсэл, буглаа, тромбофлейбит, бактереми, үжил халдвараар хүндрэх эрсдэлтэй.

6.2. Судасны гуурстай холбоотой халдвараас сэргийлэхэд зөв техник, ариун багаж, хэрэгсэл, талбайн халдваргүйтгэл, эмийн бодис бохирдолгүй байх нь чухал ач холбогдолтой.

6.3. Төвийн болон захын венийн гуурстай холбоотой халдвар үүсгэх эрсдэл нь тавьсан хугацаатай нягт холбоотой байдаг.

- Захын венийн гуурс нь өдөр тутмын арчилгаа шаардахгүй бөгөөд халдвар үүсэх эрсдэл болон өвдөлт багатай. Захын венийн гуурсыг 24 цаг тутамд шалгах ба 72 цаг болоод солино. Гуурсыг байнга солих нь венийн судсыг үрэвсүүлэх эрсдэлтэй.

- Төвийн венийн гуурс нь халдвар болон механик гэмтэл үүсэх эрсдэл өндөр байдаг. Зайлшгүй шаардлагатай биш бол төвийн венийн гуурснаас татгалзах.

6.4. Захын судсанд гуурс тавихад анхаарах зүйл:

6.4.1 Хатгалт хийх гарыг цэвэр алчуур эсвэл даавуун дээр байрлуулна.

6.4.2 Хатгалт хийх гэж байгаа эмнэлгийн мэргэжилтэн гараа угааж, халдваргүйжүүлнэ (Хатгалт хийх хэсгийг тэмтрэх, гуурс тавих, солих, гуурсны байрлал шалгах, боолт хийх ажилбар бүрийн өмнө болон дараа гараа угааж, халдваргүйжүүлнэ).

6.4.3 Ариун бээлий, катетри тавих иж бүрдлийг урьдчилан бэлтгэсэн байна.

6.4.4 Талбайг халдваргүйжүүлнэ. Үүнд: 0,5%-ийн хоргексидин, 2%-ийн иодийн уусмал, 10%-ийн спиртэнд суурьтай повидион иодын уусмал эсвэл 70%-ийн изопропилийн спиртийн аль нэгийг хэрэглэнэ. Халдваргүйжүүлэлт хийснээс хойш 30 секунд орчим, халдваргүйжүүлэх уусмалыг хатаасны дараа хатгалт хийнэ. Хатгалт хийх талбайг халдваргүйжүүлсний дараа тэмтрэлт хийж болохгүй.

6.4.5 2 сараас доош настай хүүхдэд хлоргексидины уусмал хэрэглэхгүй

6.4.6 Гуурс тавихдаа зүүнд хүрэхгүй, зүүг бохирдуулахгүй зөв техникээр тавина

6.4.7 Ариун боолт, наалт хэрэглэнэ.

6.4.8 Гуурс тавьсан хэсэгт 24 цаг тутамд үнэлж халдварын шинж тэмдэг илэрвэл авна.

6.4.9 Гуурсыг доор тавихаас зайлсхийх ялангуяа гуя, хөлөнд

6.4.10 Гуурс тавих үед халдвараас сэргийлэх дэглэм баримтлаагүй, зөрчигдсөн бол (яаралтай тусламжийн үед гэх мэт) тавьсан гуурсыг 48 цагийн дотор солих.

6.5. Төвийн венийн гуурс тавихад анхаарах нэмэлт заавар:

6.5.1. Гуурсыг тавих талбайг зөв сонгох нь чухал. Эгэмний гуурснаас илүү хүзүү болон гуянд уян гуурс тавих нь халдварын эрсдэл өндөр байдаг.

6.5.2. Төвийн венийн гуурс хийх, хөтлөгч ашиглан гуурсыг солих үед ариун бээлий, халад, малгай, маск өмсөх, ажилбар хийх хэсгийг ариун бүтээлгээр тусгаарлах

6.5.3. Ажилбар хийх хэсгийн арьсыг 2%-ийн хлоргексидины уусмалаар талбайг халдваргүйжүүлээд хатсаны дараа хатгалт хийнэ.

6.5.4. Аль болох цөөн замтай төвийн венийн гуурс хэрэглэх

6.5.5. Ариун самбай эсвэл нэвт харагддаг полиуретан наалт ашиглан гуурсанд боолт хийх. Боолт нэвтэрсэн, бохирдсон, суларсан, норсон тухай бүр нь солих.

6.5.6. Нэвт харагддаг полиуретан наалтыг 7 хоногт нэгээс багагүй удаа солих, самбай боолт хэрэглэж байгаа бол 2 өдөр тутамд солино. Боолтыг солихдоо талбайг хлоргексидины уусмалаар халдваргүйжүүлнэ.

6.5.7. Боолтыг солих бүрт гуурсны орчимд халдварын шинж байгаа эсэхийг ажиглах. Гуурсны орчим хөндүүрлэх, өөр шалтгаангүй халуурах, хэсгийн болон цусаар түгсэн халдварын шинж илэрвэл боолтыг авч шалгана.

6.5.8. Төвийн венийн гуурс болон түүний орчимд ус хүргэхгүй байх

6.5.9. Гурван замтай түгжигч нь судасны гуурс, дуслын шингэн нянгаар халдварлагдах эрсдлийг нэмэгдүүлдэг тул хэрэглэхээс зайлсхийх. Хаагддаг систем хэрэглэхэд халдварын эрсдэл багатай ба дундаа цуурхайтай хавхлага нь механик хавхлагыг бодвол халдварын эрсдэл бага.

6.5.10. Гуурсанд шингэн шахаж дүүргэх нь судсаар завсарлагатай хийх эмчилгээний чухал элемент бөгөөд гуурсанд хийх шингэн нь нэг удаагийн жижиг савалгаатай (20 мл) шингэн байх ба том савалгаатай шингэнээс олон дахин соруулж хэрэглэснээс халдварын эрсдэл багатай.

6.5.11. Төвийн венийн гуурсаар тариа хийх тохиолдол бүрийн өмнө гуурс, холбогч, гуурсанд тариур холбох хэсгийг халдваргүйжүүлэх.

6.5.12. Төвийн венийн гуурстай холбоотой хэсэг газрын болон цусаар дамжих халдвараас сэргийлэх зорилгоор антибиотик эмчилгээ хийхгүй.

6.7. Судсаар тасралтгүй үргэлжилсэн эмчилгээ хийж байгаа үед дуслын системийг хэрэглэж эхэлснээс хойш 96 цаг хүртэл хугацаанд солих заалтгүй ба ариун дэглэм мөрдөж ажилласан бол 7 хоногт 1 удаа солино. Харин цус, цусан бүтээгдэхүүн, өөхний эмульс хийж байгаа бол дуслын системийг 24 цагийн дотор, пропофолын тосон уусмал хийж байгаа үед 6-12 цаг тутам буюу бодис дуусч тариур солих бүрд систем буюу шахуургын гуурсыг солино.

6.8. Тарилгын уусмалыг бохирдуулахаас сэргийлнэ. Эмийн бодисыг нэмэлтээр хийх гэж байгаа бол ариун зүү тариураар, ариун эмийн бодисыг, үжилгүй техникийг баримтална. Тариа оруулах хэсгийн портыг 70% изопропилийн спирт шингээсэн алчууураар арчиж халдваргүйжүүлнэ. Портыг бусад үед хаалттай байлгана.

6.9. Гуурс тавихад нянгийн эсрэг сэргийлэлт хийх, хатгалт хийсэн талбайд нянгийн эсрэг үйлдэлтэй тосон түрхлэг хэрэглэх, төвийн венийн гуурс тавихдаа нянгийн эсрэг бэлдмэлтэй наалт хэрэглэх нь халдвараас сэргийлэхэд үр дүнгүй.

**Долоо. Гемодиализ эмчилгээний үеийн халдварын сэргийлэлт, хяналт**

7.1. Диализ хийлгэж байгаа үйлчлүүлэгчдийн дунд цусаар дамжих болон хэсэг газрын халдвар илрүүлэх тандалтыг хийх, хэрэглэсэн диализын аппаратны дугаар, диализын аппарат холбосон болон салгасан ажилтны нэрийг үйлчлүүлэгчийн түүхэнд тэмдэглэсэн байна.

7.2. Диализын үед эрүүл мэндийн ажилтан гарын ариун цэврийг сахин, амны хаалт бээлийг өмсөх, үйлчлүүлэгчид амны хаалтыг зүүлгэнэ.

7.3. Үйлчлүүлэгчийн хатгалт хийх хэсгийг нянгийн эсрэг үйлчилгээтэй саван ашиглан угааж, 2%-ийн хлоргексидин глюконат, 70% изопропил болон этилийн спирт эсвэл 10% -ийн повидион иодоор халдваргүйжүүлнэ.

7.4. Гемодиализын аппарат, багаж хэрэгслийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж, халдваргүйжүүлнэ. Давтан хэрэглэх цус цэвэршүүлэн шүүх (dialyser) хэсгийг цэвэрлэгээ угаалга, дээд зэргийн халдваргүйжүүлэлт хийж ариун усаар зайлж хатаана. Бохирдлоос сэргийлж хадгална.

7.5. Диализын аппаратын ус хадгалах танк, усны шүүлтүүр бохирдохоос сэргийлж тогтсон хугацаанд солино.

7.6. Цус шүүх, цэвэршүүлэх эмчилгээнд нэг удаагаар хэрэглэгдэх багаж хэрэгслийг хэрэглэсэн даруйд устгана.

7.7. Тарилгын аюулгүй байдал алдагдахаас сэргийлж олон туншил эм биобэлдмэлийг хэрэглэх явцад бохирдуулахаас сэргийлэх, аль болох нэг удаагийн туншил бүхий эм биобэлдмэлийг хэрэглэх, эм биобэлдмэлийн таглааг спиртээр халдваргүйжүүлсний дараа зүүг хатгах, ариун зүү тариурыг нэг удаагаар хэрэглэнэ.

7.8. Үйлчлүүлэгчийн дархлаажуулалтын байдал, дархлалын түвшинг тодорхойлж түүхэнд тэмдэглэнэ. Эмчилгээ эхлэхийн өмнө В, С вируст гепатит, ХДХВ, ванкомицинд тэсвэртэй энтерококк, метициллинд тэсвэртэй стафилококкын халдвар

илрүүлэх шинжилгээнд хамруулах, В вируст гепатитын эсрэг дархлаажуулалт хийлгээгүй, эсвэл хийлгэсэн боловч Anti-HBs –ийн титрийн хэмжээ <10 mIU/ml тохиолдолд В вируст гепатитын эсрэг вакцинаар дархлаажуулна.

7.9. С Вируст гепатит илрүүлэх шинжилгээг 6 сард 1 удаа, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдварыг илрүүлэх шинжилгээнд хамруулна.

7.10. Диализын усанд хамгийн багадаа сард нэг удаа хяналт тавина. Диализын усанд хор бодис (Endotoxin) 2 EU/ml –аас бага, нянгийн тоо 200 CFU/ml –ээс ихгүй байна.

7.11. Эрүүл мэндийн ажилтнуудад диализтай үйлчлүүлэгчийн халдварын эрсдэлт хүчин зүйл, эсрэг заалт, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээний талаар сургалт хийнэ.

**Найм. Халдвартай эх, нярайд тусламж үзүүлэх үеийн халдвараас сэргийлэх арга хэмжээ**

| | Халдвар | Авах арга хэмжээ |
|---|---|---|
| 1 | Эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай эх, нярай (VRE, MRSA ) | • Тусгаарлана. Нярайн тасаг тусдаа бол бусад нярайгаас 2 метрээс багагүй зайд тусгаарлана.<br>• Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө |
| 2 | Салхинцэцэг | • Тусгаарлана.<br>• Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Эхэд төрөхөөс 5 хоногийн өмнө, төрсний дараа 48 цагийн дотор эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн бол нярайд Варцелло зостерийн иммуноглобулин (VZIG) тарина.<br>• Нярайг хөхөөр хооллохыг зөвшөөрнө<br>• Эх нь салхинцэцгийн халдвартай нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй<br>• Нярай салхинцэцгийн халдвартай үед ээж дархлаатай бол эх, нярайг хамт байхыг зөвшөөрнө<br>• Дархлаатай эрүүл мэндийн ажилтан тусламж үзүүлнэ. |
| 3 | Аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэл | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Алчуур, самбай, асаргаа, сувилгааны хэрэгслийг хамт хэрэглэхгүй<br>• Эх нь аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэлтэй нярай эрчимт эмчилгээ хийлгэж байгаа бол эхтэй нь хамт байлгахгүй, сүүг сааж хэрэглэнэ.<br>• Нярай аденовирусээр үүсгэгдсэн нүдний салстын үрэвсэлтэй, эх эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. |
| 3 | Суулгалт | • Ариун цэврийн өрөөтэй өрөөнд тусгаарлана.<br>• Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ |

| | | |
|---|---|---|
| | (Нян, вирус, C. difficile –р үүсгэгдсэн) | • Эх нь суулгалттай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилснаас хойш 48 цаг хүртэл нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн эхтэй хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярай суулгалттай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярайг хуурайлах, өлгийдөх бүрт хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн ажиллана |
| 4 | Энтеровирусийн халдвар | • Тусгаарлана.<br>• Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Эх нь энтеровирусийн халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилах хүртэл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ.Нярай эрүүл бол хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлэн эхтэй хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярай энтеровирусийн халдвартай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө |
| 5 | Эх вируст гепатит А-ийн халдвартай | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Нярайд иммуноглобулин хийнэ<br>• Эх, нярайг хавьтал болох, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. |
| 6 | Энгийн херпес | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Нярайд шинж тэмдэггүй хэлбэрийг илрүүлэх үзлэг хийнэ<br>• Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө<br>• Хөхний толгой дээр байрлалтай бол хөх хөхүүлэхгүй цэврүүг хагалахгүйгээр сааж хэрэглэнэ.<br>• Ам, уруулын салст дээр байрлалтай бол нярайг үнсэхийг хориглоно. |
| 7 | Тархмал хэлбэрийн Херпес зостерийн халдвар | • Тусгаарлана.<br>• Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Эх нь херпес зостерийн халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эхийн эмнэлзүйн шинж тэмдэг арилах хүртэл эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. |
| 8 | Томуу болон амьсгалын замын вирусийн халдвар | • Тусгаарлана.<br>• Агаар дусал, хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Эх халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол эх мэс заслын амны хаалт зүүж хамт байхыг зөвшөөрнө.<br>• Нярайд хүрэхдээ гарын эрүүл ахуйг сахина. |

| | | |
|---|---|---|
| | | • Нярай халдвартай, эх нь эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө |
| 9 | Улаанбурхан | • Тусгаарлана<br>• Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Улаан бурхны дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана.<br>• Нярайд иммуноглобулиныг зааврын дагуу хэрэглэнэ.<br>• Эх нь халдвартай нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед тууралт гарснаас хойш 4 өдөр өнгөртөл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярай халдвартай үед эх дархлаатай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө<br>• Нярай халдвартай, эх халдварын сэжигтэй байгаа бол нууц үеийн хугацаа дуустал хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй |
| 10 | Менингит (Neisseria meningitidis, haemophilus influenzae) | • Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс хойш 24 цаг хүртэл хугацаанд тусгаарлана.<br>• Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс 24 цагаас хойш эх, нярайг хамт байх, хөхөөр хооллох эсэхийг шийдвэрлэнэ. |
| 11 | Гахай хавдар | • Тусгаарлана<br>• Дусал, хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Гахай хавдрын дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана.<br>• Эх нь халдвартай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед паротит эхэлснээс 9 өдөр хүртэл эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө<br>• Нярай халдвартай, эх нь дархлаатай бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. Эхэд халдварын сэжиг байгаа бол сүүг сааж хэрэглэнэ. |
| 12 | Хөхүүл ханиад | • Тусгаарлана<br>• Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Эх нь хөхүүл ханиадтай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед нянгийн эсрэг бэлдмэлээр сэргийлэлт хийж 5 өдөр болтол эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. Нярайд 2 м-ээс дотогш зайд ойртох, хүрэх бол эх мэс заслын амны хаалт, гарын эрүүл ахуйг сахина.<br>• Нярай нь хөхүүл ханиадтай, эх эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө |

| | | |
|---|---|---|
| 13 | Улаанууд | • Тусгаарлана.<br>• Дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтан ажиллана.<br>• Эх улаануудтай, нярай эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа үед тууралт гарснаас хойш 7 өдөр болтол эх, нярайг хавьтал болохыг зөвшөөрөхгүй, сүүг сааж хэрэглэнэ. Нярай эрүүл бол хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярай улаануудтай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө |
| 14 | А бүлгийн стрептококкийн халдвар | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Нянгийн эсрэг эмчилгээ эхэлснээс хойш 24 цаг хүртэл хугацаанд тусгаарлана. Эмчилгээний үр дүнг харгалзана<br>• Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. |
| 15 | Тэмбүү | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ<br>• Эх тэмбүүтэй бол эмчилгээ эхэлснээс 24 цагийн дараагаас хөхөөр хооллох, эх, нярай хамт байхыг зөвшөөрнө<br>• Төрөлхийн тэмбүүтэй нярайг эхтэй нь хамт байлгах, хөхөөр хооллохыг зөвшөөрнө. |
| 16 | Халдвартай хэлбэрийн сүрьеэ | • Тусгаарлана.<br>• Агаар дуслын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Халдвартай үеийг дуустал эх, нярайг хамт байхыг зөвшөөрөхгүй<br>• Сүүг сааж хэрэглэх боломжтой. |
| 17 | ХДХВ, ДОХ | • Эх, нярайг хамт байхыг зөвшөөрнө.<br>• Хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй. |
| 18 | Цитомегаловирусын халдвартай | • Тусгаарлана.<br>• Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ.<br>• Эх цитомегаловирусын халдвартай бол хөхөөр хооллохыг зөвшөөрөхгүй.<br>• Нярай цитомегаловирусын халдвартай бол эх, нярайг хамт байх, хөхөөр хоолохыг зөвшөөрнө.<br>• Вирус шээсээр их ялгардаг тул нярайн живхтэй солихдоо анхаарах |
| 19 | Эх вируст гепатит В-ийн халдвартай | • Эх, нярайг хамт байх, хөхөөр хооллохыг зөвшөөрнө.<br>• Нярайд 12 цагийн дотор вируст гепатит В-ийн эсрэг вакцин, иммуноглобулиныг тус тусад нь тарина.<br>• Нярайг цаашид дархлаажуулалтын хөтөлбөрийн дагуу вакцинжуулна.<br>• Товлолт вакцинд бүрэн хамрагдсаны дараа үр дүнг хянана.<br>• Эх В гепатитын архаг халдвартай бол төрөхөөс өмнө вирус дарангуйлах эмчилгээ хийлгэнэ. |
| 20 | Хамуу | • Хавьтлын замаар халдвар дамжихаас сэргийлнэ |

156

Эрүүл мэндийн сайдын 2014 оны .06
сарын 02 өдрийн 187 дугаар тушаалын
12 дугаар хавсралт

# ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТАД МИКРОБИОЛОГИЙН ЛАБОРАТОРИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү заавар нь ХСХ-д эрүүл мэндийн байгууллагын микробиологийн лабораторийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын микробиологийн лаборатори нь лабораторийн талаар гарсан тушаал, журам, заавар, стандартын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Лабораторийн үйл ажиллагаанд биоаюулгүй ажиллагаа, халдвараас сэргийлэх зааврыг дагаж мөрдөнө. Био-аюулгүйн кабинет болон лабораторид ашиглаж байгаа тоног төхөөрөмжид инженерийн хяналт, засвар үйлчилгээ хийнэ.

1.4. Лаборатори нь үйлчлүүлэгчийнн оношлогоо, тусламж үйлчилгээнд шаардлагатай нян судлал, эрүүл зүйн шинжилгээ хийх боломжтой байна.

1.5. Лабораторийн шинжилгээний чанарын баталгаа, сорьц хадгалах, тээвэрлэх нөхцлийг хангасан байна.

1.6. Микробиологийн лабораторийн үйл ажиллагаань 24 цагийн туршид тасралтгүй байхаар зохицуулагдсан байна. Үүнд: ээлжийн болон жижүүрийн лаборант ажиллуулах, нян судлалын эмч, лаборант дуудлагаар ажиллах гэх мэт.

1.7. Лаборатори нь өсгөврийн санг бүрдүүлж, баталгаажуулах ба лавлагаат шинжилгээг лавлагаа лабораториор болон лаборатори хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу гүйцэтгүүлнэ.

1.8. Микробиологийн лабораторигүй, зарим шинжилгээг өөрийн лабораторид хийж гүйцэтгэх боломжгүйтохиолдолд сорьц хадгалах, тээвэрлэх нөхцлийг бүрдүүлэн гэрээгээр гүйцэтгүүлж болно.

1.9. Шинжилгээнд илгээх сорьцыг аргачлалын дагуу зөв авч, зохих нөхцлийг бүрдүүлэн тээвэрлэнэ. Микробиологийн лабораторид илгээх сорьцны дагалдах бичигт сорьц авсан хугацаа, өвчний онош, эмчлэгч эмч, нянгийн эсрэг эмчилгээ хийгдсэн эсэх, зарим нэмэлт мэдээлэл (дархлаа дарангуйлагдсан гэх мэт) талаар мэдээлэл байх шаардлагатай.

1.10. Микробиологийн шинжилгээний хариуг урьдчилсан болон эцсийн байдлаар, бичгээр, цахим байдлаар, шаардлагатайтохиолдол(олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварууд, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай, цус, тархи нугасны шингэний өсгөврийн шинжилгээнд үүсгэгч илэрсэнгэх мэт)-д цаг алдалгүй яаралтай эмчлэгч эмч, ХСХ-ын баг/ажилтандамаар мэдэгдэнэ. Шинжилгээний хариуг урьдчилан мэдэгдсэн талаарбаримтжуулна.

1.11. Тархвар судлаач, эмчлэгч эмч, ХСХ-ын багийг шаардлагатай мэдээлэл, мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангана.

1.12. Лаборатори нь эмнэлзүйн тасгийн эмч, сувилагч нарт сорьц авах, хадгалах, тээвэрлэх, шинжилгээний дүнг үнэлэх чиглэлээр сургалт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.

**Хоёр. Микробиологийн лабораторийн оношлогооны үүрэг**

2.1. Эрүүл мэндийн байгууллага тусламж үйлчилгээний онцлогоос хамаарандоор дурдсан шинжилгээг хийнэ.

2.1.1. Наацын шинжилгээ:

2.1.1.1. Эмнэлзүйн сорьц болон нянгийн өсгөвөөс наац бэлтгэх

2.1.1.2. Грамын будгаар будахболон хүчилд тэсвэртэй нянг будах арга

2.1.2. Өсгөвөрлөх шинжилгээ:

2.1.2.1. Цусны ариун чанарын шинжилгээ, тархи нугасны шингэн, шээс, баас, шарх, амьсгалын замын сорьцноос агаартан болон агааргүйтэн нян, мөөг өсгөвөрлөх

2.1.2.2. *Staphylococcusaureus, Escherichia coli,* А бүлгийн стрептококк, В бүлгийн стрептококк, энтерококк, *Streptococcus pneumoniae,Haemophilusinfluenzae, Neiserria meningitides, Neiserriagonorrhoeae, Salmonella, Shigella,Clostridiumdifficile,Pseudomonas aeruginosa, Klebsiellapneumoniae,*бусад энтеробактер, *Candida albicans*гэх мэт эмгэгтөрөгчийг зүйлийн түвшинд ялган дүйх

2.1.2.3. Нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг дискнээс нэвчүүлэх эсвэл шингэрүүлэх аргаар тодорхойлох

2.1.3. Дархлал судлалын шинжилгээ:

2.1.3.1. Эсрэг бие болон эсрэгтөрөгч илрүүлэх: Тэмбүү, ХДХВ, ГВВ, ГСВ, томуу, суулгалтат халдвар үүсгэдэг вирусын халдвар гэх мэт

2.1.3.2. түргэвчилсэн оношлуур, ФХУ болон бусад шинжилгээний арга

2.1.4. Молекул биологийн шинжилгээ:

2.1.4.1. Эмгэгтөрөгчийг илрүүлэх: ХДХВ, ГВВ, ГСВ, томуу, суулгалтат халдвар үүсгэдэг вирусын халдвар, эмэнд тэсвэртэй бактерийн халдваргэх мэт

2.1.4.2. Эмгэгтөрөгчийн генийн хэв шинжийг тогтоон харьцуулах

2.1.4.3. Полимеразын гинжин урвал, гибриджүүлэг болон бусад шинжилгээний арга

2.2. Микробиологийн лаборатори бүр өөрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай стандарт ажиллагааны заавар (САА)-ийг холбогдох удирдамж, зааварт нийцүүлэн боловсруулж шинжилгээг гүйцэтгэнэ.

2.2.1. Сорьц авах, хадгалах, тээвэрлэх

2.2.2. Наацын шинжилгээ хийх

2.2.3. Тэжээлт орчин болон ялган дүйлтийн орчны

2.2.4. Чанарын хяналтын (гадаад, дотоод)

2.2.5. Нян судлалын шинжилгээний(цус, тархи нугасны шингэн, цэр, шархны арчдас, шээс, баасны шинжилгээ гэх мэт)

2.2.6. Нянгийн биохимийн ялган дүйлтийнСАА, бүлэг тус бүрээр(Грам эерэг каталаз эерэг кокк, Грам эерэг каталаз сөрөг кокк, Грам сөрөг кокк, Грам сөрөг оксидаза эерэг савханцар, Грам сөрөг оксидаз сөрөг савханцар гэх мэт)

2.2.7. Нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээнийСАА, бүлэг тус бүрээр(Грам эерэг каталаз эерэг кокк, Грам эерэг каталаз сөрөг кокк, Грам сөрөг кокк, Грам сөрөг оксидаза эерэг савханцар, Грам сөрөг оксидаз сөрөг савханцар гэх мэт)

2.2.8. Идэвхтэй илрүүлэг шинжилгээ

2.2.9. Эрүүл зүйн шинжилгээ

2.2.10. Баталгаажуулах, лавлагаа шинжилгээнд илгээх сорьц, нянгийн омгийг хадгалах, тээвэрлэх

2.2.11. бусад (дархлал судлал, молекул биологийн шинжилгээний гэх мэт)

2.3. Нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээг стандарт аргачлалыг дагаж хийнэ.

## Гурав. Микробиологийн лабораторийн тандалтын үүрэг

3.1. Эрүүл мэндийн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан доор дурдсан чиглэлээр лабораторийн оролцоотой тандалт хийнэ.

3.3.1. ЭТҮХХ-ын төрлөөр: үжил халдвар, шээс ялгаруулах замын халдвар, амьсгалын доод замын халдвар, арьс, зөөлөн эдийн үрэвсэл халдвар гэх мэт

3.3.2. Эмгэгтөрөгчөөр: *Streptococcus spp., Staphylococcus aureus,Enterococcispp., Escherichia coli, Klebsiellapneumoniae, Pseudomonas aeruginosa, Acinetobacter spp.*гэх мэт

3.3.3. Эрсдэл бүхий тасаг нэгжээр: мэс засал, эрчимт эмчилгээний тасаг (насанд хүрэгсэд болон нярай), хавдрын, цусны эмгэгийн, бөөрний (диалезийн), эрхтэн шилжүүлэн суулгах тасаг гэх мэт

3.3.4. Эрсдэл бүхий өвчтөний бүлгээр: хавдар, цусны эмгэгтэй, чихрийн шижин өвчтэй гэх мэт

3.2. Лаборатори нь өдөр тутамын үйл ажиллагааны явцад шинжилгээний үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж, түүнийг үндэслэн “сэрэмжлүүлэх” нянгийн жагсаалтыг гаргана.

3.3. Нян судлалын шинжилгээгээр доор дурдсан “сэрэмжлүүлэх” нян илэрсэн тохиолдолд ХСХ-ын баг, эмчлэгч эмчид мэдэгдэнэ.

- Пенициллиндтэсвэртэй А бүлгийн *Streptococcus*,
- пенициллиндтэсвэртэй В бүлгийн *Streptococcus*,
- пенициллиндтэсвэртэй С бүлгийн *Streptococcus*,
- флюклоксацин, эритромицин, тетрациклинтэсвэртэй, метициллинд мэдрэг*Staphylococcus aureus*(MSSA),
- Ванкомицинтэсвэртэй*Staphylococcus aureus*

- МетициллинтэсвэртэйStaphylococcus aureus
- ВанкомицинтэсвэртэйEnterococcus faecalis,
- ВанкомицинтэсвэртэйEnterococcus faecium,
- имипенем/меропенемтэсвэртэй/карбапенемазялгаруулдагKlebsiellapneumoniae,
- имипенем/меропенем тэсвэртэйкарбапенемазялгаруулдаг/тигециклинтэсвэртэйEscherichia coli,
- имипенем/меропенемтэсвэртэйAcinetobacterspp.
- имипенем/меропенемтэсвэртэйPseudomonas spp.
- Олон эмэнд тэсвэртэй Грам сөрөг нян (гурав болон түүнээс дээш тооны нянгийн эсрэг эмийн бүлэгт тэсвэртэй)
- амоксиклав/ко-амоксиклав/ тетрациклинтэсвэртэйHaemophilusinfluenzae,
- пенициллин/тетрациклин/эритромицинтэсвэртэйStreptococcus pneumoniae,
- Бусад

3.4. Микробиологийн лаборатори ньнянгийн эсрэг эмийн тэсвэржилтийн байдлыг сар, улирал, жил тутам болон шаардлагатай тохиолдол бүрт мэдээлнэ.

3.5. Лаборатори микробиологийн шинжилгээний зориулалтын программ хангамж (WHONETгэхмэт)-ыг өдөр тутмын практик үйл ажиллагаанд ашиглана.

## Дөрөв. ЭТҮХХ-ын дэгдэлтийн үед микробиологи лабораторийн гүйцэтгэх үүрэг

4.1. Микробиологийн лаборатори нь дараах тохиолдлыг эмчлэгч эмч болон ХСХ-ийн баг/халдвар судлаачид шуурхай мэдэгдэхүүрэгтэй.

4.1.1. Нэг ижил фенотип бүхий нян 2 буюу түүнээс дээшүйлчлүүлэгчээс нэг цаг хугацаанд зэрэг илрэх эсвэл тодорхой хугацааны туршид тасаг нэгжид үргэлжлэн илрэх

4.1.2. Сэрэмжлүүлэх шаардлагатай нянгийн халдварын тохиолдол илрэх

4.1.3. Шинэ төрлийн, ховор тохиолдох нянгийн халдвар илрэх гэх мэт

4.2. Эрүүл мэндийн байгууллагын микробиологийн лаборатори нь ЭТҮХХ-ын дэгдэлтийн үед доор дурдсан шинжилгээг хийж халдварт өртсөн үйлчлүүлэгч, халдварын голомтыг олж илрүүлэх, голомтыг баталгаажуулах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

4.2.1. Үүсгэгчийг илрүүлэх, нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээ

4.2.2. Халдвар авсан боловч шинж тэмдэг илрээгүй байгаа үйлчлүүлэгчийнг илрүүлэх идэвхтэй илрүүлэг шинжилгээ

4.2.3. Эрүүл зүйн шинжилгээ

4.2.4. Шаардлагатай тохиолдолд нэмэлт шинжилгээ(диализын болон дуслын шингэний бохирдлыг шалгах, дэгдэлтийн үед эрүүл мэндийн ажилтанд үүсгэгч илрүүлэх илрүүлэг шинжилгээ хийх, ариутгал, халдваргүйжүүлэлтийн чанар шалгах, халдваргүйжүүлэх бодисын идэвх шалгах гэх мэт)хийнэ.

4.3. Эрүүл мэндийн байгууллагын микробиологийн лаборатори нь ЭТҮХХ-ын дэгдэлтийн үед ХСХ-ын баг/ажилтан, эмнэлзүйн эмч, бусад мэргэжилтэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, дэгдэлтийн үед болон дараа эрүүл мэндийн ажиллагсдыг сургах үйл ажиллагаанд оролцоно.

4.4. ЭТҮХХ-ын дэгдэлтийн үүсгэгчийг фенотипийн түвшин (нянгийн төрөл зүйл, нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанар гэх мэт)-д харьцуулан судлаж, шаардлагатай тохиолдолд генийн түвшний шинжилгээ хийх лабораторид илгээж, нэг голомтын халдвар мөн эсэхийг баталгаажуулна.

4.5. Дараах тохиолдлыг генийн түвшинд заавал баталгаажуулах шаардлагатай. Үүнд:

4.5.1. Идэвхтэй илрүүлэг шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн дэгдэлтийн үүсгэгчтэй ижил төрөл зүйлд хамаарах, ижил фенотип бүхий нянгийн омог

4.5.2. Хүний хэвийн бичил биетэнд хамаарагддаг үүсгэгч (*E.coli, K. pneumoniae*гэх мэт)-ээр ЭТҮХХ-ын дэгдэлт үүсгэгдсэн тохиолдолд

4.5.3. Цаг хугацааны хувьд ялгаатай ч дэгдэлтийн үүсгэгчтэй фенотипийн хувьд ижил, нэг голомтын байж болохуйц халдвар илэрсэн тохиолдолд дэгдэлт шинээр гарсан болон өмнөх дэгдэлт үргэлжилсээр байгаа тохиолдолд

4.6. Дэгдэлтийн үед сорьц (ийлдэс, цус, арчдас гэх мэт), нянгийн өсгөврийг нэмэлт шинжилгээнд зориулан хадгалах шаардлагатай.

4.7. Дэгдэлтийн үед хийгдэх нэмэлт шинжилгээг лавлагаа лабораториор болон лаборатори хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу шийдвэрлэнэ.

## Тав. Идэвхитэй илрүүлэг шинжилгээ

5.1. Идэвхитэй илрүүлэг шинжилгээ нь ЭТҮХХ-аас сэргийлэх, хянах, ЭТҮХХ-ийн дэгдэлтийн үед авах арга хэмжээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

5.2. ЭТҮХХ-ын дэгдэлтэд өртсөн байх эрсдэл бүхий бүх үйлчлүүлэгч, эрүүл мэндийн ажилтанд үүсгэгчийг илрүүлэх идэвхтэй илрүүлэг шинжилгээ хийнэ.

5.3. Дэгдэлтийн бус үед идэвхтэй илрүүлэг шинжилгээгээр илрүүлэх эмгэгтөрөгч, шинжилгээнд хамруулах тасаг, эрсдэл бүхий үйлчлүүлэгч, илрүүлэг шинжилгээ хийх давтамж (үйлчлүүлэгч бүрийг, дэгдэлтийг үед гэх мэт) зэргийг тухайн эрүүл мэндийн байгууллагын онцлог, чадамжид тохируулан ХСХ-ийн багаар хэлэлцэн батлана.

5.4. Илрүүлэг шинжилгээнд зарцуулагдах төсөв хөрөнгө, ажиллах хүчний асуудлыг байгууллагын хүрээнд шийдвэрлэсэн байна.

5.5. Илрүүлэг шинжилгээний үр дүнг ХСХ-ын баг, эмчлэгч эмчид мэдэгдэнэ.

5.6. Өсгөвөрлөгдсөн бактерийн омгийг өсгөврийн санд хадгалах ба илрүүлэг шинжилгээгээр өсгөвөрлөгдсөн бактерийн омог нь дэгдэлтийн үүсгэгчтэй ижил эсэхийг баталгаажуулна.

5.7. Идэвхитэй илрүүлэг шинжилгээгээр халдвартай эсвэл тээгч болох нь тогтоогдсон тохиолдолд үүсгэгчийн төрлөөс хамааруулан халдвараас сэргийлэх арга хэмжээ авна.

## Зургаа. Эрүүл зүйн урьдчилан сэргийлэх шинжилгээ

6.1. Эрүүл мэндийн байгууллагад дэгдэлтийн бус үед эрүүл зүй, урьдчилан сэргийлэх шинжилгээг бүх тасаг нэгжийг хамруулан хийх шаардлагагүй, зөвхөн эрсдэл бүхий тасаг нэгжид тодорхой давтамжтайгаар хийнэ.

6.2. Эрүүл зүйн урьдчилан сэргийлэх шинжилгээнд:

- Ариутгалын чанарыг хянах шинжилгээ,
- Эмнэлгийн орчны агаарын шинжилгээ
- Орчны эд зүйлсийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үр дүнг хянах,
- Эмнэлгийн ажилтныг хамруулсан идэвхтэйилрүүлэгшинжилгээ
- Эрүүл мэндийн байгууллагын усны шинжилгээ
- Эрүүл мэндийн байгууллагын хүнсний шинжилгээ
- Ариутгал, халдваргүйтгэлийн бодисын идэвхийг тодорхойлох, бохирдлыг шалгах шинжилгээ зэргийг хамруулан ойлгоно.

6.3. Эрүүл зүйн урьдчилан сэргийлэх шинжилгээг дараах тохиолдолд тодорхой давтамжтай хийнэ. Үүнд:

6.3.1. Ариутгалын чанарыг шалгах

6.3.2. Гемодиализын тасагт хийгдэх усны шинжилгээ

6.3.3. Эрсдэлтэй тасаг нэгж(цусны хавдартай, дархлаа султай үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж буй тасаг нэгж, мэс заслын өрөө, ариун өрөө, дутуу нярай болон нярайн эрчимт эмчилгээний өрөө, эмийн сан)-ийн агаарын болон орчны эд зүйлсийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үр дүнг хянах шинжилгээ

6.3.4. Агааржуулалтын системийн засвар үйлчилгээний хүрээнд хийгдэх шинжилгээ (фильтрийн нянгийн бохирдлын шинжилгээ)

6.4. ЭТҮХХ-ын дэгдэлтийн үед, эрсдэлийг тогтоох, судалгааны болон халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээний үр дүнг үнэлэх зорилгоор эрүүл зүйн урьдчилан сэргийлэх нян судлалын шинжилгээг хийнэ.

6.5. Эрүүл зүйн урьдчилан сэргийлэх шинжилгээгээр өсгөвөрлөсөн үүсгэгчийг

6.5.1. Зүйлийн түвшинд зайлшгүй дүйнэ.

6.5.2. Лабораторийн өсгөврийн санд хадгална.

6.5.3. Үйлчлүүлэгчээс өсгөвөрлөсөн дэгдэлтийн үүсгэгчтэй фенотип болон генотипийн түвшинд харьцуулан судалж дүгнэлт гаргана.

6.6. Ариутгалын чанарыг хими, биологийн индикатор ашиглан хянахаас гадна ариун материалаас нян судлалын шинжилгээ авч ариутгалын үр дүнг шалгана.

6.6.1. Ариутгалын чанарыг шалгах нян судлалын шинжилгээгээр ариун материал, багаж хэрэгсэл нянгийн бохирдолгүй байна.

6.7. Эрүүл мэндийн байгууллага ХСХ-ын үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хянах, сайжруулах, эрсдэлийн үнэлгээ хийх, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үр дүнг хянах зорилгоор орчны эд зүйлд эрүүл зүйн шинжилгээ хийнэ.

6.7.1. Шинжилгээг өсгөврийн шинжилгээ, тэжээлт орчин бүхий түргэвчилсэн оношлуур (туузан, цаасан, шилэн хавтан зэрэг), флюресцент оношлуур, АТФ-биолюминисцент аргуудаар холбогдох стандартын дагуу гүйцэтгэнэ.

6.7.2. Тухайн байгууллага ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хянах зорилгоор орчны эрүүл зүйн шинжилгээ хийж байгаа тохиолдолд нийт тасаг нэгжийг төлөөлж чадахуйц тасаг нэгжийг хамруулж, хангалттай тооны сорьцавсан байна (150 ортой эмнэлэгт нийт тасгийн 10-15%-ийг, 150-аас цөөн ортой эмнэлэгт 15-аас цөөнгүй тасгийг хамруулна.).

6.7.3. Сорьцыг тасгийн бохирдлын өндөр эрсдэлтэй гадаргуугийн хэсэг(тарианы ширээ, үйлчлүүлэгчийн ор, утас, дуудлагын болон гэрлийн товчлуур, хаалганы бариул, үйлчлүүлэгчийн шүүгээ, сандал, дуслын тогтоогуур гэх мэт), ариун цэврийн өрөө(хаалганы дотор бариул, гэрлийн товчлуур, суултуурын хажуугийн ханын бариул, суултуурын товчлуур, суултуурын угаагч гэх мэт), багаж тоног төхөөрөмж(дуслын шахуурга, хяналтын самбарын товчлуур, хяналтын самбарын мэдрэгчтэй дэлгэц, кабель, амьсгалын аппарат гэх мэт)-ийн гадаргуугийн хэсгүүдийг хамруулан үнэлж дүгнэнэ.

6.7.4. Гадаргуугийн бохирдлыг үнэлэхэд 10х10 см хэмжээтэй гадаргуугаас сорьц авах ба зорилгоос хамааран тоо ба чанарын үзүүлэлтээр гаргана.

6.7.5. Шинжилгээ авах гадаргууд халдваргүйтгэлийн бодисын үлдэгдэл байгаа тохиолдолд зохих саармагжуулах уусмалыг ашиглах шаардлагатай.

6.8. Даавуун эд зүйлсээс эрүүл зүйн шинжилгээ хийх шаардлагагүй, зөвхөн халдварын дэгдэлтийн үед эх уурхайг илрүүлэх зорилгоор хийнэ.

6.9. Агаарын эрүүл зүйн шинжилгээнд сорьц цуглуулахад агаарын шинжилгээний зориулалтын багаж(air sampler) ашиглана. Тунадасжуулах аргыг энгийн тасаг, эм найруулах хэсэг зэрэг хэсэгт хэрэглэж болно. Нянгийн бохирдол бага байхуйц өрөө тасалгаа(ариун өрөө, мэс заслын өрөө гэх мэт)-ны агаарын эрүүл зүйн шинжилгээнд их багтаамжтай агаарын шинжилгээний багажийг хэрэглэнэ.

6.10. Агаарын эрүүл зүйн шинжилгээний хүрээнд мөөгний спор илрүүлэх шинжилгээ хийж буй тохиолдолд тунадасжуулах арга хэрэглэхгүй.

6.11. Шинжилгээний үр дүнд агаарын бохирдол нөлөөлж болохуйц биологийн сорьцтой ажилладаг лаборатори(микробиологи, молекул биологи гэх мэт)-д агаарын бохирдлын хянах шаардлагатай ба агаарын бохирдлыг хянахад тунадасжуулах аргыг ашиглаж болно.

6.12. Эрүүл мэндийн байгууллага нь тасаг, нэгжийн агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа тохиолдолд

6.12.1. ХСХ-ын баг/ажилтанд мэдэгдэнэ.

6.12.2. Шинжилгээ зөв хийгдсэн эсэхийг баталгаажуулна. Шинжилгээг давтана.

6.12.3. Агааржуулалтын системийн үйл ажиллагааг шалгана.

6.12.4. Мэс заслын тасагт агаарын бохирдол үл зөвшөөрөх хязгаараас хэтэрсэн тохиолдолд мэс засал хийхийг хориглоно.

6.12.5. Шалтгааныг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

6.13. Эрүүл мэндийн байгууллагын агаарын шинжилгээний үр дүнг дүгнэхдээ:

6.13.1. Өрөөний доторх агаарын урсгал, хүний хөл хөдөлгөөн, агаарын хэм, цаг хугацаа, агаарын чиигшил, нянгийн бохирдлыг зэрэг, шинжилгээ хийж буй аргачлал зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

6.13.2. Үүсгэгчийг зүйлийн түвшинд зайлшгүй, шаардлагатай тохиолдолд генийн түвшинд ялган дүйж, үйлчлүүлэгчээс өсгөвөрлөсөн үүсгэгчтэй харьцуулан баталгаажуулах шаардлагатай.

6.13.3. Тоосонцрын хэмжээ халдварлах байдалд нөлөөлдөг тул агаарын тоосонцрын хэмжээг тодорхойлж, дүгнэлт гаргахад харгалзан үзэх (<5 мкм тоосонцор уушгинд хүрэх чадвартай, 1-2 мкм хэмжээтэй тохиолдолд уушгины альвеолд үлдэх боломж өндөртэй)шаардлагатай.

6.14. Усны эрүүл зүйн шинжилгээгээр усны бохирдлын ерөнхий үзүүллэлт (колиформ, *E.coli,* агаартан нянгийн тоо гэх мэт), усаар дамжин халдварладаг эмгэг төрөгчид (*Legionella* spp., *Aeromonas*spp, *Pseudomonas* spp., and *Acinetobacter*spp.)-ийг өсгөвөрлөх шинжилгээ, эндотоксин илрүүлэх шинжилгээ, химийн бохирдлын тодорхойлно.

6.14.1. Шинжилгээг гемодиализ эмчилгээний тасагт тогтмол, бусад тасаг нэгжид засвар үйлчилгээний дараа эсвэл ХСХ-ын заалтааршаардлагатай тохиолдолд хийнэ.

6.14.2. Эндотоксин илрүүлэх шинжилгээнд сорьц авахдаа “pyrogen-free”шошготой, нэг удаагийн зөөврийн саванд авна. Нян судлалын шинжилгээнд ариун саванд сорьц авна.

6.14.3. Усны шинжилгээнд сорьц авах, шинжилгээ хийхэд холбогдох стандартыг дагаж мөрдөнө.

6.15. Эрүүл мэндийн байгууллага хүнс үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч байгууллагатай гэрээтэй бол хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг холбогдох стандартад нийцсэн байхыг шаардана. Хэрэв өөрийн байгууллагад хоол хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэх хоолны газартай бол хүнсний бүтээгдэхүүний бохирдлын шинжилгээг холбогдох стандартын дагуу хийнэ.

6.15.1. Тогтмол давтамжтай хийгдэх шинжилгээний давтамжийг ХСХ-ын баг/ажилтан болон хоолны газартай зөвшилцөн тогтооно.

6.15.2. Хоол хүнсээр дамжин халдварладаг эмгэгийн дэгдэлтийн үед хийнэ.

**Долоо. Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээнд лабораторийн үүрэг**

6.16. Эмгэгтөрөгч нянгийн цэвэр өсгөвөр ялгаагүй, өсгөвөрлөгдсөн нян халдварын процесстой холбоогүй байж болох тохиолдолд (хэвийн бичил биетэн)нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тогтоох шинжилгээг хийх шаардлагагүй.

6.17. Эмийн бэлдмэлд мэдрэг чанарыг урьдчилан баримжаалах боломжтой зарим эмгэгтөрөгч (*Streptococcus pyogenes*-ийн пенициллиний мэдрэг чанар гэх мэт) –

ийн цэвэр өсгөврийгзүйлийн түвшинд ялган дүйсэн тохиолдолд нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тодорхойлолгүй стандартын дагуу нянгийн эсрэг эмчилгээг хийж болно.

6.18. Эрүүл мэндийн байгууллагын онцлогт тохируулан лаборатори тус бүр нянгийн эсрэг эмэнд мэдрэг чанарыг тодорхойлох шинжилгээ хийж эмнэлзүйн эмчид сонгон мэдээлэх, нэмэлт буюу нөөц эмийн жагсаалтыг халдвар хяналтын багийн бүрэлдэхүүнтэй зөвлөлдөн гаргана. Уг эмийн жагсаалтад тухайн эмнэлэгт голомтлон гарч буй олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар, зарим нэг өвөрмөц халдварын үед халдвар хяналт, тархвар судлалын үүднээс шинжлэх нянгийн эсрэг эмуудыг оруулна.

6.18.1. Антибиотикийн мэдрэг чанарыг өдөр тутам заавал тодорхойлох, мэдээлэх шаардлагатай нянгийн эсрэг эмийн нэр төрлийг нянгийн бүлэг тус бүрээр (Грам эерэг каталаз эерэг кокк, Грам эерэг каталаз сөрөг кокк, Грам сөрөг кокк, Грам сөрөг оксидаза эерэг савханцар, Грам сөрөг оксидаз сөрөг савханцар гэх мэт)

6.18.2. Нянгийн эсрэг эмийн мэдрэг чанарыг өдөр тутам тодорхойлж болох боловч “сонгон” мэдээлэх нянгийн эсрэг эмийн нэр төрөл, ямар тохиолдолд мэдээлэхийг нянгийн бүлэг тус бүрээр (Грам эерэг каталаз эерэг кокк, Грам эерэг каталаз сөрөг кокк, Грам сөрөг кокк, Грам сөрөг оксидаза эерэг савханцар, Грам сөрөг оксидаз сөрөг савханцар гэх мэт)

6.18.3. Шинжилгээ хийх болон мэдээлэх эмийн багцыг сонгоход эм тус бүрийн эмнэлзүйн үр нөлөө, тэсвэржилтийн тархалт болон үр дагавар, уг эмийг үнэ өртөг, эмчилгээнд хэрэглэх талаар мөрдөгдөж буй холбогдох заавар, удирдамж, тухайн эмнэлэгт хэрэглэгдэж буй эмийн эхний сонголт, нөөц эмийн нэр төрөл зэрэг хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

6.19. Шээс ялгаруулах эрхтэний халдварын эмчилгээнд хэрэглэдэг эмийн мэдрэг чанарыг шээс ялгаруулах замын халдварын үед л тодорхойлох шаардлагатай. Бусад тохиолдолд шинжлэхгүй.

6.20. Бүх төрлийн нянгийн эсрэг эмийн бэлдмэлийг үйлдвэрлэгчийн бус, олон улсын нэршлээр бичиж, хариуг мэдээлнэ.

6.21. Эмчлэгч эмчид шинжилгээний хариуг үндэслэн нянгийн эсрэг эм эмчилгээг сонгоход шаардлагатай мэдээллээр хангана. Үүнд: өвөрмөц тэсвэржилтийн механизм илэрсэн тохиолдолд эмчилгээний үр дүнгүй байх нянгийн эсрэг эмууд, мэдрэг чанарын шинжилгээний хариуг нь дүйцүүлэн дүгнэж болох нянгийн эсрэг эмууд гэх мэт.

6.22. Лаборатори нь нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээ бий болгох зорилгоор эрүүл мэндийн байгууллагын доор дурдсан үйл ажиллагаанд оролцоно. Үүнд:

6.22.1. Нянгийн эсрэг эмийн тэсвэржилтийн тандалт
6.22.2. Нянгийн эсрэг эмийн хэрэглээний тандалт
6.22.3. Жор бичилт (зөв эмийн сонголт, зөв тун, зөв үргэлжлэх хугацаа гэх мэт)
6.22.4. Нянгийн эсрэг эмийн хэрэглээг хянах, зохицуулах удирдамж заавар боловсруулан хэрэгжүүлэх
6.22.5. Аудит, хяналт үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагаанд оролцоно.

6.23. Эмэнд тэсвэртэй нянгийн тархалтын түвшнээс хамааран нянгийн эсрэг эмийн хэрэглээнд хяналт тавих зорилгоор ХСХ-ын баг доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

6.23.1. антибиотикийн хэт хэрэглээг хязгаарлана.

6.23.2. антибиотик хэрэглэх тун, үргэлжлэх хугацааг зохистой эсэхэд хяналт тавина.

6.23.3. өргөн хүрээний үйлдэлтэй антибиотик (фторхинолон, цефалоспорины III уламжлал гэх мэт)-ийн хэрэглээг хязгаарлана.

Хүснэгт 1.

Эрүүл мэндийн байгууллагын хүнсний нянгийн бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Үзүүлэлт | Шинжилгээний давтамж | Шинжилгээний хариу | Дүгнэлт | Авах арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| Бэлтгэж хөргөгчид хадгалсан бүтээгдэхүүн | | | | |
| Агаартан нянгийн тоо | Сард 1-ээс цөөнгүй шинжилнэ. Шинжилгээнд 100гр-аас багагүй хүнсний бүтээгдэхүүний дээж илгээнэ. | ≥100 000/гр<br><100 000/гр | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |
| *Salmonella* spp. | | Үүсгэгч илэрсэн*<br>Үүсгэгч илрээгүй* | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэхийг хориглоно. Шалтгааныг илрүүлнэ.<br>- |
| *E. coli* | | ≥10/гр<br><10/гр | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |
| *S.aureus* | | ≥100/гр<br><100/гр | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |
| *C.perfiringens* | | ≥100/гр<br><100/гр | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |
| *L.monocytogenes* | | Үүсгэгч илэрсэн*<br>Үүсгэгч илрээгүй* | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэхийг хориглоно. Шалтгааныг илрүүлнэ.<br>- |
| Бэлэн бүтээгдэхүүн | | | | |
| *L.monocytogenes* | Тухайн бүс нутгийн онцлогоос | Үүсгэгч илэрсэн*<br>Үүсгэгч илрээгүй* | Шаардлага хангаагүй (эрсдэлтэй үйлчлүүлэгчид) | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамаарна. | | Шаардлага хангасан | |
| Агаартан нянгийн тоо, *Enterobacteriacae, E.coli, S.aureus, Salmonells spp.,*<br><br>*C.perfringens*(мах махан бүтээгдэхүүн)<br><br>*B.cereus*болон бусад *Bacillus* (будаа, халуун ногоотой хүнсний бүтээгдэхүүн) | | Хүнсний бүтээгдэхүүний бохирдлыг үнэлэх холбогдох стандартын дагуу дүгнэнэ. | | |
| *- 25 гр хүнсний бүтээгдэхүүнд | | | | |
| Нярайн хоол тэжээл (6 сар хүртэл) | | | | |
| *B.cereus* | | >500/гр<br><br>≥50 - <500/гр<br><br><50/гр | Шаардлага хангаагүй<br><br>Эргэлзээтэй<br><br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br><br>- |
| *Enterobacteriacae,* | | Үүсгэгч илэрсэн**<br><br>Үүсгэгч илрээгүй** | Шаардлага хангаагүй<br><br>Шаардлага хангасан | Шалтгааныг илрүүлэн холбогдох арга хэмжээ авах<br>- |
| **- 10 гр хүнсний бүтээгдэхүүнд | | | | |

Хүснэгт 2.

Эрүүл мэндийн байгууллагын усны нянгийн бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Үзүүлэлт | Шинжилгээний давтамж | Шинжилгээний хариу | Дүгнэлт | Авах арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| *Legionella* | Эрсдэлийн үнэлгээний дүнд давтамжийг тодорхойлно. | >1000 күн/л | Шаардлага хангаагүй | Шинжилгээг давтах, яаралтай арга хэмжээ авах, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх, усан хангамжийн системийг халдваргүйтгэх, засвар үйлчилгээ хийх |
| | | ≥100 - <1000 күн/л | Анхаарах шаардлагатай | А.хэрэв 1-2 сорьцны бохирдол энэ хязгаарт байвал шинжилгээг давтах. Одоо хэрэгжүүлж буй арга хэмжээг хянаж үзэх, эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг тодорхойлох<br>Б. Хэрэв 3≤ тооны сорьц энэ хязгаарт бол усан хангамжийн систем бохирдолтой, бага хэмжээний бактерийн колонизаци байна гэж үзнэ. Халдваргүйтгэж болно. Эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлно. |
| | | <100 күн/л | Шаардлага хангасан | - |
| *P.aeruginosa* (бусад*Pseudomonas spp.*-ийг дэгдэлтийн үед өсгөвөрлөнө.) | Эрсдэлийн үнэлгээний дүнд давтамжийг тодорхойлно. | >10 | Шаардлага хангаагүй | Шалтгааныг тодорхойлж засах арга хэмжээ авна. 3 долоо хоногийн дараа шинжилгээг давтана. |
| | | 1-10 | Анхаарах шаардлагатай | Шинжилгээг давтана. Эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авна. |
| | | 0 (100мл тутамд) | Шаардлага хангасан | - |
| Бөөрний диалезийн шингэн болон диалезийн шингэн бэлтгэх ус | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Агаартан нянгийн тоо | Сар бүр, шаардлагатай тохиолдол бүрт | >100<br>>50-≤100/мл<br>0->50/мл | Шаардлага хангаагүй<br>Эргэлзээтэй<br>Шаардлага хангасан | Шаардлагатай арга хэмжээ авч хэвийн үзүүлэлтэд хүрэх хүртэл хэрэглэж болохгүй, Эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авна.<br>- |
| Эндотоксин/мл | | >0.03 ОУН/мл<br>≤0.03 ОУН/мл | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авна.<br>- |
| Дурангийн төгсгөлийн угаалга хийх ус | | | | |
| Агаартан нянгийн тоо | Долоо хоног тутам, шаардлагатай тохиолдол бүрт | >100<br>10-≤100<br>1-9<br>(тогтмол илэрвэл)<br><1<br>(100мл тутамд) | Үл зөвшөөрөх<br>Шаардлага хангаагүй<br>Зөвшөөрөх боломжтой*<br>Шаардлага хангасан | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, дуран угаагч багажийг хэрэглэхийг зогсоох (ялангуяа ариун биеийн хэсэгт хүрэлцдэг дурангийн угаалгад хэрэглэхийг хориглоно)<br>ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, дуран угаагч багажийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг сайжруулах, давтан хийх<br>Хэрэв *P.aeruginosa* илрээгүй бол зөвшөөрөх боломжтой*<br>- |
| Орчны микобактер | Улирал тутам, шаардлагатай тохиолдол бүрт | >0<br>(100мл тутамд)<br>0<br>(200мл тутамд) | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авна.<br>- |
| *P.aeruginosa* | Эрсдэлийн үнэлгээний дүнд давтамжийг тодорхойлно. | >0<br>0<br>(100мл тутамд) | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авна.<br>- |
| Эндотозсин | Тогтмол хийх шаардлагагүй | ≤30ОУН/мл | Шаардлага хангасан | >30ОУН/мл их үед ч эрсдэл багатай, нянгийн бохирдол их үед илэрнэ. |



169

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Шаардлагатай арга хэмжээг авна. |
| Шүдний тасаг | | | | |
| Агаартан нянгийн тоо ($22^0$с) | Шаардлагатай тохиолдол бүрт | >200 /мл | Шаардлага хангаагүй | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээг авна. |
| | | 100-200 /мл | Зөвшөөрөх боломжтой* | Хяналт зөв хийгдэж буй эсэхийг баталгаажуулах |
| | | <100 /мл | Шаардлага хангасан | - |
| EU (endotoxin unit)=IU (international unit) буюу ЭН (ЭндотоксинНэгж)=ОУН (ОлонУлсынНэгж)<br>күн-колони үүсгэх нэгж (cfu буюу colony forming unit) | | | | |

Хүснэгт 3.

Эрүүл мэндийн байгууллагын орчны гадаргуугийн бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Үзүүлэлт | Шинжилгээний давтамж | Шинжилгээний хариу | Дүгнэлт | Авах арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| Агаартан нянгийн тоо (хоолны газрыг оролцуулан) | Шаардлагатай тохиолдолд | >5 күн/см2 | Шаардлага хангаагүй | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээг авна. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн дадал, давтамж зэргийн онцгой анхаарна. |
| | | <5 күн/см2 | Шаардлага хангасан | |
| цэвэрлэгээний үр дүнг хянаж буй тохиолдолд | | >2.5 күн/см2 | Шаардлага хангаагүй | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээг авна. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн дадал, давтамж зэргийн онцгой анхаарна. |
| | | <2.5 күн/см2 | Шаардлага хангасан | |
| | | Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн чанарыг үнэлэх энгийн үнэлгээг тогтмол (өдөр бүр) хийх ба лабораторийн шинжилгээний үр дүнг дүгнэхэд энгийн үнэлгээний үр дүнг харгалзан үзнэ. | | |
| Индикатор организм (*S.aureus* (Метициллиндтэсвэртэй*S.aureus*-ийгоруулан), *C. difficile*, Ванкомициндтэсвэртэйэнтерококк, олонэмэндтэсвэртэйГрамсөрөгсавханцар) | Шаардлагатай тохиолдолд | >1 күн/см2 | Шаардлага хангаагүй | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээг авна. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн дадал, давтамж зэргийн онцгой анхаарна. |
| | | <1 күн/см2 | Шаардлага хангасан | |
| *Salmonella* spp. | Шаардлагатай тохиолдолд | Үүсгэгч илэрсэн* | Шаардлага хангаагүй | ХСХ-ын баг/ажилтантай зөвлөлдөх, эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Үүсгэгч илрээгүй* | Шаардлага хангасан | арга хэмжээг авна. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн дадал, давтамж зэргийн онцгой анхаарна.<br>- |
| Эм бэлтгэх байгууллага, эрүүл мэндийн байгууллагын эмийн сангийн орчны гадаргуугийн бохирдлыг дүгнэх үзүүлэлт | | | | |
| Агаартан нянгийн тоо | 7 хоног тутам | <50<br><25<br><5<br><1 | Шаардлага хангасан (D түвшин)<br>Шаардлага хангасан (C түвшин)<br>Шаардлага хангасан (B түвшин)<br>Шаардлага хангасан (A түвшин) | Зөвхөн эрсдэл багатай үйл ажиллагаа# хийхэд гадаргуугийн бохирдол үгүй гэж үзнэ. Гэвч бохирдлын шалтгааныг тодорхойлох судалгаа хийнэ.<br>Ажилбарын үед ариун дэглэм баримтлан багаж хэрэгсэл, эм, ороох боох материал зэргийг савлаж болно (aseptic preparation and filling)**<br>Эрсдэл өндөртэй үйл ажиллагаа* хийхийг зөвшөөрнө. |
| | | Дээр дурдсан хязгаарт багтахгүй тохиолдолд давтан шинжилгээний чиг хандлага, бохирдлын шинж чанар, болзошгүй үр дагавар зэргийг үнэлэн шаардлагатай арга хэмжээ авна. | | |
| Бээлийн болон хурууны дардасны шинжилгээний үзүүлэлт | | | | |
| Агаартан нянгийн тоо | А түвшингийн эрсдэлтэй хэсэгт тодорхой давтамжаар | ≥1 күн/гар<br><1 күн/гар | Шаардлага хангаагүй<br>Шаардлага хангасан | Давтан шинжилгээний чиг хандлага, бохирдлын шинж чанар, болзошгүй үр дагавар зэргийг үнэлэн шаардлагатай арга хэмжээ авна<br>- |

* А түвшин – эрсдэл өндөр үйл ажилбарыг гүйцэтгэдэг бүс (савлах хэсэг, ампул, тарианы шилийг онгойлгон ажиллах хэсэг, ариун байдлаар холих, найруулах хэсэг гэх мэт. Энэ хэсэгт ихэвчлэн зориулалтын сорох шүүгээ ашигласан байна.)

** В түвшин- орчны нянгийн бохирдол зөвшөөрөх хязгаарт байгаа үед ариун дэглэм баримтлан ажилбар гүйцэтгэх хэсэг. А түвшингийн бүс (сорох шүүгээ гэх мэт) буй орчин

#С болонD түвшин – ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцын эрсдэл багатай үе шатууд

күн-колони үүсгэх нэгж (cfu буюу colony forming unit)

Хүснэгт 4.

Эрүүл мэндийн байгууллагын агаарын бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Тасаг нэгж | Нийт тоо (к.ү.н/дм2/цаг) | | |
|---|---|---|---|
| | Ердийн | Зөвшөөрөх дээд хязгаар | Үл зөвшөөрөх хязгаар |
| Үйлчлүүлэгчийн өрөө | 0-450 | 451-750 | 750< |
| Мэс засал | 0-250 | 251-450 | 451< |
| Эмийн найруулах өрөө | 0-100 | 101-180 | 181< |
| Ариун өрөө | 0-50 | 51-90 | 91< |
| Мэс заслын ажилбарын өрөө (мэс ажилбарын бус үед) | 0-4 | 5-8 | 9< |
| Мэс заслын ажилбарын өрөө (мэс ажилбарын үед) | 0-60 | 61-90 | 91< |

Хүснэгт 5.

Эм бэлтгэх байгууллага, эрүүл мэндийн байгууллагын эмийн сангийн агаарын бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Үзүүлэлт | Шинжилгээний давтамж | Шинжилгээний хариу | Дүгнэлт | Авах арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| Агаартан нянгийн тоо | 7 хоног тутам, улирал тутам, болон хагас жил тутам (тунадасжуулах аргад 90 мм диаметртэй Петрийн аяга ашиглана, 4 цагийн хугацаанд тавьна) | <100 күн | Шаардлага хангасан (D түвшин) | Зөвхөн эрсдэл багатай үйл ажиллагаа# хийхэд гадаргуугийн бохирдол үгүй гэж үзнэ. Гэвч бохирдлын шалтгааныг тодорхойлох судалгаа хийнэ. |
| | | <50 күн | Шаардлага хангасан (C түвшин) | |
| | | <5 күн | Шаардлага хангасан (B түвшин) | Ажилбарын үед ариун дэглэм баримтлан багаж хэрэгсэл, эм, ороох боох материал зэргийг савлаж болно(aseptic preparation and filling)** |
| | | <1 күн | Шаардлага хангасан (A түвшин) | Эрсдэл өндөртэй үйл ажиллагаа* хийхийг зөвшөөрнө. |
| | | <200 күн/м$^3$ | Шаардлага хангасан (D түвшин) | Зөвхөн эрсдэл багатай үйл ажиллагаа# хийхэд гадаргуугийн бохирдол үгүй гэж үзнэ. Гэвч бохирдлын шалтгааныг тодорхойлох судалгаа хийнэ. |
| | | <100 күн/м$^3$ | Шаардлага хангасан (C түвшин) | |
| | | <10 күн/м$^3$ | Шаардлага хангасан (B түвшин) | Ажилбарын үед ариун дэглэм баримтлан багаж хэрэгсэл, эм, ороох боох материал зэргийг савлаж болно(aseptic preparation and filling)** |
| | | <1 күн/м$^3$ | Шаардлага хангасан (A түвшин) | Эрсдэл өндөртэй үйл ажиллагаа* хийхийг зөвшөөрнө. |
| | | Дээр дурдсан хязгаарт багтахгүй тохиолдолд давтан шинжилгээний чиг хандлага, бохирдлын шинж чанар, болзошгүй үр дагавар зэргийг үнэлэн шаардлагатай арга хэмжээ авна. | | |

* А түвшин – эрсдэл өндөр үйл ажилбарыг гүйцэтгэдэг бүс (савлах хэсэг, ампул, тарианы шилийг онгойлгон ажиллах хэсэг, ариун байдлаар холих, найруулах хэсэг гэх мэт. Энэ хэсэгт ихэвчлэн зориулалтын сорох шүүгээ ашигласан байна.)

** В түвшин- орчны нянгийн бохирдол зөвшөөрөх хязгаарт байгаа үед ариун дэглэм баримтлан ажилбар гүйцэтгэх хэсэг. А түвшингийн бүс (сорох шүүгээ гэх мэт) буй орчин

#С болонD түвшин – ариун бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцын эрсдэл багатай үе шатууд

күн-колони үүсгэх нэгж (cfu буюу colony forming unit)

Хүснэгт 6.

Эрүүл мэндийн байгууллагын биологийн сорьцтой ажилладаг лабораторийн агаарын бохирдлыг дүгнэх үзүүлэлт

| Үзүүлэлт | Шинжилгээний давтамж | Шинжилгээний хариу | Дүгнэлт | Авах арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| Агаартан нянгийн тоо | Давтамжийг лабораторийн онцлог, ажлын ачаалал зэргийг харгалзан үзэж тогтооно. (тунадасжуулах аргад 90 мм диаметртэй Петрийн аяга ашиглана, 4 цагийн хугацаанд тавьна) | 100 | Шаардлага хангасан (D түвшин) | Зөвхөн эрсдэл багатай үйл ажиллагаа# хийхэд гадаргуугийн бохирдол үгүй гэж үзнэ. Гэвч бохирдлын шалтгааныг тодорхойлох судалгаа хийнэ. |
| | | 50 | Шаардлага хангасан (C түвшин) | |
| | | 5 | Шаардлага хангасан (B түвшин) | Ажилбарын үед ариун дэглэм баримтлан багаж хэрэгсэл, эм, ороох боох материал зэргийг савлаж болно(aseptic preparation and filling)** |
| | | 1 | Шаардлага хангасан (A түвшин) | Эрсдэл өндөртэй үйл ажиллагаа* хийхийг зөвшөөрнө. |
| | | Дээр дурдсан хязгаарт багтахгүй тохиолдолд давтан шинжилгээний чиг хандлага, бохирдлын шинж чанар, болзошгүй үр дагавар зэргийг үнэлэн шаардлагатай арга хэмжээ авна. | | |

* А түвшин – эрсдэл өндөр үйл ажилбарыг гүйцэтгэдэг бүс (Энэ хэсэгт ихэвчлэн зориулалтын сорох шүүгээ ашигласан байна.)
** В түвшин- орчны нянгийн бохирдол зөвшөөрөх хязгаарт байгаа үед ариун дэглэм баримтлан ажилбар гүйцэтгэх хэсэг. А түвшингийн бүс (сорох шүүгээ гэх мэт) буй орчин
#С болонD түвшин –Эрсдэл багатай ажилбар хийх хэсэг

Маягт 1.

Нянгийн эсрэг эмийн тэсвэржилтийн дүнг мэдээлэх хуудас

Үүсгэгчийн нэр*: .....

| д/д | Нянгийн эсрэг эмийн нэр | Сорьцны төрөл ** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цус | | ТНШ | | Шарх | | Шээс | | .. | | ... | |
| | | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй |
| 1 | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | | |
| 11 | | | | | | | | | | | | | |
| 12 | | | | | | | | | | | | | |
| 13 | | | | | | | | | | | | | |
| 14 | | | | | | | | | | | | | |
| 15 | | | | | | | | | | | | | |
| 16 | | | | | | | | | | | | | |
| 17 | | | | | | | | | | | | | |
| 18 | | | | | | | | | | | | | |
| 19 | | | | | | | | | | | | | |
| 20 | | | | | | | | | | | | | |

Үүсгэгчийн нэр*: *Staphylococcus aureus*, *Escherichia coli*, *Pseudomonas aeruginosa*, *Salmonella spp*. зэрэг үүсгэгч тус бүрээр тэсвэржилтийн хувийг гаргана.



176

Сорьцны төрөл **: -Цус, тархи нугасны шингэн (ТНШ) зэрэг сорьц тус бүрээр тэсвэржилтийн хувийг гаргана.

Маягт 2.

## Нянгийн эсрэг эмийн тэсвэржилтийн дүнг мэдээлэх хуудас

Тасгийн нэр*: .....

| д/д | Нянгийн эсрэг эмийн нэр | Үүсгэгчийн нэр** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *S. aureus* | | *E. coli* | | ... | | ... | | ... | | ... | |
| | | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй | Нийт | Тэсвэртэй |
| 1 | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | | |
| 11 | | | | | | | | | | | | | |
| 12 | | | | | | | | | | | | | |
| 13 | | | | | | | | | | | | | |
| 14 | | | | | | | | | | | | | |
| 15 | | | | | | | | | | | | | |
| 16 | | | | | | | | | | | | | |
| 17 | | | | | | | | | | | | | |
| 18 | | | | | | | | | | | | | |
| 19 | | | | | | | | | | | | | |
| 20 | | | | | | | | | | | | | |

Тасгийн нэр*: Мэс засал, нярай, САТ зэрэг тасаг тус бүрээр тэсвэржилтийн хувийг гаргана.
Үүсгэгчийн нэр**: *Staphylococcus aureus*, *Escherichia coli*, *Pseudomonas aeruginosa*, *Salmonella spp.* зэрэг үүсгэгч тус бүрээр тэсвэржилтийн хувийг гаргана.